

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-53</i>
<hr/>	
<i>1. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх тайлан сонсох</i>	<i>3-36</i>
<i>2. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх тайлан сонсох</i>	<i>36-53</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 14 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ж.Эрдэнэбат;
Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Д.Батлут.*

Нэг. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга З.Баяр-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, “Монголын Хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, Зам, тээврийн хөгжлийн яамны Зам, ашиглалт засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, Авто замын засвар, арчлалт нэгтгэл компанийн гүйцэтгэх захирал Б.Наранбат, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирал С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2023 оны 03 дугаар тогтоолын 1, 2 дугаар заалтын хэрэгжилтийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн тогтоолын 3, 4 дүгээр заалтын хэрэгжилтийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул Уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Т.Энхтүвшин, Ж.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Г.Ганболд нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул Уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, “Монголын Хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, Зам, тээврийн хөгжлийн яамны Зам, ашиглалт засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, Авто замын засвар, арчлалт нэгтгэл компанийн гүйцэтгэх захирал Б.Наранбат, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Ашигт малтмал газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн захирал Д.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолыг хэрэгжилтийн тайланг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Ж.Батжаргал, Г.Ганболд нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Ашигт малтмал газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн захирал Д.Алтанцэцэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тайланг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 25 минут үргэлжилж, 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
11 цаг 14 минут

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Ганболд: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Г.Ганболд, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Ц.Туваан, Т.Энхтүвшин нар хүрэлцэн ирсэн байна. Бусад гишүүдийн хувьд тойрогт, орон нутагт томилолттой байгаа юм байна. Байнгын хорооны хуралдаанд олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны хуралдааны ирц 56.2 хувьд бүрдсэн тул Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолыг хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох.

Хоёр. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө баталлаа. Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газрын мэдээллийг сонсоно.

Уг тогтоолын 1, 2 дугаар заалтын хэрэгжилтийн талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, 2, 3 дугаар заалтын хэрэгжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул Уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр нар танилцуулга хийнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцох ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, З.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга, М.Мэндбаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Х.Алтай “Монголын Хөрөнгийн бирж” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, Ц.Эрдэнэ-Очир Зам, тээврийн хөгжлийн яамны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга, Б.Наранбат Авто замын засвар арчлалт нэгтгэл компанийн гүйцэтгэх захирал гэсэн хүмүүс оролцож байна.

Ингээд эхний тогтоолын 1, 2 дугаар заалттай холбогдуулаад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл мэдээлэл хийнэ.

Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг өгье. Ажлын хэсгийн 2 номер.

Б.Цэнгэл: Эрхэм Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2023 оны 04

сарын 11-ний өдрийн 03 дугаартай “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоол гарсан. Энэ тогтоолын 1 болон 2 дугаар заалт дээр “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах, засаглалыг сайжруулах зорилгоор хувьцааг нь олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг урт дунд хугацааны бодлогын баримтад нийцүүлэн боловсруулах гэсэн ийм эхний заалт байгаа.

2 дахь заалт нь хувьцаагаа нийтэд худалдсан төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийг шууд хяналтад оруулах ажлын хэрэгжилтийг хангах гэсэн ийм 1, 2 дугаар заалттай холбогдуулж Та бүхэнд мэдээлэл хийе.

Бид Та бүхнийхээ ажлыг хөнгөвчлөх зорилгоор гишүүдэд Байнгын хорооны ажлын албаар дамжуулаад нэлээд олон хуудас материалыг гишүүдэд хүргүүлсэн байгаа. Тийм учраас бид ерөнхийдөө товч байдлаар слайд дээр танилцуулга бэлдсэн байгаа. Үүнийгээ товч танилцуулчихъя. Сая би Их Хурлын тогтоолыг танилцуулсан.

Ингээд Их Хурлын баталсан үндсэн чиглэлийн дагуу бид Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-

2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг батлах тухай” Засгийн газрын тогтоол.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох шийдвэрүүд гарсан.

Энэ дээр нэр бүхий 26 аж ахуйн хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй олон нийтэд IPO гаргах ийм ажлыг зохион байгуулахаар заасан. Энэ дотор:

- Төрийн банк 20 хүртэл хувийг;
- Монголын хөрөнгийн бирж 34 хүртэл хувийг;
- Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн 34 хүртэл хувийг;
- Үндэсний давхар даатгал 34 хүртэл хувийг;
- Мэдээлэл холбооны сүлжээ төрийн өмчит хувьцаа компани 34 хүртэл хувийг;
- Мэдээлэл, технологийн үндэсний парк, авто зам арчлалтын төрийн мэдлийн 20 компани байгаа.

Энэ 20 компанийн мөн 34 хүртэлх хувийг олон нийтэд хөрөнгийн биржээр дамжуулж гаргах ийм жагсаалт гаргаад ажилласан. Үүний хэрэгжилтийн байдлыг бид хамгийн сүүлийн байдлаар Та бүхэнд танилцуулж байна. Энэ дээр бид ер нь энэ IPO гаргах ажил тодорхой цаг хугацаа ордог, нэлээн бэлтгэл шаарддаг ийм ажил байдаг. Эхлээд холбогдох судалгаа, урьдчилсан бэлтгэлийг хангана, ажлын төлөвлөгөөг нь гаргаж батална, зөвлөх үйлчилгээ хуулийн дагуу авна. Үнэт цаасны танилцуулга хийгддэг. Тэгээд эрх бүхий байгууллагаар бүртгэлийнх нь асуудал

орж шийдвэр гаргадаг. Үүний үндсэн дээр үнэт цаасыг олон нийтэд сурталчлах ажлууд хуулийн дагуу эхэлдэг. Хугацаатай. Үнэт цаасны арилжааны захиалга хүлээн авах, арилжааг зохион байгуулах гэсэн цаг хугацаатай ийм дэс дараалсан арга хэмжээнүүд авсны үндсэн дээр Монголын хөрөнгийн бирж дээр нийтэд зарлагдаж явсан. Төрийн банкныг Та бүхэн мэдэж байгаа. Төрийн банк нийтэд 5.71 хувиа санал болгож, нэмэлт хувьцаа гаргах асуудал амжилттай хийгдсэн. Энэ бол саяын миний хэлсэн бүх шат дамжлагаар яваад амжилттай зохион байгуулаад явж байна. Энэ цаашлаад 20 хүртэл хувь гэж байгаа. Энэ үе шаттай ингээд цаашаа явах байгаа юм.

Та бүхэн мэдэж байгаа. Их Хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Системийн 5 банк дээр энэ ажил хийгдээд явж байгаа. Дараагийн асуудал бол Монголын хөрөнгийн биржийг бид оны зааг дээр 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй гаргаж амжилттай арилжаалагдсан. Өнөөдөр тухайлбал манай Хөрөнгийн биржийн хувьцаа хоёр дахь зах зээл дээр гарчихсан явж байгаа. Хувьцааны тухайн үеийн нэрлэсэн хани тогтвортой, бууралтгүй явж байгааг Та бүхэнд танилцуулж байна. Үндэсний давхар даатгалын 20 хүртэлх хувь байж байгаа. Энэ бол эрх бүхий байгууллагын бүртгэл хийгдчихсэн. Энэ нь болохоор манай нэгж хувьцааны үнийг тогтоодог. Бас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хорооны хурлаар ороод энэ дээр үнийг нь тогтоочихсон байж байгаа. Үүнээс цаашлаад үнэт цаасаа олон нийтэд сурталчлаад үнэт цаасаа арилжаалан захиалга хүлээж аваад арилжаа зохион байгуулах ийм процесс явагдах ёстой. Засгийн газар дээр энэ байдал танилцуулагдчихсан байгаа. Энэ дээр зарим Засгийн газрын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гарсан учраас энэ асуудлуудад Засгийн газрын түвшинд ярилцаж байгаад энэ асуудлыг цааш нь явуулъя гэдэг ийм байр суурьтай байгааг Та бүхэнд танилцуулж байна. Монголын

цахилгаан холбоогийн хувьд бас хөрөнгийн бирж дээр өөрөө байдаг компани. Үүний 30.6 хувийг бид ярьж байгаа. Бас үнэт цаасны танилцуулга нь хийгдчихсэн явж байна. Энэ ондоо багтаад 12 сарын 31-нээс өмнө бид үүнийг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд зарлах ажил бэлтгэл хангагдчихсан явж байгаа. Бид энэ хугацаандаа амжуулна гэж тооцоолж байгаа.

“Мэдээлэл холбооны сүлжээ” компанийн хувьд мөн 34 хүртэлх хувийг олон нийтэд гаргах ёстой. Энэ компанийн хувьд жаахан асуудал бий. Засгийн газар дээр бид IPO гаргах ажлын талаар Засгийн газар дээр танилцуулдгийг нэгээс хоёр удаа хийсэн. “Мэдээлэл холбооны сүлжээ” компанитай холбоотой асуудлын хувьд тусад нь жич танилцуулсан. Яагаад гэхээр Та бүхэн мэдэж байгаа. “Мэдээлэл холбооны сүлжээ” компани Монгол Улсын нийт интернэт сүлжээний шилэн кабелиудыг төрийн мэдлийн кабелиудыг хариуцаж ажиллаж байгаа. Үүний хажуугаар хувийн хэвшлийн гурав, дөрвөн компани мөн адилхан өөрийн сүлжээ үүсгэчихсэн ажиллаж байдаг. Тэгэхээр энэ бол стратегийн чиглэлд хамаарах үйл ажиллагаагаа гэж манай салбарынхан үзэж байгаа. Энэ дээр тухайн бизнест оролцож байгаа хувийн хэвшлийн компаниудтай бид харилцан санал солилцож байгаа. Яагаад гэхээр Засгийн газраас чиглэл өгсний дагуу солилцсон. Тэгэхээр энэ дээр яг үндэсний хэмжээний корпорац байгуулаад стратегийн хөрөнгө оруулагч нар оруулаад ингээд бүр үндэсний хэмжээний сүлжээ үүсгэгч ажиллах нь Монгол Улсын эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд чухал юм гэдэг саналыг энэ салбарт бизнес эрхэлж байгаа бизнесийн салбарынхан ийм санал гаргаад яваад байгаа. Ер нь 34 хүртэлх хувийг эдгээр салбарын нөхдүүд бага байна гэж үзэж байгаа. Хэрэв та нар энэ асуудлыг хийх гэж байгаа бол нэгмөсөн хувийг нь жаахан өндөр тавиад явбал

яасан юм бэ. Энэ асуудлыг та нар засагтаа эргэж яримаар байна. Бүгдээрээ харилцан танилцаж, судлах юмнууд их байна. Тийм учраас энэ дээр яаран асуудлыг явуулмааргүй байна гэдэг ийм юм ярьсан. Үүнийг бид Засгийн газрын хуралдаан дээр танилцуулаад ингээд асуудал явж байгаа. Ер нь ингэхийн тулд бид эхний ээлжид хаалттай хувьцаат компани болгох, хийгээд ингээд цаашаага асуудлуудыг нь судлаад явна гэдэг ийм байдлаар асуудлыг хандуулсан. Зарим компаниудын үндсэн чиглэл дээр заагдсан хугацааг цаг хугацааны хувьд амжихгүй байна гэж үзээд бид засаг дээр бэлтгэлийг нь хангах хугацааг сунгах асуудал яриад Засгийн газар дээр дэмжлэг аваад шийдсэн ийм Засгийн газрын тэмдэглэл гаргуулсан байгаа. Энэ IT паркийн асуудал байж байна. Ер нь бид IT паркийг бас л адилхан 34.0 хувь гэж оруулсан л даа. Үндсэн хуулийн чиглэл дээр. Яг үнэндээ хэлэхэд манай эрхэм Их Хурлын гишүүд мэдэж байгаа. IT парк гэдэг үндсэндээ л нэг байшин байж байгаа шүү дээ. Нөгөө “Өргөө-2” байдаг. Тийм ээ. Тэгэхээр түүн дээр яах вэ, старт-апп-уудыг хөгжүүлэх, шинэ инновацын чиглэлийн компаниудыг бойжуулах маягтай байр саваар нь хангадаг, үйлчилгээ үзүүлдэг ийм л үйлдвэрийн газар байж байгаа юм. Улсын үйлдвэрийн газрын статустай. Тэгэхээр энэ нь өөрөө яг компани гэж хэлэхэд маш хүндрэлтэй ийм л юм байж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр зүгээр салбар өөрөө, салбарын яам нь, одоо Н.Учрал сайд санал санаачилга гаргаад салбарын яамны оролцоог нь жаахан нэмэгдүүлээч ээ. Энэ дээр бид салбар өөрөө бодлогоо гаргаад бас арай өөр маягаар энэ дээр явмаар байна гэдэг санал гаргасан учраас бид энэ дээр салбарын яамны оролцоог нэмэгдүүлэх замаар хувьцаат компани болгоод инновацын төв болгох чиглэлийг барьж ажиллавал яачихсан юм бэ гэдэг ийм байдалтай явж байгаа. Гэхдээ ерөнхийдөө холбогдох судалгаа, урьдчилсан бэлтгэл ажлын төлөвлөгөө

энэ тэр нь гарчихсан явж байгааг Та бүхэнд хэлье. Дараагийн асуудал бол 20 АЗЗА-гийн асуудал байгаа. 20 АЗЗА-гийн асуудал Та бүхэн санаж байгаа бол Их Хурал дээр энэ үндсэн чиглэл батлагдаж байх үед үндсэн чиглэлд 25 компани биш нэлээн олон компани орж ирж байсныг санаж байгаа байх. Бүр эрчим хүчний компаниудыг хүртэл оруулж ирсэн шүү дээ. Тэгээд түүн дээр Их Хурлын гишүүд шүүмжлээд эрчим хүчний салбарыг ингэж хамаагүй оруулж болохгүй гэсэн. Миний санаж байгаагаар салбарын сайд Н.Тавинбэх сайд энэ дээр өөр байр сууриа илэрхийлж байсан. Ингээд эрчим хүчний зарим компаниудыг энэ үндсэн чиглэлийн жагсаалтаас хасаж байсан. Яг энэ үндсэн чиглэлийг байхад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас үнэндээ ажлын хэсэгт хүн оруулаагүй. Энэ дээр тухайн үеийн Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамтай ярьсан байх гэж бодож байгаа. Энэ дээр ингэж саналыг багцалж оруулж ирж байсан. Тухайн үед бид АЗЗА дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хувьд арай өөр саналтай байсан. Гэхдээ Их Хурал дээр батлагдаад 34.0 хувь гээд гарчихсан учраас бид үүнийг хэрэгжүүлэх ажилд ингээд орж байгаа юм. Энэ ажлыг хэрэгжүүлж байх явцад Та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр 20 төрийн өмчит АЗЗА үндсэндээ нэг компани нь тэрбумаас ойролцоогоор 1.5 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй ийм л компани байж байгаа. Хийж байгаа гол ажил нь гэвэл улсын төсөв дээр энэ зам арчилгаанд суусан төсөв 24 орчим тэрбум төгрөгийг л энэ 20 компани хувааж авч Зам, тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан гэрээний үндсэн дээр л зам арчилгаага хариуцаад ингээд засвараа хийгээд явдаг. Бусад үед бусад орлогоо тухайн орон нутгийн тендерт оролцох замаар ажил олж аваад тэрийгээ тэндээсээ орлого олж ингэж амьдардаг л ийм л компани байгаа юм. Энэ олон жилийн хугацаанд АЗЗА-гийн бүтцийг янз янзаар өөрчилж үзэж байсан юм билээ. Ингээд хамгийн гол нь бид энэ АЗЗА-г 20 компани дээр тус

тусад нь мэдээж энэ чинь IPO хийх болно шүү дээ. Тэгэхээр IPO хийх болохоор 1.0 болон 1.5 тэрбум төгрөгийн активтай, тэгээд өр ширтэй, техник, тоног төхөөрөмж бараг байхгүй ийм компанид Хөрөнгийн биржээр IPO хийхэд амжилтгүй болох магадлал ерөнхийдөө өндөр болчихоод байгаа юм. Үүнийг бид яг энэ хөрөнгийн судалгааны компани, андеррайдер компаниуд, бусад зөвлөх компаниудтай ажиллаж байхад ер нь энэ бол хүнд юм байна шүү гэдэг асуудал ярьсан. Тэгээд гарц гаргалгааны талаар бид Засгийн газарт танилцуулсан. Нөхцөл байдал ийм байна. Хэд хэдэн хувилбар ярьсан. Тийм ээ. Хэд хэдэн хувилбар яриад тэр олон хувилбаруудаас нэг хувилбаруудыг сонгож авсан. Тэр нь юу байсан бэ гэхээр ерөөсөө төрийн өмчит 20 АЗЗА-г нэгтгээд нэг зам арчилгааны нэгдэл болгоё. Тэгэх юм бол хөрөнгө буюу актив нь 40 хэдэн тэрбум төгрөгийн активтай болох юм байна. Ингээд нэг IPO гаргаад явах юм бол 34.0 хувь нь бас амжилттай болох бололцоо байна гэж үзсэн. эдээж энэ асуудлаар бид үүнийг шууд хийчхээгүй. АЗЗА нартай нэлээд тулж ажилласан. Салбарынхантай нэлээн ярилцаж байж энэ шийдэлд хүрсэн. Гэхдээ энэ салбарын үйлдвэрчний эвлэлийн гэх байгууллага шийдвэр гарсны дараа янз янзын байр суурь илэрхийлээд байгаа юмнууд байгаа. Гэхдээ эрхэм Их Хурлын гишүүдэд хэлэхэд Засгийн газраар оруулаад шийдвэр гаргаад тийм ээ, тогтоол гарсан. Тийм учраас бид АЗЗА-г нэгдсэн нэгдэл компаниа сая байгуулж дууссан. Төлөөлөн удирдах зөвлөлийг нь бүрдүүлсэн. Гүйцэтгэх захирлыг нь нээлттэй сонгон шалгаруулалтаар томилоод явж байгаа. Өмнө нь АЗЗА-нуудыг бүсчилсэн байдлаар хуваагаад тус бүртээ төлөөлөн удирдах зөвлөлтэй байсан. Тэр төлөөлөн удирдах зөвлөлүүд үндсэндээ татан буугдаад нэг төлөөлөн удирдах зөвлөлтэй болсон. Ингэснээрээ ерөнхийдөө зөвхөн төлөөлөн удирдах зөвлөл ойролцоогоор нэлээн хэдэн тэрбум төгрөгийн зардал хэмнэгдэж байх жишээтэй байгаа. Ерөнхийдөө бид

АЗЗА-г бэлтгэлийг нь хангая, хугацаа хэрэгтэй байна гэдэг асуудлыг засагт оруулаад 2023 онд бэлтгэлийг нь хангах. Тийм ээ. Бэлтгэлийг нь хангах гэдэг байдлаар жагсаалтад нь өөрчлөлт оруулаад, цаг хугацааных нь календарт нь өөрчлөлт оруулаад тэгээд Засгийн газраас дэмжигдчихсэн байдалтай явж байгааг Та бүхэнд танилцуулж байна. Дараагийн слайд. Ер нь сая би хэллээ. Ер нь бид цаашилаад төрийн өмчит компаниудыг хувьчилна гэнэ үү, олон нийтийн болгоно гэнэ үү энэ асуудлыг хийхдээ бид ерөнхийдөө дандаа Хөрөнгийн биржээр дамжуулж л ерөнхийдөө ийм нээлттэй байдлаар үүнийг хэрэгжүүлж байя гэдэг ийм концепт буюу чиглэлийг барьж ажиллаж байгаа. Зүгээр энэ дээр Та бүхэнд сонирхуулж хэлэхэд Төрийн банк 5 хувийн санал болгож байхад 34 сая ширхэг хувьцаа, 21.1 тэрбум төгрөг төвлөрүүлэх захиалгатай байсан гэхэд 64 тэрбум төгрөгийн санал орж ирж байх жишээтэй. Тийм ээ. Энэ нь өөрөө эрэлт хэрэгцээ бас нэлээн өндөр байсныг илэрхийлж байгаа. Одоо тухайлбал Хөрөнгийн бирж дээр гэхэд л 11.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх ёстой байсан бол санал нь 57.8 тэрбум төгрөгийн санал орж ирж байх жишээтэй. Ерөнхийдөө ер нь манай иргэд болоод хуулийн этгээдүүд Монголын хөрөнгийн биржээр дамжиж байгаа энэ төрийн өмчит компаниудыг олон нийтийн болгох энэ үйл явцад нэлээн идэвх санаачилгатай оролцдог болсон гэдэг нь их сайшаалтай мессежид бид ерөнхийдөө харж байгаа. Бид ерөнхийдөө энэ бүгдээс улбаалаад ерөнхийдөө тодорхой ийм санал, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Энэ дээр бид юу гэж байгаа гэхээр ер нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т Монгол Улсын иргэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, байгалийн баялгийг тэгш хүртээмжтэй хуваарилах. Ингэснээрээ баялгийн санд

төвлөрүүлж зохион байгуулах. Дийлэнх өгөөж нь ард иргэдэд хүртэх ийм зарчим байж байгаа. Тэгэхээр энэ шинэ зарчимд нийцүүлэхийн тулд яг энэ чиглэлийн баялаг бүтээж байгаа аж ахуйн нэгжүүд буюу төрийн өмчит компаниудаа яаж зохистой хэлбэрээр компанийнх нь хэлбэрийг бий болгох вэ, яаж үр дүнтэй ажиллуулах вэ, яаж өгөөжтэй байлгах вэ гэдэг талаас нь засаг дээр маш олон талаас нь ярьж байгаа. Энэ дээр Та бүхэнд хэлэхэд бид компанийн засаглалын хэлбэрийг оновчтой болгох талаар олон улсын байгууллагуудын сайн туршлага, мөн Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудтай нэлээн хамтарч ажиллаж байгаа. Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтарч ажилласан. Энэ дээр хамгийн сүүлийн байдлаар хэлэхэд бид Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай энэ чиглэлээр 250 мянган долларын зөвлөх үйлчилгээний ажил хийгдэх гээд үндсэндээ тохиролцоод байж байна. Тэгэхээр энэ дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай бид хамтарч үүнийгээ хийнэ.

Тэгэхээр “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт заагдсан засаглалын хэлбэрийг оновчтой болгох, компанийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, Үндсэн хуулийн 6.2-ыг хэрэгжүүлэх чиглэлээр ийм “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн хүрээнд төрийн өмчит компаниудын засаглалыг оновчтой болгох, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөөнүүд гаргаад ажиллаж байгаа гэдгийг Та бүхэнд хэлье. Ер нь төрийн өмчит компаниудын өнөөгийн нөхцөл байдлын талаар 2022 он, 2023 оны байдлаар 2022 оны санхүүгийн үндсэн үзүүлэлтээр аваад үзэх юм бол тодорхой дүр зураг харагдаж байгаа. Би хэдхэн статистик тоог Та бүхэнд хэлье гэж бодож байна. Ер нь бид төрийн

өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компаний, улсын төсөвт үйлдвэрийн газар гээд байгаа. Тухайлбал, 2022 онд улсын төсөвт үйлдвэрийн газар 44 байсан бол бид 2023 оны 09 сарын 01-ний байдлаар 41 болгож нэгтгэж нийлүүлж цөөрүүлсэн. Төрийн өмчит үйлдвэрийн газар 26 байсан бол 2023 оны 09 сарын 01-ний байдлаар 26-г 18 болгож бууруулсан. Төрийн өмчит компаниуд 112 байсныг 85 болгож бууруулсан байдалтай байгаа. Энэ нь өөрөө бид компаниудыг ангилж үзээд эдийн засгийнх нь нөхцөл байдал, компанийн ашигт ажиллагаа, өнөөгийн нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг ролиос нь авч үзээд компаниудыг эрэмбэлж ангилсан. Ашиггүй байж байгаа зарим нэгэн давхардалтай, адил төстэй чиг үүрэгтэй компаниудыг нэгдэж нийлүүлэх, татан буулгах ийм процессуудыг сая өнгөрсөн жилүүдэд нэлээд хийлээ. Үүний үр дүнд компаниудын тоо ингэж зохистой түвшин рүү бууж орж ирснийг Та бүхэнд танилцуулж байна. Ер нь төрийн өмчит компаниудын хийсэн анализаар манай салбарт төрийн өмчит компаниудад

- 2021 онд 53 мянган хүн;
- 2022 оны байдлаар 57 орчим мянган хүн ажиллаж байна.

Ер нь яах вэ, өр авлагууд энэ тэр зарим талаараа нэмэгдэж байгаа. Нийт хөрөнгө 53 их наядаас 59 их наяд хүртэл өссөн. Орлого нь мэдээж 3-аас 4 их наядаар нэмэгдэж байгаа. Зардал тэр хэмжээгээрээ л өссөн байдал харагдаж байгаа. Энэ дээр нэг анхаарал татаж байгаа Та бүхэнд хэлэх нааштай үзүүлэлт улсын төсөвт төвлөрүүлж байгаа ногдол ашиг ерөнхийдөө өсгөсөн.

- 2021 онд 207.0 тэрбум;
- 2022 онд 470.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлж чадсан.

Энэ үндсэндээ Төрийн бус компаниуд ногдол ашиг төвлөрүүлсэн энэ түүхэн хугацаанд хамгийн өндөр ногдол ашгийг төвлөрүүлсэн ийм жил байсныг Та

бүхэнд хэлье. Ер нь хөрөнгийн өгөөж ерөнхийдөө нэг хувь, заримдаа нэг хувиас ч доошоо үзүүлэлттэй байсан. 2022 оны байдлаар гэхэд хөрөнгийн өгөөжийг 3.5 хувь руу бид үндсэндээ оруулсан. Энэ байдлаар бид анализ дүгнэлт хийхэд бас ч гэж Их Хурал болон Засгийн газраас гаргаж байгаа шийдвэрүүдийн үр дүн харагдаж байна. Энэ дээр төрийн өмчит компаниудад нааштай үр дүнгүүд гарч байна гэдэг үзүүлэлт хийхэд болохоор байна гэж бид үзэж байгаа. Гэхдээ бидний тавьсан зорилго том. Энэ том зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө хийх ажлууд нэлээдгүй байгаа. Тийм учраас үүнийг бид төлөвлөөд цаашдаа ч гэсэн процесс ажлууд үргэлжлээд явах юм гэдгийг бид Та бүхэнд танилцуулж байна.

- Хувьцаа эзэмшигч гэж нэг ойлголт байгаа.
- Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч гэж нэг ойлголт байгаа.

Тэгэхээр яг энэ хэрэгжүүлэгч гэдэг ойлголтоор аваад үзэх юм бол өнөөдөр манай цөөхөн энэ төрийн өмчит компаниуд хэд хэдэн хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэгчдэд ингэж хуваагдаад байгаа юм.

Тухайлбал,

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 19,
- Эрчим хүчний яаманд 7,
- Сангийн яаманд 7,
- Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 3,
- Зам, тээврийн яаманд 3,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 45 байсан юм. Энэ тоо цөөрөөд одоо манайд 20 гаруй компани байж байх жишээтэй. Тэгэхээр бид хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхдээ ч гэсэн өөрчлөлтүүд.../минут дуусав/

Г.Ганболд: 2 номерын микрофоныг сунгая. Танилцуулгаа гүйцээе.

Б.Цэнгэл: Энэ дээр диаграмм байгаа. Диаграмм манай эрхэм Их Хурлын гишүүдэд харагдаж байгаа байх. Энэ дээр хөрөнгөд өсөлттэй харагдаж байна. Өр төлбөр, орлого гээд. Хамгийн доод талд нь байж байгаа ашиг бол одоо бид бас энэ дээр ер нь жаахан дүгнэлт хийж байгаа. Яах вэ ногдол ашгийн хэлбэрээр бид нэлээн шахаж шаардаж байж үүнийг өсгөж байгаа боловч ер нь орлого энэ тэр нь өсөөд байгаа болоход ашиг нь ерөнхийдөө төдийлөн сайн өсөхгүй байгаа явдал энэ компаниудыг ашигтай ажиллуулах асуудал чухал байна гэдэг тал руугаа ерөнхийдөө анхаарал хандуулахаас өөр аргагүй байдалд хүргэж байгаа юм. Ер нь төрийн өмчит компаниудын ерөөсөө ихэнх орлого, өр төлбөр, энэ бүх асуудал ерөөсөө 6, 7 компанид л ерөнхийдөө гол юм нь хуваагдаж байгаа юм. Энэ хүснэгт дээр байгаа. Та бүхэн харж байгаа байх гэж бодож байна. Бид зорилгоо хэрэгжүүлэхийн тулд яах вэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр ямар чиглэлээр бид ажиллаж байна вэ гэхээр зарчмын шинжтэй шинэчлэлүүдийг хийнэ гэж үзэж байгаа. Энэ дээр бид гурван асуудлыг Та бүхэнд онцгойлон хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, бид төрийн бус компаниудын өмчлөлийн асуудлыг ер нь их зүй зохистой шийдэх нь зөв юм. Энэ дотор бид юуг анхаарч ажиллаж байна гэхээр олон нийтийн нээлттэй хувьцаат компани байлгах, төрийн зохистой оролцоо бүхий стратегийн салбарын компанийг авч үзэх. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, зарим салбарт зохицуулалт хийх, нийгмийн зарим нэг зорилтыг хангаж хэрэгжүүлэх зорилго бүхий тусгай зориулалтын компани байх юм байна. Мөн хувийн хэвшилтэй өрсөлдөөнт зах зээлд өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж ажиллах нь зүйтэй гэдэг чиглэлийг барьж байгаа.

Засаглалынх нь хувьд бид олон улсын хэмжээнд засаглалын асуудлыг судалдаг OECD гэж байгууллага байгаа. Энэ байгууллагын засаглалын 4, 5 хэлбэр байна. Энэ хэлбэрүүдээс манайд судалгаа хийсний үндсэн дээр ер нь төвлөрсөн байдлаар менежментийг хийх нь танай Монгол Улсын хувьд хамгийн зөв хувилбар байна гэдгийг их зөвлөөд байгаа. Тэгэхээр бид яах вэ бас олон талаас нь харж байгаа л даа. Тэгэхээр яах вэ, төвлөрсөн удирдлага, хөрөнгийн нэгдсэн менежменттэй, цахим шийдэлд суурилсан мэдээллийн нэгдсэн сангийн хяналт, гүйцэтгэлийн тогтолцоотой байя гэж байгаа. Тэгэхээр дунд болон урт хугацааны төлөвлөлт хийж байя. Хөрөнгийн өгөөжийн хяналт, мониторингийг бас их оновчтой зохион байгуулъя. Мэргэисэн удирдлага байя. Нээлттэй сонгон шалгаруулалтаар удирдлагын багийг төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлж байя. Хувьцааны үр өгөөжийг иргэд шууд хүртдэг байх энэ хэлбэр лүү зайлшгүй орох ёстой гэдэг ийм байдлаар асуудалд хандаад энэ чиглэлээр бид ер нь ажиллаж байгааг Та бүхэнд хэлье. Ерөнхийдөө ийм байна. Тэгээд ер нь хэрэгжүүлж буй ажлууд, зорилтыг ерөнхийдөө 6 бүлэгт хуваачихсан юм. 6 бүлэгт хуваагаад ер нь энэ хэдэн 6 зорилгыг хэрэгжүүлээд ажиллахад бид энэ компанийн засаглалыг ямар ч байсан шинэ шатад гаргана гэдэг итгэл үнэмшил байгаа. Энэ дагуу Засгийн газартайгаа хамтарч, бас төрийн өмчит компаниудтай нэлээн тулж ажиллаж байгаа. Тодорхой үр дүнгүүд харагдаж байгаа. Гэхдээ мэдээж хийх ажлууд их байгаа гэдгийг хэлье. Тэгээд товчхон Та бүхэнд мэдээлэл хийлээ. Баярлалаа. Асуултад хариулъя.

Г.Ганболд: Тогтоолын 3, 4 дэх заалттай холбогдуулаад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр танилцуулга хийнэ.

Ажлын хэсгийн 1 номерын микрофон руу оччих. Ажлын хэсгийн 1.

Тэгээд дараа нь асуулт асууна. Ажлын хэсгийн 1 номерын микрофоныг өгье.

М.Мэндбаяр: Сайн байцаана уу. Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 03 дугаар тогтоолын 3 дахь заалтаар Уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжүүлэхтэй холбогдуулан хуульд заасан холбогдох журмуудыг хууль хэрэгжих хугацаатай нийцүүлэн баталж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэн, арилжааг олон улсын жишигт нийцүүлж, нээлттэй, ил тод зохион байгуулахыг Засгийн газарт чиглэл болгосон байгаа.

Монгол Улсын Их Хурлаас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцэн баталсан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Хууль хэрэгжих хүртэлх хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол, мөн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны түр журам батлах тухай” 466 дугаар тогтоол тус тус батлагдаж 2023 оны 1 дүгээр сараас нүүрсийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй цахимаар арилжаалах ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж эхэлсэн.

Цаашилаад хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамнаас Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг Монголын хөрөнгийн биржээр гүйцэтгүүлэх тухай” 59 дүгээр тогтоол, “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллын батлах тухай” Засгийн газрын 2023 оны

06 дугаар сарын 07-ны өдрийн 223 дугаар тогтоолыг тус тус батлуулаад байна.

Мөн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан “7 журам”-ыг Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж мөрдөж эхэлсэн. Ингэснээр экспортод гаргах нүүрс, төмөр, жоншны хүдэр, баяжмалыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжих эрх зүйн орчин бүрдээд байна. Биржийн арилжаа эхэлснээр уул уурхайн бүтээгдэхүүнийг ил тод, нээлттэй арилжих, зээлийн бодит үнээр борлуулах, гадаад дотоодын худалдан авагчдын тоо нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар дээшлэх, хууль тогтоомжийн дагуу албан татвар, төлбөр хураамжийг бодитой ногдуулах ач холбогдолтой арга хэмжээ болон хэрэгжиж байна гэж үзэж байгаа. Үүнтэй холбогдуулан “Биржээр дамжуулан арилжаалсан бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн борлуулалтын үнэлгээг биржийн үнэд үндэслэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 345 дугаар тогтоол батлагдсан нь биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэн арилжааг олон улсын жишигт нийцүүлэхэд түлхэц болохуйц зохицуулалт болсон гэж харж байна. 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Монгол Улсын нүүрсний экспорт 64.7 сая тонн байгаагаас уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 1.7 тэрбум ам.долларын 11.7 сая тонн нүүрс арилжсан байна. Үүнийг задлан харвал

- “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани 8.4 сая тонн;
- “Тавантолгой” хувьцаат компани 1.8 сая тонн;
- “Энержи ресурс” 1.5 сая тонн;

- “Хангад Эксплорэйшн” 140.8 мянган тонн нүүрс тус тус арилжсан байна.

Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани 2023 онд экспортолсон нүүрснийхээ 31 хувийг, орон нутгийн өмчит “Тавантолгой” хувьцаат компани нийт борлуулсан нүүрснийхээ 81 хувийг тус тус биржээр дамжуулан арилжаалаад байгаа мэдээтэй байна. Мөн биржийн арилжсан нийт нүүрсний 90 орчим хувийг чулуун нүүрс, 10 орчим хувийг эрчим хүчний нүүрс эзэлж байна. Төмрийн хүдэр баяжмалын хувьд 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс арилжаалж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар “Дархан төмөрлөгийн үйлдвэр” болон “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газар нийт 46.6 сая ам.долларын 581.7 мянган тонн төмрийн баяжмалыг арилжаалсан байна.

Цаашид төмөр болон жоншны экспортын арилжааг нэмэгдүүлэх хүрээнд Замын-Үүд-Эрээн чиглэлийн төмөр замын нэвтрүүлэх чадварыг сайжруулах, нүүрсний биржийн экспортыг нэмэгдүүлэх хүрээнд биржээр арилжаалсан бүтээгдэхүүний экспортын тусгай гарцтай болох зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлага байна гэж харж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Ганболд: Ж.Ганбаатар сайдын микрофоныг өгье. Ж.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би зүгээр энгийн үгээр хоёр зүйл хэлчихье гэсэн юм. Бирж хуулиараа зөвхөн төрийн өмчит компаниуд заавал бүтээгдэхүүнээ арилжина. Тэгэхдээ хувийн компаниуд зүгээр сайн дураараа гэдгийг гишүүдэд сануулж хэлье. Тэгээд Засгийн газраас ээлж дараалаад биржээр зарах бүтээгдэхүүнийг баталж байгаа. Яагаад нэг доор батлахгүй байна вэ гэхээр мэдээж энэ ачааллыг дийлэх боломжгүй.

Бирж маань өөрөө шинэ тулгар байгуулагдаж байгаа учраас энэ дээр ингээд ээлж дараалаад явж байгаа. Өнөөдөр “зэс” гэсэн шийдвэр нэмж гарлаа. Засгийн газраас. Тэгээд уул уурхайн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний бид 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” болоод “Жижиг Тавантолгой” компанийн 30 хувийг экспортолно гэж байгаа юм. 2023 онд. Яагаад 30 хувь бэ гэж олон хүн асуудаг юм. Яагаад 100 хувь биш байгаа юм бэ. Тэгэхээр 30 хувь гэдэг бол урт хугацааны гэрээ байгуулагдчихсан. Бид одоо юу гэдэг юм шууд 100 хувь зарна гээд тэр урт хугацааны гэрээнүүдийг бүгдийг нь хүчингүй болгож болохгүй шүү дээ. Энэ чинь бизнесийн харилцаа явж байгаа. Компани. Түүнээс биш шууд очоод л бүгдийг нь зогсооно, бүгдийг нь биржээр зарна гэвэл Монгол Улс маань өөрөө яаж харагдах вэ. Тийм учраас урт хугацааны гэрээнүүдийн дуусах хугацааг хүлээж байгаа учраас бид 30 гэдэг тоог санамсаргүйгээр хэлээгүй шүү. 2024 онд 50 руу хүрэх байх.

Тэгээд 30-д хүрчихсэн байгаа. Одоо энэ 11 сая тонн нүүрс гэдэг бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн болоод “Жижиг Тавантолгой” компанийн экспортолж байгаа нүүрсний 30-аас дээш хувь нь хүрчихсэн байгаа шүү. Үүнийг би сануулж хэлье. Тэгээд төмөр, жонш бид бас аль болох бололцоогоороо зарахыг юу яаж байна. Ер нь яах вэ, худалдан авагч тал хуучин байсан тэр нэг амар хялбар хэлбэрээр хийж байсан гэрээ рүүгээ санагалзах, тэр лүүгээ орох сонирхол ихтэй. Тэгээд аль 2 сараас хойш л, ялангуяа Өвөр Монголын Баяннуур аймаг ер нь үүнийг нэлээн ярьдаг. Тэгэхдээ бид нэлээн солонгоруулсан байгаа. Худалдан авагч нарыг. Солонгоруулсан гэдэг нь ганц Өвөр Монголын худалдан авагч нар биш. Одоо Хонгконгоос, Шанхайгаас, Гуаньжоугаас. Одоо тэр бусад мужуудаас оролцдог солонгорсон байдал руу нэлээн сайн оруулж өгч чадаж байгаа гэж үзэж байгаа.

Тэгээд биржийн арилжаа ер нь тэгээд сул тал байгаа. Хүргэлт үнэхээр бас тийм санасанд хүртэл явахгүй байгаа. Сул тал байна. Тийм учраас бид нүүрс дээр тусгай гарц шаардаж байгаа. Тэгээд үүнийг манай боомтын сайд хөөрхий маш сайн л хөөцөлдөөд л байгаа. Тэгээд бирж дээр яах вэ, тусгай гарц дээр тэр нэг Баян Базараа гээд нэг нөхрийн авчихсан байгаа тэр нэг зам одоо хүчингүй болох л ёстой л доо. Жишээ нь, тендер нь хүчингүй болгоод. Тэгээд хүчингүй болгоё гэхээр баахан л өр төлбөр. Манайх ингээд бас нэг тойрогт орчихсон юм байгаа. Тэгээд тэр замыг хүчингүй болгоод, тендерийг нь хүчингүй болгоод өөр хүмүүс хийгээд маш хурдтай явчихвал уг нь бас бирж маань тусдаа замтай болчихвол хүмүүсийн сонирхол хамаагүй.

Тэгээд л бирж нь ч нэг очертой, урт хугацааны гэрээтэй нь ч нэг очертой. Ямар ч давуу талгүй болохоор тэгээд биржийг нэг их тийм. Энэ тэгээд давуу талгүй юм байна даа гээд. Төр бодлого хэрэгжүүлж байгаа юм бол уг нь тэнд нэг чиглэл, давуу тал гаргаж өгөх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Зэсийн хувьд бид ямар ч байсан эхний ээлжид 5-аас 10 хувийг нь биржээр зарна. Тэгээд л хардлага сэргэлэг болоод л. Тийм юм байдаг, ийм юм байдаг гээд л янз янзын ярианууд гараад байдаг. Тийм учраас ямар ч байсан 2024 ондоо бид зэсийг 5 хувийг нь ч юм уу, 10 хувийг нь. Мэдээж бас зэс чинь өөрөө урт хугацааны гэрээнүүд хийчихсэн байгаа. Тийм учраас нэмэгдэж байгаа тэр зэсийн баяжмал шүү дээ. Тийм ээ. Зэсийн баяжмалыг бид биржээр зарж. Ер нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зэсийн, ялангуяа зэс хайлуулах үйлдвэрүүдэд манай Эрдэнэтийн зэсэд маш сайн амтай. Маш эрэлттэй. Хүн болгон гэрээ хийх. Хүн болгон ч юу байх вэ, ер нь үйлдвэрлэгч болгон гэрээ хийх сонирхолтой байдаг. Оюу Толгойг ч гэсэн ялгаагүй. Тийм учраас бид зэсийг оролдож үзэж зарах ёстой. Тэгээд биржийг Монгол Улс, ялангуяа

Үйлдвэржилтийн байнгын хороо олон талын шахалт ирж байгаа ч гэсэн маш сайн дэмжиж ажиллаж түлхэх. Энэ бол Монгол Улсын өнөөдрийн уур уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж байгаа бас нэг суурь шалтгаан. Ганцхан үүнээс болсон гэж хэлэхгүй л дээ. Суурь шалтгаан. Тэгээд үүнийг олон талаас нь дэмжиж байж цаашидаа Монгол Улс валютынхаа орлогыг нэмэгдүүлэх. Тэгээд худалдан авагч тал ч гэсэн ямар нэгэн өөр арга зам хайхгүйгээр сонирхол нь ч гэсэн нэг тал руугаа ирээд бүх зүйл ил тод болох, экспортолж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэх ийм гол гарцаа гэдгийг хэлье. Ярьж дууслаа.

Г.Ганболд: Байнгын хорооны 2023 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбогдуулаад мэдээлэл сонслоо. Асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Т.Энхтүвшин гишүүнээр тасалъя. Ж.Батжаргал гишүүн асууя. Н.Наранбаатар нэр өгсөн үү. Үгүй юу.

Ж.Батжаргал: Төрийн өмчийн компаниудыг хувьчлах, үнэт цаас гаргах тухай тодорхой бодлого, чиглэл гаргаад тогтоол гаргасан. Сая хийж байгаа ажлын талаар их тодорхой мэдээллүүд ярина лээ. Мэдээж бид зах зээлийн өөрийнх нь хууль гэдэг юм уу, тэр моральд нь нийцэх тухай юм шиг байгаа юм. Би тэгж ойлгоод байдаг юм. Жишээ нь, Төрийн банкаа бид 20 хувийг нь гаргана гээд хэлчихээр зэрэг бидний 80 хувь руу хүн мөнгөө барьж ер нь орж ирэх юм уу. Тэгээд энэ чинь нэгж хувьцааныхаа “нэрлэсэн үнэ”-ийн өсгөлт дээр сөрөг нөлөө үзүүлээд байгаа юм биш үү. Одоо жишээ нь Хөрөнгийн бирж, Төрийн банк хоёрын “анхны үнэ”, “санал болгосон үнэ” хоёрыг хооронд нь тооцоод үзэхээр Төрийн банк дээр анхны үнэ, санал болгосон үнэ хоёрын зөрүү 3 дахин, Хөрөнгийн бирж дээр 5 дахин өссөн байгаа байхгүй юу. Санал нь. Тэгэхээр эндээс би их л тодорхой харагдаж байгаа юм байна даа. Тэгэхээр ер нь цаашид нэгэнтээ л олон нийтийн

болгож, олон нийтийн оролцоо хяналттай, тэр улсууд тэр ТУЗ юмандаа орж ирж, менежментийнхээ бодлого, чиглэлд ч оролцож чаддаг, хяналт юмнуудаа ч тавьж чаддаг тэр л зарчим юм руу нь оруулах нь ер нь бидний хамгийн гол зүйл юм биш үү. Энэ дээр ер нь ямар бодол байна гэж. Нэг ийм зүйл.

Хоёр дахь зүйл. Тэр АЗЗА-нуудыг нэгтгээд нэгтгэл үүсгэчихсэн юм билээ. Мэдээж хөрөнгийн дүн, элдэв бусын юмнууд харвал томорсон нэлээн гайгүй юм харагдаж байгаа байх. Гэхдээ бид жилээс жилд энэ зам талбайн хэмжээ нэмэгдээд яваад байдаг. Тэгэхээр үүнийг бид үнэхээрийн жосоохон урт настай зам байлгая, хөрөнгө юм хий үржихгүй байя гэвэл арчлалтынх нь асуудал л онцгой чухал байгаа л даа. Тэгэхээр энэ рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулахад энэ том нэгтгэл чинь ер нь хэр үр өгөөжөө өгөх юм болоо? Үүнийгээ нэг тооцсон бодсон, цаад үйл ажиллагаа явуулах үйл явцтайгаа, тэгээд тэр нэгж орон нутгууд руугаа чиглэсэн хариуцах ажилтайгаа уялдуулаад үзэхээр энэ ер нь ямархуу юм байгаад байгаа юм. Өнөө жижиг аймгуудад байгаа салбар нэгтгэлтэйгээ юмаа учраа олох гээд тамаа идсэн нэг ийм юм болчих гээд байна уу, үгүй юу. Энэ чинь ер нь явж явж. Компани дотор дахиж компани үүсгээд яваад байгаа юм. Энэ ер нь ямархуу байдлаар яаж зохицуулаад, эрх зүйн ямар гаргалгаа юмнууд хийгээд байна вэ гэж. Уул уурхайн биржийн тухай хууль батлагдсан. Монголын экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байгаа. Тэгэхээр үүнийг ер нь нэг жосоохон ил тод, нээлттэй борлуулалтынх нь асуудлыг шийдье гээд шийдсэн. 07 сарын 01 хүртэл бид туршилтын журмаар явсан. 07 сарын 01-нээс хууль яг хэрэгжээд эхэлсэн. Тэгээд борлуулсан байдал 17.9 хувь л байна шүү дээ. Нийт гарсан нүүрсний одоогийн байдлаар биржээр гарчхаад байгаа чинь 17.9, 18.0 орчим хувь л байгаа юм байна.

Тэгэхээр үүний цаана биржээр борлогдоогүй нүүрсний чинь үнэ ханшид ямар өөрчлөлт орсон юм бэ? Биржээр борлуулаагүй ч гэлээ гэсэн биржийн үнэ рүүгээ татаж шинэчилсэн гэрээ хийгдсэн юмнууд хэр байна. Ер нь бидний урт хугацааны гэрээний.../минут дуусав/

Г.Ганболд: Дараа нь тодруулчих даа. 2 номерын микрофон өгье. Ажлын хэсгийн.

Б.Цэнгэл: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя. Сая би хэллээ. Ер нь цаашидаа ч гэсэн төрийн өмчит компаниудыг олон нийтийн болгох ажлыг Хөрөнгийн биржээр л дамжуулж хийж байя гэж байгаа юм. Хэрэв төсөвт байгууллага юм уу, албан байгууллага байх юм бол компанийн хэлбэрт шилжүүлэхэд дараагийн юмыг хийнэ гэдэг ийм чиглэлийг барьж байгаа. Тэгэхээр хувьцаагаа хөрөнгийн бирж дээр гаргасан компаниуд дээр яах аргагүй таны хэлж байгаа Төрийн банкны хувьцаа хоёр дахь зах зээл дээр уначихсан явж байгаа. Бүр хоёр, гурав дахин уначихсан явж байгаа. Тийм. Үүнийг манай Х.Алтай захирал энд оролцож байгаа. Танд нэмэлт тайлбар өгөх болов уу гэж бодож байна. Зүгээр Монголын хөрөнгийн бирж 34 хувиа гаргачихсан шүү дээ. Хөрөнгийн биржийн хувьд өсөлттэй явж байгаа. Хоёр дахь зах зээл дээр. Тэгэхээр урт хугацааны хөрөнгө оруулалт “Хөрөнгө оруулалтын сан” гэдэг хэлбэрээр бирж хөгжчихсөн оронд ингэж явдаг юм билээ. Тэгээд үүнийгээ дэмжиж явдаг. Тэгэхээр тэр бүтэц нь манай Монголд хараахан бий болоогүй юм шиг байгаа юм. Тийм учраас энэ дээр бас Их Хурал, Засгийн газар дээр ярих ёстой. Тэр нөгөө Баялгийн сангийн сангийн хууль гээд яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр зайлшгүй эдийн засаг, санхүүгийн хувьд нь дэмждэг механизм байх ёстой юм билээ. Хоёр дахь зах зээл дээр. Үүнийг Их Хурал дээр ярих л ёстой асуудал гэж би үзэж байгаа. Нэг дэх асуултын хувьд ийм товч хариулт өгье. АЗЗА-гийн тухайд гэх юм бол

Ж.Батжаргал гишүүний хэлж байгаатай би хувьдаа санал нэг байгаа. Гэхдээ бид энэ АЗЗА нэгтгэлийг нийлүүлж нэгтгэл болгосон явдал ерөөсөө 34 хувийг IPO гаргах гэдэг асуудалтай л ер нь гол нь холбогдчихсон юм. Яагаад гэхээр тус тусдаа 1-1.5 тэрбум төгрөгийн активтай 20 жишжиг компани дээр сонирхогч орж ирэхгүй. Манай Их Хурлын гишүүд нөгөө Банкны тухай хуульд өөрчлөлт оруулаад системийн 5 банканд дээр дүгнэлт хийж байгаад нэг болон нэгдмэл сонирхолтой этгээдүүд нийт хувьцааны 5-аас илүү хувийг авч болохгүй гэдэг ийм хууль хуульд өөрчлөлт орсон шүү дээ. Тэгээд тэр хуулиа гаргахдаа аваачаад бусад юманд хамааруулаад гаргачихсан. Тэгээд тэр хууль чинь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд бас орчихсон байгаа. Тэгээд түүнээс улбаалахаар бод доо, 1.5 тэрбум төгрөгийн активтай компанид хүн орлоо гэж бодоход тэр хүн 5 хувиас илүү юм авч чадахгүй байхгүй юу. Хуулиараа хориглочихсон. Ингээд бодохоор 60-аас 70 саяын төлөө хэзээ ч хүн тийшээ орохгүй шүү дээ. Тэгэхээр бид үүнийг ярьж судалж байгаад ерөөсөө энэ чинь аягүй хэцүү юм байна. Болохгүй юм байна. Үүнийг амжилттай болгохын тулд бид яах ёстой юм бэ гэдэг юм ярьсан. Ингэж ингэж байгаад хэд хэдэн хувилбар бид засагтай ярьсан гэж хэлсэн. Тэндээс хамгийн эцсийн байдлаар боломжит хувилбарыг нь ер нь энэ АЗЗА-нуудыг нэгтгээд нэгтгэл болгоод нэг толгой компанитай болгочихъё. Тэгээд толгой компани дээрээ бүх актив нь харагдаж байдаг. Үүгээрээ явах юм бол 40 гаруй тэрбум төгрөгийн активтай болно. Үүний 34.0 хувь дээр орж ирэх сонирхол гарч магадгүй юм байна гэж л үзсэн юм. Хэрэв энэ бүтэлгүй болох юм бол андеррайтер компаниуд ч гэсэн лицензээ хураалгах юм билээ шүү дээ. Ер нь бол. Ийм л юмнаас гарсан гэдгийг нь хэлье. Ер нь АЗЗА-гийн асуудал. Одоо манай Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга АЗЗА-г удирдаж байсан хүн. Жаргал зовлонг нь сайн мэднэ.

Ж.Батжаргал дарга аймгийн Засаг дарга байсан хүн.

Ерөнхийдөө хувийн хэвшлийн 12 АЗЗА байж байгаа шүү дээ. 12 хувийн хэвшлийн АЗЗА яг адилхан ажил хийж байгаа. Төрийн 20 байгаа.

Г.Ганболд: *Гүйцээж хариулъя. 2 номер.*

Б.Цэнгэл: *Хувийн хэвшлийн АЗЗА хийж болоод байгаа ажлыг заавал төр хийх ёстой юм уу, үгүй юм уу гэдэг бас ийм асуудлууд гардаг юм. Манай Зам, тээврийн яамны мэргэжлийн улсууд энэ ажлыг чинь төр хийхгүй бол энэ рүү чинь орох юмнууд гардаггүй юм. Тийм учраас бид энэ рүү чинь ханцуй шамлаж орохоос өөр аргагүй байдаг гэж байгаа юм. Тэр ч бас тийм юм байх талтай. Уг нь хувьчилчихсан бол 34-өөс илүү хувийг нь хувьчлах нь оновчтой байсан гэж би түрүүн хэлсэн. Энэ дээр анхнаасаа манай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар өөр байр суурьтай байсан. Манайхаас ажлын хэсэгт хүн оруулалгүйгээр энэ асуудал үндсэн чиглэл рүү орж байсан. Гэхдээ 34 хувиар гарчихсан учраас одоо бид өмнөх юм яриад яах вэ. 34-өө яаж эвтэйхэн явуулах вэ гэдэг юм харж байгаа шүү дээ. Тийм учраас мэдээж энэ салангид үйл ажиллагаа болохгүй. Яагаад гэвэл ерөнхийдөө активыг нь нэгтгээд л энэ IPO-д зориулж хийсэн. Дээрээс нь энэ чинь 3-аас 4 удаа АЗЗА-нуудын бүтцийг өөрчилж байсан юм билээ. Өмнө нь бид бас нэлээн судаллаа. Тэгэхээр энэ бол аймгууд дээр нөгөө салбар гэдэг юм нь байдгаараа байх юм.*

Тэгэхээр энэ бол нэгдсэн удирдлагатай болоод хөрөнгө оруулалтын нэгдсэн байдлаар юмыг ярьдаг, хөөцөлддөг, хаана ямар техник хэрэгтэй байгаагаа хийдэг. Тэрийгээ бүсчилсэн байдлаар баазуудаа бий болгоод ажиллах юм бол илүү маневртай, илүү хөрөнгө оруулалтын талдаа ч тэр, техник, технологийн

шинэчлэлтийг асуудлыг цаашидаа ярих ёстой шүү дээ. Тэгэхээр ямар ч байсан эндээс үр дүн гарна гэж бид харж байгаа.

Тийм учраас одоо яаж байна вэ гэхээр зөвхөн толгой компани нь байгуулагдаад явж байна. Бид өнөөдөр 16.00 цагаас Зам, тээврийн хөгжлийн сайдтай энэ асуудлаар уулзах гэж байгаа. Яаман дээр очиж. Тэгээд цааших юмнуудаа түлхээд явна л гэж ойлгож байна. Ямар ч байсан бид өмнөхөөсөө л үр дүн гаргана. Энэ өр ширтэй, алдагдалтай байдлыг л ерөнхийдөө цэгцлэх зорилго тавьж байгаа. АЗЗА-нууд дээр хийж хэрэгжүүлэх нь зөв байна. Ер нь АЗЗА-нууд алаг цоог байгааг та мэдэж байгаа. Яг үндсэн дүнгээр нь харах юм бол ер нь гайгүй. Хэдэн компани алдагдалтай ажилладаг юм. Яг бүх АЗЗА-нуудын санхүүгийн үзүүлэлт надад байна л даа. Ер нь улсын чанартай авто замууд нэмэгдэж байгаа. Энэ дээр санал нэг байгаа.

- *улсын чанартай авто зам 14 мянга 918 километр;*
- *орон нутгийн чанартай авто зам 96 мянган километр байгаа.*

Энэ бол яах вэ ердийн, сайжруулсан, хайрган, хатуу хучилттай гээд хуваагддаг. Ер нь жил ирэх тусам АЗЗА-нуудын хариуцдаг замын хэмжээ нэмэгдэж байгаа. Зарим гар хөрөнгө оруулалтаар шинэ замууд баригдаж байна. Зарим тохиолдолд хувийн хэвшилд тэрийг нь өгөөд, хувийн хэвшилээ АЗЗА байгуулаад яам гэрээ байгуулаад л явчхаж байгаа шүү дээ. Ерөнхийдөө яам 25 орчим тэрбум төгрөгийг л энд хуваарилж байгаа. Үлдэж байгаа буюу ойролцоогоор 13-аас 14 тэрбум төгрөгийг АЗЗА өөрсдөө олдог. Ингээж амьдардаг. Боловсон хүчний бодлогууд ер нь тааруу болсон. Техник, технологийн хувьд маш хүнд байгаа. Цалин хангамж энэ салбарынхан их бага байдаг. Улирлын шинжтэй ажилладаг. Зарим үед улирлын

шинжтэй ажилчид авдаг. Нэг ийм л нөхцөл байдал дунд олон жил явж ирсэн. Тэгэхээр үүнийг бид засаж залруулж үүнийг бас нэлээн сайжруулах чиглэлд нь ерөнхийдөө нэлээн анхаарч ажиллана гэж бодож байгаа. Баярлалаа.

Г.Ганболд: 1 номерын микрофон өгье. Ажлын хэсгийн.

М.Мэндсайхан: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. 07 сарын 01-нээс хууль хэрэгжиж эхэлснээр нийт экспортод гарсан нүүрсний 17.9 хувь нь биржээр арилжаалагдсан байна гэдэг мэдээ нь өнөөдөр 12 сарын 11-ний байдлаар 18.4 хувьтай. Гэхдээ үүнээс түрүүн сайд танилцуулгадаа дурдсан. Нийт биржээр арилжаалсан нүүрсний 32 хувийг төрийн өмчит компаниуд арилжсан байгаа. Үнийн хувьд биржийн арилжааны үнэ тогтмол өсөж байгаа. Ер харьцангуйгаар. Өнөөдрийн байдлаар өнгөрсөн долоо хоногийн арилжаатай харьцуулсан байдлаар харах юм бол 23-аас 98 хувь хүртэл орчим өсөлттэй харагдаж байгаа.

Энэ биржийн арилжиж байгаа нүүрсний үнээс гадна урт хугацааны гэрээтэй буюу биржээс гадуур арилжаалагдаж байгаа, нийлүүлэгдэж байгаа, экспортолж байгаа нүүрсний үнэ ямар нэгэн тохируулга хийгдсэн үү гэсэн байдлаар асуулт тавигдлаа гэж ойлгосон. Борлуулсан нүүрс нь өмнө нь хийгдсэн гэрээнүүд дандаа уурхайн ам нөхцөлөөр ихэвчлэн хийгдсэн гэрээнүүд байсан. Үүнийг “Эрдэнэс Тавантолгой” болон “Эрдэнэс Монгол” компанийн удирдлагуудын санаачилгаар ерөнхийдөө Засгийн газрын тогтоолд нийцүүлэх үүднээс хил нөхцөл рүү шилжүүлэхээр шаардлагууд тавигдсан байдаг.

Ингээд нийтдээ тухайн үедээ хүчин төгөлдөр байсан 100 гаруй гэрээнээс 88 гэрээний асуудлыг ямар ч байсан цэгцэлсэн. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээнд хил нөхцөл рүү үнэ тохиролцоод шилжүүлэх боломжтой. Тийм боломжтой. Хүлээн зөвшөөрсөн.

Үнэ хүлээн зөвшөөрөөд хил нөхцөлөөр үнэ тохиролцсон аж ахуйн нэгжүүдийн гэрээг үргэлжлүүлээд, хил нөхцөлийг хүлээн зөвшөөрөөгүй аж ахуйн нэгжүүдийн гэрээнүүдийг тухайн үед нь хүчингүй болгоод.../минут дуусав/

Г.Ганболд: Ж.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Ганбаатар: Манайх сая зуун арван хэдэн гэрээ гэдэг нь дандаа урт хугацаатай гэрээ юм. Үүнийг ам нөхцөлийг нь хил болго, биржийн үнэд ойртуул гэдэг бодлого л гаргаж байгаа юм. Түүнээс биш гэрээгээ аваад ир. Энэ үнийг өөрчил гэж. Энэ утгаа алдана. Тэгэхээр яаманд тийм зүйл байхгүй. Энэ бол С.Наранцогт захирал ч бараг мэдэхгүй байгаа байх. “Эрдэнэс Тавантолгой” компани өөрөө яг үүнийгээ гардаж хийнэ. Бид нарт өгч байгаа мэдээ бол тэр 118-аас 11-ийн л урт хугацааны гэрээ үлдээсэн. 4 оффтэйк гэрээ байгаа. Үүнийг та өөрөө бараг мэдэж байгаа байх. Түүнээс биш. Тэгээд тэрийг зөвшөөрөхгүй байгааг нь. Тийм ээ. Одоо ингээд ам нөхцөлтэй байна, үнэ чинь хямдхан байна, Засгаас ийм чиглэл барьж байна, ингээд өөрчилье гээд зөвшөөрөхгүй байгааг нь шууд хүчингүй болгочихсон юм билээ. Одоо Хятадын компаниуд манай яаманд ямар гомдол ирүүлж байна гэхээр тэр хүчингүй болгочихсон компаниудын барьцаа мөнгийг нь өгөөч ээ. Урьдчилгааг нь өгөөч ээ. Үүнийг өгөхгүй байна гээд. Бид болохоор үгүй энэ барьцааг нь өгөх ёстой шүү дээ. Тавантолгой компани гээд л. Одоо яг өчигдөр энэ асуудлаар хүртэл. Хятадын Элчингээрээ дамжаад компаниуд нь. Энэ болохгүй л дээ. Хүний мөнгө авчхаад тэгээд болохгүй. Түүнээс биш тэр төрийн бодлогод нийцүүлнэ гээд нэлээн дорвитой сайн арга хэмжээ авсан юм билээ. Дэлгэрэнгүй ярьчихлаа. Уучлаарай.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Уул уурхайн анхдагч бүтээгдэхүүн гэдэг юм уу, боловсруулаагүй бүтээгдэхүүн гэсэн үг юм байна. Тийм бүтээгдэхүүний борлуулалт төр байна уу, хувь байна уу түүнээс үл хамаарч энэ биржсийн борлуулалт руугаа явах ёстой. Энэ бол заяагдмал баялаг байхгүй юу. Үр өгөөжийг нь ард түмэн хүртэх ёстой ийм баялаг. Тийм учраас нэг компанийн захирал асуудлыг мэддэг юм шиг хандуулж бас боломгүй. Мэдээж олон улсын өмнө гэдэг юм уу, тодорхой түншийн өмнө хүлээчихсэн үүрэг байгаа. Бидэнд. Тийм урт хугацаатай гэрээнүүдийн 2024 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ яг хэд юм гэдэг юмаа тогтоод л бусдыг нь биржээр борлуулах арга хэмжээг л яам бодлогоор шахах ёстой. Энэ бол хуулийн хэрэгжилт бай байх ёстой гэж. Ер нь 1 сая гаруй тонн л юм гарч байгаа шүү дээ. Наад зэс чинь. Тэгээд одоо үүнийг Уул уурхайн биржсийн хуулиараа л явчихсан нь дээр дээ. Тэр урт хугацааны гэрээг нь хасаад л үлдсэн.../минут дуусав/

Г.Ганболд: Санал хэллээ.
Т.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Биржсийн тухай хууль гараад амжилттай хэрэгжиж байгаа. Үүнтэй санал нэг байна. Хамгийн гол асуудал нь бид биржээр зарж байгаа нүүрсээ хил давуулж хүргэж өгөх ажил дээр онцгой анхаараач ээ. Биржээр худалдаа хийгээд байдаг аж ахуйн нэгж, байгууллага чинь хүргэлт нь цаг хугацаандаа очихгүй болохоор нөгөө биржид итгэх итгэл маань бас байхгүй болчих вий. Энэ дээр онцгой анхаараач. Бусдаар юу гэдэг юм нүүрсээ бид биржээр зарж байна. Зарим хувийн хэвшлийн компаниудын төмөр болон угаасан нүүрсийг биржээр зарж байна. Цаашидаа хувийн хэвшлийнхэн энэ угаасан болон баяжуулсан бүтээгдэхүүнээ биржээр зарах ийм сонирхол бий болно. Бий болж байна. Яагаад биржээр зарах гээд байна гэхээр үндсэндээ АМНАТ-ийнх нь төлбөрөө биржсийн үнээр төлөх гээд

байгаа учир тэр хэд биржээр бүтээгдэхүүнээ заръя гэдэг асуудал сүүлийн саруудад нэлээн тавьж байгаа юм билээ.

Тэгэхээр танай биржсийн хүчин чадал нэмэгдэх, цаашидаа биржээрээ энэ хувийн хэвшлийн баяжуулсан болон боловсруулсан түүхий эдийг биржээр зарах ийм хүчин чадал, тийм нөөц бололцоо танай дээр байна уу? Хоёр дахь асуудал.

Нэг дэх асуудал. Би түрүүн хэллээ шүү дээ. Биржээр худалдаж авсан компаниудын нүүрсийг цаг хугацаанд нь хүргэж өгөх асуудал дээр онцгой анхаараач ээ. Биржид итгэх итгэл маань байхгүй болчихов. Биржээр юмаа авдаг. Тэгээд дөрөв, таван сарын дараа сар дамнуулаад бүтээгдэхүүнийг нь өгдөг. Ингээд үнийн ханш унадаг ч гэдэг юм уу ийм эрсдэлтэй байгаа учир энэ дээр ер нь ямар арга хэмжээ авч байгаа юм бэ?

Гурав дахь асуудал. Ингээд эрдэс баялгаа бид биржээр зараад явж байна. Нөгөө Дарханы төмөрлөгийн үйлдвэрээ яах юм? Нөгөө Хөтөлийн цемент шохойгоо бид яах ёстой юм? Энэ Тавантолгойгоо цаашидаа олон нийтийн болгох, хувьцаат болгох энэ асуудал дээр ер нь ямар бодлого барьж ажиллаж байгаа юм. Ерөөсөө ард иргэдийн ярьж байгаа юм бол ерөөсөө л энэ төрийн өмчтэй компаниудаа олон нийтийн болгоодхооч ээ. Хувьцааг нь гаргаад дотоодын компаниуддаа худалдаач ээ гэдэг ийм асуудал тавьж байгаа шүү дээ. Энэ хулгай зэлгээний асуудал чинь дандаа л энэ төрийн өмчтэй компаниудтай холбоотой асуудал. Энэ дээр ямар бодлого барьж байгаа юм бэ гэдэг дээр гурав дахь асуудал.

Дөрөв дэх асуудал. Улсын Их Хурлын тогтоолоор баахан төрийн өмчтэй компаниудыг олон нийтийн болгох Улсын Их Хурлын тогтоол гарсан. Амьдрал дээр нийцэхгүй. Тухайлбал, бүх цахилгаан станцуудаа олон нийтийн

болгох, бүх дулааны станцаа олон нийтийн болгох, бүх зам арчлалтын компаниа олон нийтийн болгох гээд ийм. Тэгээд бүгд алдагдалтай ажилладаг. Цахилгаан станцаа олон нийтийн болгочих юм бол цаашидаа цахилгаан тасрах ч гэдэг юм уу, ямар нэгэн эрсдэл үүсэхэд хэн хариуцах юм? Энэ байж байгаа юм. Тийм. Тэгэхээр энэ дээр та хэд маань нэг эргэж хараад харин эсрэгээрээ энэ юу гэдэг юм төрийн өмчтэй энэ уул уурхайн компаниудаа олон нийтийн болгох энэ асуудал дээр нэлээн дүгнэлт хийгээч ээ. Дээр нь энэ Хөдөө аж ахуйн бирж гээд байна. Энэ арьс ширний бүтээгдэхүүнээ биржээр худалдаалах асуудлыг та хэд онцгой анхаараач ээ. Ерөөсөө арьс ширний үнэ, ноос ноолуурын үнэ гээд. Одоо мах, махан бүтээгдэхүүнээ ч гэсэн бид биржээр зарах бололцоо боломж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр та хэд маань нэг онцгой анхаараач гээд. Саяхан хэдхэн хоногийн өмнө сошиалаар яваад билээ. Хөрөнгийн биржийн удирдлагыг сонгон шалгаруулна гээд. Хөрөнгийн биржийн салбар нэгжүүдийн захирлуудыг сонгон шалгаруулна гээд.

Саяхан манай хөрөнгийн бирж чинь 34 хувиа олон нийтийн болгоод, олон нийтийн хяналттай болоод явж байхад нь одоо хэзээ хойно нь сонгон шалгаруулалтыг нь хийнэ гэдэг ийм зар яваад байгаа юм. Энэ ямар хууль эрх зүйн орчин байдаг юм? Х.Алтай захирал юу гэж бодож байгаа юм.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номер. Ажлын хэсгийн 3.

Х.Алтай: Эрхэм Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хамгийн сүүлийн асуулт буюу Монголын хөрөнгийн биржтэй холбоотой асуултад хариулъя. Монголын хөрөнгийн бирж 1991 онд байгуулагдсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг

хуулиудаар зохицуулагддаг, үнэт цаасны арилжаа эрхэлдэг байгууллага. 2022 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль гарсан. Энэхүү хуулийн дагуу Засгийн газрын 2023 оны 02 сарын 08-ны өдрийн 59 тоот тогтоол гарч Монголын хөрөнгийн биржээр уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг гүйцэтгүүлэхээр заасан байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль дээр зохицуулалт байдаг. Тэр зохицуулалт нь энэхүү хуулийн дагуу байгуулагдсан биржийн удирдлага, газрын захирлуудыг сонгон шалгаруулна гэсэн зохицуулалт байдаг. Бид бүхэн сая гишүүний асуусан тэр зарын тухайд гэвэл манай төлөөлөн удирдах зөвлөлөөс ийм шийдвэр гаргаад энэ зарыг тавьсан. Гүйцэтгэх удирдлагын зүгээс энэхүү хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа Санхүүгийн зохицуулах хорооны байр суурь, чиглэлийг авах ёстой гэсэн энэ зөвлөмжийг өгсөн. Ер нь гүйцэтгэх захирлын хувьд магадгүй тусдаа асуудал байж магадгүй. Гэхдээ гар нэгжийн захирлуудыг бүгдийг нь сонгон шалгаруулж өөрчлөх нь магадгүй энэ чухал үед уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа нэвтэрсэн, түүнчлэн бирж өөрөө олон нийтийн компани болсон. Бусад төрийн өмчит компаниудтай үлгэр жишээ үзүүлэхүйц хэмжээний засаглалтай, үйл ажиллагаатай байх ёстой. Түүнчлэн банкны реформ хөрөнгийн биржээр дамжин хийгдэж байгаа энэ чухал үед бас ингэж нийтээр нь өөрчлөх нь өөрөө магадгүй энэ санхүүгийн институцийн хувьд эрсдэлд оруулах магадлалтай гэж үзэж байна.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 2 номер.

Б.Цэнгэл: Т.Энхтүвшин гишүүний хэлж байгаатай санал нэг байгаа. Ер нь бид тухайлбал 2010-2012 онд үндсэн чиглэлд тусгагдсан боловч хэрэгжээгүй хуулийн этгээдүүд гэхэд л Багануур, Дулааны-III цахилгаан станц, Эрдэнэт, Улаанбаатар цахилгаан түгээх,

Автоимпекс, Монголын цахилгаан холбоо, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Монголын төмөр зам. Ингээд л цаашаа явна. Эрдэнэт, Шивээ-Овоо, Багануур, Диспетчерийн үндэсний төв, Хөдөө аж ахуйн бирж гээд л.2010-2012 онд 8, 2015-2016 онд 15, 2022-2023 онд 6 байгаа байхгүй юу. Тэгэхээр бид Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Хэрэг эрхлэхтэй яриад бид үүнийг ойрын хугацаанд засаг руу оруулах гэж байгаа юм. Юу гэхээр ер нь энэ үндсэн чиглэл батлаад л байдаг. Тийм ээ. Тэгээд л хэрэгжиж байгаа юм байхгүй. Тэгсэн мөртлөө хүчин төгөлдөр гэдэг категорид ороод яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид ингээд л нэг юмнаас эшлэл авах болохоороо 2010 оны үндсэн чиглэлийн тэдэд заасан гээд л юм ярьдаг юм. Тэгэхээр одоо үүнийг бид цуцалсныг нь цуцлаад, байх нэгийг нь байлгаад энэ юмнуудыг ерөнхийдөө нэг болгоё гэж ярьсан. Засаг дээр. Ингэхээр энэ юмнууд жигдрээд д ороод ирнэ гэж бид үзэж байгаа. Нөгөө нэг асуудал цаашидаа энэ төрийн өмчит томоохон компаниудаа яах юм бэ гэж. Их Хурлын нэг шийдвэр байдаг. Гэхдээ тэр хэрэгжээгүй яваа. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэртэй холбогдож гарсан. 10 хувийг нь олон нийтийн болгоё. Иргэд нь хувьцааг нь өгье гэсэн шийдвэр ерөөсөө огт хэрэгжихгүй явж байгаа. Тэгэхээр бид энэ дээр зөвлөх үйлчилгээний компани, гадаадын байгууллагуудтай нэлээн ажиллаж байна. Тухайлбал, бид “МИАТ” дээр зөвлөх үйлчилгээ Сингапураас авчихсан явж байгаа. Бид холбогдох байгууллагуудтайгаа ярьж байгаад ер нь дараагийн үндсэн чиглэлийг оруулахдаа нэлээн нухацтай судалж байгаад тийм ээ, нэлээн хэрэгжих үндэслэлтэй ийм юмнуудаа Их Хурлаараа оруулна гэж бодож байгаа. Тухайлбал, энэ дотор саяын таны хэлсэн тэр Хөтөл, Дарханы төмөрлөг, Эрдэнэт, Монросцветмет энэ тэр бол тодорхой хэмжээгээр орж ирэх ёстой байхгүй юу. Одоо “МИАТ” энэ тэр орж ирэх ёстой гэж бид харж байгаа.

Зүгээр яах вэ нэг л асуудал байгаа. Энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөтөлтэй холбоотой асуудал дээр нөгөө шүүхийн маргаанууд яваад байгаа байхгүй юу. Захиргааны хэрэг дээр ч байж байна, иргэн дээр ч байж байна, эрүү дээр ч байж байгаа юмнууд байгаа юм. Тэгэхээр яах вэ, энэ асуудлыг нь жаахан харсан байдалтай явж байгаа тал бий. Гэхдээ ер нь одоо бид энэ томоохон төрийн бус компаниуд руу орох цаг хугацаа болчихсон гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр бид ойрын хугацаанд ерөнхийдөө засагтайгаа ярьж байгаад энэ асуудлуудыг гаргаж ирж тавина гэж Та бүхэнд хэлье.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 1 номер.

М.Мэндсайхан: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Биржээр арилжаалагдсан бүтээгдэхүүний хүргэлт дээр анхаарах шаардлагатай байна гэдгийг. Тэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Эрдэнэс Монгол”, мөн Боомтын сайд тал талаасаа хамтраад Засгийн газар хоорондын уулзалтуудын түвшинд ч гэсэн энэ асуудлыг байнга тавьсаар байгаа. Түүнээс гадна бид бусад өнөөдөр ашиглаж байгаа гарцуудыг ч гэсэн тодорхой хэмжээний зохицуулалт хийгээд тодорхой цагийн хуваарьтайгаар, жишээлбэл Оюу Толгойн гарц дээр тодорхой цагийн хуваарьтайгаар биржийн нүүрсийг экспортлох боломжийг ч гэсэн Оюу Толгойн талтай ярилцаж байгаа. Одоогоор яг эцсийн шийдэлд хүрээгүй байна. Гэхдээ Оюу Толгойн талаас бас огт болохгүй гэсэн санааг хэлээгүй байгаа.

Ер нь бидний харж байгаа гол эмзэглэж байгаа асуудал мөн. Биржийн арилжааг хүчин чадлыг нь нэмэгдүүлэх боломж бий. Хүчин чадлыг нь нэмэгдүүлэхдээ нэг удаагийн арилжааны хэмжээг нь ч нэмж болно. Эсвэл дуудлага худалдаа зохион байгуулж

байгаа арилжааных нь тоо, эрчмийг нь ойртуулах байдлаар биржээр арилжиж байгаа бүтээгдэхүүний хэмжээг бид зорилтынхоо түвшинд нэмэх боломж байна гэж харж байгаа. 65 хувийг нь бид ямар ч байсан хүргээд өгчихсөн байгаа.

Өнөөдрийн байдлаар биржээр арилжаалагдсан бүтээгдэхүүний 35 хувь нь эзэндээ хурч очоогүй байгаа ийм мэдээтэй байгаа. Тэгээд бид үүнийг ирэх жилийн 2024 оны багцаандаа ямар ч байсан хүргэлтээ 100 хувь болгочих юм бол биржийн үйл ажиллагаа цаашаа эрчимтэй явах бололцоо байна.

Г.Ганболд: Тийм. Яг зөв. Т.Энхтүвшин гишүүний хэлж байгаа зөв шүү дээ. Түрүүн Ж.Ганбаатар сайдын хэлж байгаа ч гэсэн. Ерөөсөө энэ биржээр арилжиж байгаа нүүрсэндээ коридор гаргаж өгөх нь чухал байхгүй юу. Тэгэхээр тэр Базараагийн зам гээд түрүүн ярьсан. Тэр талаар нэг тодорхой мэдээлэл өгөөдхөөрэй. Дараа нь. Т.Энхтүвшин гишүүн тодруулъя.

Т.Энхтүвшин: Тэгээд үндсэн чиглэл дээр ер нь нэг анхаарах ёстой юм байна лээ шүү. Үндсэн чиглэлдээ тодотгол оруулдаг юм уу яадаг юм. Тэгээд энэ олон цахилгаан станцуудаа олон нийтийн юм болгочих юм бол бас нэлээн хүндрэлтэй л юм болох байх. Энэ зам арчлалтын компани чинь ч нэлээн тодорхойгүй л юм байна лээ. Харин үүнийхээ оронд юу гэдэг юм эрдэс баялаг, нүүрс олборлож байгаа ч гэдэг юм уу, жонш олборлож байгаа ч гэдэг юм уу ийм төрийн өмчтэй компаниудаа л яаралтай олон нийтийн болох ажлыг л яаралтай эхлүүлэх хэрэгтэй. Одоо иргэдийн хүсээд байгаа юм нь л ерөөсөө л тэр шүү дээ.

Хоёрдугаарт, биржийн хүчин чадлыг нэмэгдүүлэх. Ялангуяа аль болох их л эрдэс баялгийг л биржээр зарах. Тэгээд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг биржээр зарах, биржийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр л бид их онцгой

анхаарах ёстой юм билээ. Бид үүгээр л явна. Цаашидаа.

Гуравдугаарт, биржийн нэр хүндийг өсгөх. Биржээр зарагдсан бараа бүтээгдэхүүн цаг хугацаандаа хилийн цаана гардаг байх.../минут дуусав/

Г.Ганболд: Ж.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Ганбаатар: Т.Энхтүвшин гишүүнтэй санал нэг байгаа. Ер нь манай улсын уурхайн салбарын ирээдүй бирж байгаа л даа. Бирж үнэ өсгөх гээд байгаадаа биш л дээ. Бид дотооддоо байгаа асуудлуудыг цэгцлэх, бусад улсад байхгүй асуудал манайд байна л даа.

Тийм учраас худалдан авч байгаа тал нь үнээ өсгөх гэж байгаа юм шиг л байдлаар хараад байгаа. Тэрийг бид шат шатанд нь ойлгуулж байгаа. Баян Базараагийн зам гээд байгаа энэ зам бол үнэхээр. Сая Засгийн газар дээр хоёр долоо хоногийн өмнө танилцуулсан. Энэ компани өөрөө маш их өртэй юм билээ. Европын Хөгжлийн банканд өртэй. Тэгээд шүүхийн шийдвэр гарчихсан. Монгол Улсын болоод шат шатын шийдвэр гарчихсан. Ийм учраас Эдийн засгийн хөгжлийн яамыг цуцалчхаач гэхээр буцаад баахан хөрөнгө оруулалт орчихсон. Тэгээд хугацаа хэрэгтэй байгаа гээд. Манай нэг тендерийн хууль чинь нэг ийм эргүүлэгт ороод түгжигдчихдэг ийм юм руугаа л орчихсон юм билээ. Тэгээд үүнийг л хурдан шийд шийдвэрлэх хэрэгтэй. Тэгвэл уг нь яг цаад хил дээрээ.../минут дуусав/

Г.Ганболд: Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Сая АЗЗА-гийн талаар хэд хэдэн гишүүд лавлаад асуух шиг болж байна. Миний хувьд дахиад нэг лавлачих юм уу гэж бодоод. АЗЗА-гийн одоогийн энэ шинэ бүтэц ер нь ямар байдалтайгаар цаашиаа ажиллах юм? Ер нь Та бүхэн маань яг яаж харж байна.

АЗЗА-нуудынхаа 34 хувийг хувьчилъя гээд Улсын Их Хурлаас шийдвэр гарчихсан байгаа шүү дээ. Тэгээд үүнээсээ л болсон. Тэгээд том нэг компани болгоод ингээд шийдэл Та бүхэн маань гаргаад Засгийн газар дээр ярилцаад явчих шиг боллоо. Миний хувьд хувийн аж ахуйн нэгжүүд дээрээ бид түшиглэх ёстой л гэж боддог юм. Сайд байхдаа “АЗЗА”, “МИАТ” хоёрыг хувьчилъя гэж орлуулж байсан байхгүй юу. Тэгээд тэр Улсын Их Хурлаар нэг их дэмжигдээгүй.

Тэгэхээр цаашидаа орон нутагт нэг ч гэсэн зам ашиглалтын, зам арчлалтын ийм компани байх ёстой. Зарим аймгууд дээр боломж бололцоотой л байдаг байх. Зарим аймгууд дээр тэр болгон замын компанитай аймгууд бас юу л байгаа бол. Хүрэлцээ багатай байдаг шүү дээ. Тэгээд тэр утгаараа АЗЗА гээд ерөнхийдөө төрийн бодлогоор бойжуулаад өнөөдрийг хүртэл явчихсан юм бол үүнийгээ хувьчилчихад болохгүй зүйл байхгүй л гэж боддог юм л даа. Тийм болохоор үүнийг хувьчлах юм уу, эсвэл томоор нь хувьчлах уу, хувьчлалын талын талын ийм бодлого наад АЗЗА дээр чинь байна уу, үгүй юу. Ер нь тэгээд аливаа зүйл томроод л баахан гар сарвуутай болоод л, салбаруудтай болоод л, 21 аймагт салбартай болоод л ингээд ирэхээрээ юм дамнуурах тал руугаа л орчих гээд байдаг шүү дээ. Үнэгүйдүүлэх, ажил хариуцлагагүй болох ийм тал руугаа л орох гээд байдаг. Тийм болохоор цаашдынх нь ирээдүй ер нь яаж харагдаж байна гэж.

Хоёрдугаарт, сая би хэлсэн. МИАТ-ийн хувьчлалын бодлогын талаар ер нь бодож байгаа зүйл байна уу, үгүй юу. Ер нь салбарын яам ч энэ талаараа бодож байх ёстой. Бид “МИАТ” компани гээд үндэсний авиа тээвэрлэгч гээд дээш нь өргөөд яваад байдаг. Болохгүй зүйл байхгүй. Дээш нь өргөөд дэмжээд явах нь зүйтэй. Гэхдээ үүний чинь далбаан доор цаана чинь нөгөө бусад хувийн аж ахуйн нэгжүүд чинь

дарагдаад, бусад хувийн аж ахуй нэгжүүд чинь дээшээгээ босох боломж бололцоог нь бид давхар дараад яваад байгаа байхгүй юу. Тэгээд бид иргэний агаарын тээврийн либералчлал гээд явуулсан. Энэ хүрээндээ нэлээн амжилт олсон шүү дээ. Бид нар. Тэгээд цаашидаа МИАТ-ийн хувьд Та бүхний бодлого ер нь ямар байгаа вэ? Яаж явж байна гээд. Үүнтэй уялдаад Та бүхний хэлсэн үгэнд чинь ороод явчих шиг боллоо. Тэр Хөдөө аж ахуйн биржийн тухай асуудал. Хөдөө аж ахуйн биржийг ер нь цаашидаа бодлогыг нь яая гэж бодож байгаа юм. Бид хөдөө аж ахуйгаа биржээрээ дамжуулаад худалддаг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд биржээр худалдаалдаг болох энэ том бодлогоо гаргаж ирсэн. Үүнийг бид хийхээс өөр зам байхгүй. Ухрах асуудал бид нарт байхгүй.

Тэгэхээр хөдөө аж ахуйн биржээ маш зөв зүйтэй явуулна. Сая явуулах ёстой. Сая бид Уурхайн биржийн тухай хууль гаргаад явсан. Энэ үр дүнгээ өгч байгаа шүү дээ. Яг үүний цаашаагаа хөдөө аж ахуйн биржээр бүтээгдэхүүнүүдэд нь зарагддаг болох. Тэгээд нөгөө бэлтгэн нийлүүлэлтийн схемийг сайжруулж байж бид Хөдөө аж ахуйн бирж бүрэн утгаараа ажиллах ёстой. Энэ дээр ямар бодлоготой байгаа вэ?

Нөгөөтээгүүр Уул уурхайн сайд сууж байна. Давхар хариулах байх. Уул уурхайн бирж маань хэзээ байгуулагдах вэ? Одоо яг энэ бүтцээрээ цаашаагаа хэр удаан үргэлжлээд яваад байх юм. Ер нь бие даасан уул уурхайн бирж байгуулах ёстой. Миний ойлголтоор 07 сарын 01-нээр байгуулагдаад явах ёстой. Санхүү хөрөнгө мөнгө нь хэр байж байгаа юм? Ямар байдлаар төсөөлөгдөж байгаа юм. Ер нь цаашаа Уул уурхайн бирж маань дангаараа бие даагаад байгуулагдах юм уу, эсвэл саяын явж байгаагаар давхар хөрөнгийн бирж дээрээ явчих гээд байна уу? Энэ талаар хариулж өгөөч. Баярлалаа.

Г.Ганболд: Ж.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Ганбаатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь хувийн хэвшил үүнийг хийчихье гээд яваад байгаа байхгүй юу. Бид хийж чадна гээд. Тэгэхдээ энэ бэлэн платформ, нөгөө программ хангамж. Тийм ээ. Үүнд нь бараг 20 тэрбум, 30 тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй. Анхны тооцоолол нь. Тэгээд хувийн хэвшил орж ирээд ярьж байгаа зүйл нь дандаа нүүрснээс тодорхой. Тийм. Бас л нэг ийм нэг сонин яриа үүсэх магадлалтай. Юу гэдэг юм бэ дээ. Яаж ойлгуулах вэ гэдэг ийм сонин үед. Аягүй тэр 0.3 ч гэдэг юм уу, тэг зууны хэд ч гэдэг юм. Яаж ч тайлбарласан гэсэн энэ өөрөө бас нэг тийм, юу гэдэг юм дээ. Амнаас гарахгүй байна л даа. Нэг ийм сонин байдал нийгэмд үүсгэх магадлалтай. Гэхдээ үүнийг Х.Алтай захирал Хөрөнгийн биржийг ер нь тусдаа гаргах нь зөв л дөө. Энэ яг сонгодог утгаараа тусдаа гарч байж л. Одоо ер нь Хөрөнгийн биржийг зүгээр уучлаарай авч явж байгаа ганц юу нь манай юу байгаа л гэж. Өөрсдийгөө хэт дөвийлгөж байж магадгүй байх. Нэлээн л өөдөө. Тоон мэдээллийг нь нэлээн татаж байгаа нь. Тэгээд би Х.Алтай захирлын хувьд сайн ажиллаж байгаа. Би энэ биржийн үйл ажиллагаанд оролцохоосоо өмнө Х.Алтай захирлыг сайн ойлгож мэддэггүй. Бас л тоон мэдээллээ өөр өөр ярьдаг. Надад би яг ажлын хэсэг дээр хамтраад ажиллахад Х.Алтай захирал сайн ажиллаж байгаа. Үнэхээр ажил хэрэгч сайн ажиллаж байгаа. Түрүүн солино гээд юу яриад байдгийг би мэдэхгүй байна. Тэгээд өөр хүн ороод ирэх юм бол энэ аягүй бол Уул уурхайн биржийг санаатайгаар хойш нь татах гэж байгаа ийм байдал байгаа болов уу. Түрүүн Ч.Хүрэлбаатар сайд засаг дээр ярьж байна лээ. Үүнийг одоохондоо хөдөлгөх, ийм байдалтай болгож болохгүй. Сайн явж байгаа дээр нь сайхан дэмжээд цааш нь явах ёстой гэж. Тэгээд Ж.Бат-Эрдэнэ гишүүн надаас

хариултаа авсан байх. Би зүгээр яах вэ хувьчлаад танд нэг тодорхой зүйлүүдийг хэлье. Гэхдээ арай л хугацаа нь болоогүй байна л гэж бид үзэж байгаа юм. Тийм.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 2. Ж.Ганбаатар сайд болоогүй бол түр байж байгаарай. Би бас хэдэн юм уг нь тодруулмаар л байна.

Б.Цэнгэл: Яах вэ бид энэ АЗЗА-гийн талаар тал талаас нь засаг дээр ярьсан. 4 хувилбар ярьж байсан. Ямар хувилбар ярьсан бэ гэхээр ер нь АЗЗА-нуудыг тус тусдаа 34 хувийг биржээр олон нийтэд арилжих нэг хувилбар байна. 20 АЗЗА-г нэгтгэж 34 хувийг биржээр дамжуулан олон нийтэд гаргах нэг хувилбар ярьсан. 20 АЗЗА дээр нэмэх нь 12 хувийн АЗЗА-тайгаа нэгтгэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтарсан групп компани байгуулах бас нэг хувилбар байж болох юм. Дөрөв дэх хувилбар нь 20 АЗЗА компаниудыг бүр хувьчилчихъя гэдэг ийм 4 хувилбар ярьсан юм. Гишүүн ээ.

Ингээд ярьж ярьж байгаад бид засаг дээр энэ 4 хувилбараас бидний нөгөө групп компани болгоод нэгтгэх энэ хувилбар дээр тогтсон юм. Яагаад бид ингэж тогтсон бэ гэхээр ерөөсөө л нөгөө Их Хурлын үндсэн чиглэл батлагдчихсан, Засгийн газрын жагсаалт батлагдчихсан учраас 34 гэдэг хувь дээрээ л ерөнхийдөө тээглэчихсэн. 1-1.5 тэрбум төгрөгийн активтай 20 ийм тархай бутархай компани дээр IPO орж ирэх хувилбар нь их магадлал багатай. Нөгөө нэг асуудал нь системийн 5 банкиг Их Хурал дээр ярьж байх явцад нэг болон нэгдмэл сонирхолтой этгээдэд 5 хувиас илүү хувь авч болохгүй гэдэг ийм заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орчихсон шүү дээ.

Тэгэхээр өөрөөр хэлбэл нэг АЗЗА-гийн 34.0 хувь дээр орно гэдгийг тооцоод үзэхээр 60-аас 70 саяын юманд л орох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хэн сонирхох юм бэ. Сонирхох хүн ховор

шүү дээ. Тийм учраас ерөөсөө энэ маань маш бүтэлгүй болох юм байна гэж үзээд ерөөсөө нэгтгэх юм бол 40 гаруй тэрбум төгрөгийн активтай болох юм байна. Ингээж байж 34 буюу Их Хурлын үндсэн чиглэлийг нь авч гаръя л гэж бид үзэж байгаа юм. Ямар үр дүн гарах юм бэ гэж асууж байна. Их чухал асуулт л даа.

Тэгэхээр бид эндээс зүгээр би багцлаад л нэг хэдхэн л юм хэлье гэж бодож байна. Яривал зөндөө л юм ярьж болохоор байна. Мэдээж хөрөнгийн актив нь нэмэгдэнэ гэдэг нь нэг асуудал.

Хоёрдугаарт, 20 компанийн 8 ТУЗ, 72 гишүүн байсан шүү дээ. 72 гишүүн байсан. Хараат бус 24. Төрийн төлөөлөл 48 гээд. Тэгэхээр үүнийг бид ерөөсөө татан буулгаад нэг л ТУЗ-тэй болгож байгаа. 9 хүнтэй. Үүнийг нь бид сая бүгдийг нь нээлттэй сонгон шалгаруулалт Засгийн газраас баталсан тэр журмын дагуу шударга нээлттэйгээр явуулчихсан. Бүтэц орон тоо оновчтой болж зардлын хэмнэлт гарах юм. Гараад явж байгаа. Эхнээсээ. Энэ бол одоо бас үр дүн гэж харж байгаа юм. Бид нар. Зам засвар, арчилгааны чанар, норм стандарт, хууль эрх зүйн орчин үүнийгээ дагаад сайжрах учиртай. Энэ чиглэлээр бидэнд бодож байгаа юмнууд бий. Нэгдсэн компаниар IPO гаргах нь хөрөнгө босгох, цаашаа амжилттай болоод хөрөнгө босгох нь боломжтой болох юм байна гэж бид харж байгаа. Нөгөө нэг гол чухал асуудал бол мэргэжлийн боловсон хүчин тогтвор суурьшилтай байх. Улмаар ашиг орлогыг нэмэгдүүлж, энд байгаа ажилчдын цалин хангамж нэмэгдэх. Нөгөө нэг асуудал нь энэ компанийн хөрөнгө оруулалтыг өгөөжтэй болгох, замбараагүй энд тэндээс баахан юм авдаг шүү дээ. Тэр юмнуудыг нь цэгцтэй нэг бодлогоор явуулах ийм их олон давуу тал уг нь байгаа юм. Тэгээд бид үүнийг та бүхэндээ ер нь үүнийг их сайн тайлбарлаж тайлагнах ийм цаг хугацаа бидэнд гарах байх гэж бодож байна. Одоо зүгээр толгой компани дөнгөж

байгуулагдаад явж байна. Өнөөдөр бид 16.00 цагаас Зам, тээврийн хөгжлийн яамныхантай, сайдтай бид уулзалт хийх гэж байгаа. Ажил төрлийн. Ингээд ер нь замынхаа асуудал, зам арчилгааны компанийнхаа асуудлын талаар нэлээн юмнууд ярина.

Тэгэхээр энэ дээр Их Хурлын гаргасан үндсэн чиглэлийг л бид хэрэгжүүлж байгаа учраас үүнийг явна.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 2 номерыг өгье. 1 минутаар өгье.

Б.Цэнгэл: “МИАТ” дээр бид МИАТ-ийнхэнтэй нэлээн ажиллаж байгаа. МИАТ-ийнхэн дараагийн Их Хурлын үндсэн чиглэлд орж IPO гаргах бэлтгэл рүүгээ орчихсон байж байгаа. Зөвлөх үйлчилгээнүүд аваад ажиллаж байгаа. Ер нь бид МИАТ-ийг өмнө нь оруулах гэж байгаад КОВИД-ын үеэр “МИАТ” алдагдалтай ажиллачихсан. Алдагдалтай ажиллачихсан. Одоо энэ жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 30 гаруй тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах ийм дүр зураг ажиглагдаж байгаа. IPO гаргах асуудал өөрөө маш олон үзүүлэлтүүдийг шаарддаг. Хэрэв компани өөрөө алдагдалтай муу байх юм бол мэдээж үүнийг сонирхохгүй шүү дээ. Тийм учраас ямар ч байсан энэ алдагдлыг нь бууруулж ашигтай байдал руу авчрах нь зүйтэй гэж гаднын зөвлөх компаниудтай хамтарч ажиллаж байна. Ингээд үүнийг бид яг таны хэлсэнчлэн бид МИАТ-ийг.../минут дуусав/

Г.Ганболд: Б.Пүрэвдорж гишүүн асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нүүрсний хулгай гарсан. 40 их наяд төгрөгийн хохиролтой гэж байгаа. 44 ч гэдэг. Тэгээд үүнийг сүүлдээ 44 их наядаа бас тодорхойлж чадахгүй байгаа юм. Би үүнийг нь тодорхойлоод өгчхөж болно гэж байгаа юм. Энэ бол ерөөсөө л төрийн өмчийн компани дээр гарч байна

гэсэн үг. Тэгэхээр энэ төрийн өмчийн компани дээр яагаад ийм хулгай гарч байна вэ гэхээр хэн нэгэн Их Хурлын гишүүн, хэн нэгэн сайд нарын цүнх барьдаг нөхдүүд тэнд очоод дураараа дургисантай холбоотой байхгүй юу. Өөрийн өмчөөс долоон доор үзэж тэр компанийг бүр дампууртал нь ингэж л явсны үр дүнд энэ хулгайнууд гарч байгаа. Төрийн өмчийн компаниуд бүгдээрээ хамгийн супер бизнесийг хийж байгаа. Тэгээд тэндээ ашигтай ажиллаж чадахгүй байгаа нь гол нь л тэр цүнх баригчтай нь холбоотой.

Тийм учраас энэ их хулгай гарсан. Тэрнийгээ өнөөдөр хулгай гарсан гэж яриад байгаа боловч эрх баригч нар яаж засах тухай өнөөдрийг хүртэл ерөөсөө ярихгүй байгаа. Үүнийг засах гол асуудал бол ард иргэд болон хувийн хэвшлийнхэнд тодорхой хувь эзэмшүүлэх замаар иргэдийн хяналтыг, хувийн хэвшлийн хяналтыг төрийн өмчийн томоохон компаниуд дээр оруулах нь хамгийн чухал гэж үзсэн. Тийм учраас 07 сарын 06-ны өдөр Эрдэнэт үйлдвэрийн 20 хувийг Монголын нийт ард иргэдэд үнэгүй эзэмшүүлэх, 20 хувийг нь Монголын үндэсний аж ахуйн нэгжүүд, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтан, албан хаагчидтай үндэсний компаниудад 20 хувийг нь тодорхой үнээр борлуулж эзэмшүүлэх ийм тогтоолын төслийг өргөн барьсан. Ингэснээр нэг зүйл бий болно. Өөрөөр хэлбэл цүнх баригч нар тийшээ шууд томилогдох боломж нь Компанийн тухай хуулиар хаагдана. Өөрөөр хэлбэл 40 хувийг нь эзэмисэн тохиолдолд тэр ард иргэдийн болон хувийн хэвшлийн компаниудын тодорхой төлөөлөл оролцсон төлөөлөн удирдах зөвлөлөөс энэ компанийн удирдлага нэгдүгээрт сонгогдоно.

Хоёрдугаарт, ард иргэд энд хяналт тавих бүрэн боломж нь нээгдэх юм. Энэ оны эцсээр Эрдэнэт үйлдвэр 1.3 их наяд төгрөгийн ашигтай ажиллана. Энэ нь 20 хувь гэхэд 260.0 тэрбум төгрөг ард иргэдэд очиж байгаа. 3 сая 400

мянган иргэдтэй хуваахаар ойролцоогоор 80 мянган төгрөг очиж байгаа. 5 бүлтэй айлд 400 мянган төгрөг очиж байгаа. Тэр 400 мянган төгрөг авч байгаа тэр иргэн тэр компанийнхаа үйл ажиллагаанд илүү сайн оролцох, хяналт тавих ийм нөхцөл бүрдэнэ л гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл тэр цүнх баригч нар очиж тэнд дураараа дургисан тэр бүх зүйл бүгдээрээ хяналтад орсны үндсэн дээр компанийн борлуулалт, худалдан заавалтууд бүгдээрээ тэр хувийн хэвшлийн компаниудын нүдэн дээр болох учраас энэ компанийн ашигт үйл ажиллагаа илүү нэмэгдэнэ гэсэн ийм тооцоолол гарсан байгаа. Ингэж байж бид төрийн өмч дээр гарч байгаа энэ их хулгайнуудыг бүгдийг нь цэгцлэх ийм нөхцөл байдлыг бий болгох юм. Ардчилсан намын даргаас би үүрэг авсан. Өөрөөр хэлбэл яг энэ асуудлыг ард түмний толгойд ортол нь бүгдийг нь ярьж өгөөч ээ. Ингэж байж бид ард иргэддээ өөрсдөө 6.2-ын дагуу баялгийн эзэн болсон тэр хүмүүсийгээ энэ баялагтаа эзэн болох тэр урам зоригийг нь сэргээж өгөх тийм бодлогыг нь гаргаж өгөх тэр бүх зүйл дээр нь ажиллаач гэж ийм үүрэг авч байгаа. Тэгээд энэ дээр ер нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар ямар байр суурьтай байгаа юм бэ? Цаашидаа яаж ажиллах юм? Төрийн өмчийн компаниудыг хувьчлах талаар ямар бодлого баримталж байгаа юм бэ гэдгийг асууя.

Г.Ганболд: эхний хэсэг өөрөө санал юм байна. Цаашидаа өргөн барих гэж байгаа хуулийн талаар ярих шиг боллоо гэж ойлголоо. Тогтоолын төсөл өргөн барих гэж байгаа юм байна гээд. Ерөөсөө төрийн өмчит компаниудын хувьчлал дээр ямар бодолтой байгаа вэ л гэсэн асуулт байна. Ажлын хэсгийн 2 номер.

Б.Цэнгэл: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Төрийн өмч бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл. Би түүрүүн мэдээллээр хийсэн. Түүн дээр

ерөнхийдөө ярьчихсан байгаа. Тэгээд дахиад үүнийгээ давтаад ярья. Тэгэхээр яах аргагүй Үндсэн хуулийн 6.2-ын заалтыг бид хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр Үндсэн хуулийн 6.2-ыг хэрэгжүүлэхэд баялгийн сангаар дамжуулаад иргэддээ уул уурхайн салбарын өгөөжийн дийлэнх хэсэг нь оногдох ёстой гэдэг энэ л зарчим байж байгаа юм. Тэгэхээр энэ зарчмыг бид уг нь хэрэгжүүлэхдээ хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт орох, зарим нэгэн хуулийг анхдагч хууль болгож гаргах асуудал засаг дээр яригдаад явж байгаа. Баялгийн сангийн хууль нэлээн идэвхтэй байдал руу орчихсон явж байгаа юм билээ.

Нэг дэх асуудал. Бид баялгийн сангийн хуулиа хүлээхгүйгээр угтуулаад ямар ч байсан энэ компаниудынхаа юмыг янзалъя гэсэн юм. Энэ агуулгаараа бид уул уурхайн чиглэлийн компаниудыг нэгтгээд “Эрдэс Монгол нэгдэл” гэдэг корпорацийн бүтцийг бий болгоод дотроо групптэй. 40 гаруй компани орж байгаа байх. Тийм ээ. Манай “Эрдэс Монгол”-ын захирал энд сууж байна. Нэмэлт мэдээлэл өгөх байх. Ингээд нэг ёсондоо яг тэр Баялгийн сангийнхаа юмыг суурь болгоод явж байгаа юм. Тэгэхээр энэ бол бас үр өгөөжөө өгнө байх гэж бид харж байгаа. Дунд болон урт хугацаанд нь шүү дээ. Нөгөө нэг асуудал гэх юм бол бид Эрдэс Монголын компанийн нэгдэлд хамаарахгүй байгаа бусад төрийн өмчийн компаниудыг мөн нэгдлийн зохион байгуулалт оруулах юмыг засгийн хурлаар сая хоёр Засгийн хурлын өмнө оруулаад танилцуулчихсан. Тэгэхээр Засгийн газрын гишүүдийн саналыг тусгаад яригдах юмнууд байж байгаа. Тэгэхээр ямар ч байсан засаглалыг нь сайжруулъя гэж ярьж байгаа. Тийм ээ. Засаглалыг нь сайжруулъя, бүтцийг нь оновчтой болгоё, алдагдалтай байдлыг нь багасгая, олон нийтийн хяналттай болгоё гэдэг асуудлуудыг бид дэс дараатай хийх юм.

Яг одоо олон нийтийн хяналттай болгох асуудлыг ерөөсөө л хөрөнгийн биржээр дамжуулаад ер нь цаашидаа явж хийе. Хөрөнгийн биржээрээ дамжуулаад нээлттэй, иргэдэд тодорхой хувьцааг нь гаргадаг энэ л жишиг рүү явъя гэж харж байгаа юм. Энэ агуулгаараа бид сая үндсэн чиглэл батлахдаа 25 компани, дээр нь Төрийн банк нэмэгдээд 26 гээд явж байгаа шүү дээ. Тэгээд энэ асуудал ингээд явж байна. Ер нь бид яаж байгаа гэхээр гишүүнд хэлэхэд ер нь удаан дараагийн Их Хурлын баталсан үндсэн чиглэлд маш олон компаниудын юм хэрэгжээгүй үлдчихсэн юм билээ. Үүнийгээ бид ер нь нэг цэгцлээд ингээд цаашаагаа гарахдаа яг таны хэлж байгаа тухайлбал Эрдэнэт үйлдвэр, Тийм ээ, Монросцветмет, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр, Хөтөл, Багануур, Шивээ-Овоо зэрэг томоохон. Нэн ялангуяа уул уурхайн чиглэлийн компаниудыг ерөөсөө олон нийтийн болгохгүй бол болохгүй юм билээ. Болохгүй юм билээ. Их Хурлын нэг тогтоол байдаг юм билээ. Эрдэнэт үйлдвэртэй холбоотой 10 хувийг нь олон нийтийн болго гэдэг тогтоол ерөөсөө хэрэг бичихгүй явж байгаа. Тухайлбал, бид дараагийн үндсэн чиглэлийг нэгтгэж байгаад хасахыг нь хасаж, нэн ялангуяа саяын нэр дуудагдаад байгаа компаниудыг ер нь оруулж ирнэ гэдэг байдлаар тийм байр суурьтай байж байгаа. Зарим нэг саналаа ч гэсэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр бид ярилцаад явж байгаа. Тэгэхээр энэ дээр бид тодорхой зоримог алхмуудыг хийнэ гэж бодож байна. Баярлалаа.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 1 номер. “Эрдэнэс Монгол”-ын захирал нэмж хариулъя. Дээр нь түрүүн гишүүд ч асуусан. Танай компаниудын хувьчлалын асуудлууд ямар байгаагаас гадна танай “Эрдэнэс Тавантолгой” компанийн биржийн үнээс гадна бусад гэрээнүүд дээр танайх ер нь яаж хяналт тавьж байгаа талаар гишүүд асуугаад байсан. Түүнд хариулъя.

С.Наранцогт: Байнгын хорооны дарга гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр гишүүдийн асуулттай холбоотойгоор ер нь нийлүүлээд нэг мэдээлэл өгчихье гэж бодож байна. Өмч хувьчлал, хувь эзэмшлийн тухай асуудал дээр Ашигт малтмалын хууль дээр стратегийн ач холбогдолтой ордуудын 10 хувийг нь олон нийтэд гаргах тухай заалт байгаа юм. Нэгдүгээр асуудал нь. Хоёрт нь, стратегийн ач холбогдолтой ордуудын жагсаалт гээд 2007 онд Их Хурлын тогтоолын хавсралтаар 39 ордыг гаргачихсан байгаа юм. Тэгэхээр энэ дотор хувийн компаниуд ч байна, зарим нь хөрөнгө оруулалтын гэрээгээр явж байгаа компани. Манай дээр нэмэгдээд “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой”, Шивээ-Овоо, Багануур гэсэн стратегийн ордууд эзэмшиж байгаа компаниуд манай нэгдлийн харьяанд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ нэг стратегийн ач холбогдолтой ер нь энэ бүх ордуудынхаа асуудлыг, үүний хуулийн хэрэгжилтийг хангах тухай асуудал нэг асуудал болно.

Хоёрдугаарт, энэ компаниудаас үр ашиг, өгөөжийг ард иргэд, нийтэд Үндсэн хуулийн 6.2-оор яаж өгөх вэ гэдэг. Тэгэхээр энэ бүх асуудлыг одоо ингээд Их Хурлын тогтоол. Б.Цэнгэл дарга түрүүн ярьж байна. Олон шийдвэрүүд гарсан. Олон санал санаачилгууд яваад байгаа. Тэгээд бид юу гэж үзэж байна вэ гэхээр энэ асуудлаа одоо нэг мөр нэг талд нь шийдэх болчихсон юм байна лээ. Тэгэхээр Баялгийн сангийн хуулийн ажлын хэсгийн ахлагчаар би ажиллаж байгаа. Баялгийн сангийн хууль дээрээ ер нь энэ асуудлаа нэг мөр нэг талд нь шийдэх нь зүйтэй байгаа юм. Яг би тухайлаад нэгдэлтэй хамааралтай хоёр зүйлийг ярихад одоо Эрдэнэс Тавантолгойн 86 хувь нь төрд, үлдсэн нь ард иргэдэд байгаа. 1072 хувьцаа тараасан. Үнэгүй. 1072 хувьцааг 2012 оноос хойш төрсөн хүмүүсийг яах вэ гэдэг асуудал удахгүй Их Хурлын тогтоолоор орж ирнэ. Яг энэ процесс үргэлжлэх юм бол Эрдэнэс Тавантолгойн хувь эзэмшлийн асуудал

хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр энэ нэлээн тийм төвөгтэй байдал руу түлхэж эхэлж байгаа юм. Эрдэнэтийн хувьд гэх юм бол Эрдэнэт бол компани биш улсын үйлдвэрийн газар гэж явж байгаа. Ингээд компани болгоноор яриад ирэхээр тус тусдаа асуудалтай.

Тэгэхээр цаашидаа асуудлаа Их Хурал дээр баялгийн сантай холбоотой нэг талд нь гаргаж шийдээд. Өөрөөр хэлбэл юу гэж шийдэх нь зүйтэй вэ гэхээр энэ үнэгүй хувь эзэмшил ард иргэдэд олгох нь өөрөө нэлээдгүй асуудал дагуулах юм байна лээ. Тэгэхээр ард иргэддээ үр ашгаа яаж өгөх вэ гэдэг концепц Баялгийн сангийн хууль дээр тусчихсан явж байгаа.

Хоёрдугаарт, сая Б.Пүрэвдорж гишүүн яриад байна. Энэ компанийн засаглал үйл ажиллагаатай холбоотой асуудал нэлээд цэгцгүй явж ирсэн. Одоо болохоор ингээд төрийн өмчит компаниуд Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар зарим нь явдаг. Зарим компаниуд нь Компанийн тухай хуулиар яваад байгаа. Тэгэхээр энд хуулийн нэг бүлгийг бид бас тэгж оруулж ирж байгаа юм. Энд орлого төвлөрүүлэгч төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан компаниудын засаглал, үйл ажиллагааг яаж тогтвортой байх юм. Тэрний гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүн, тэдгээрийн тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, түүнтэй холбоотой зохицуулалтуудыг хэрхэн хийх вэ. Тэгээд энэ болгоныг нийлүүлээд бид Баялгийн сангийн хууль дээрээ асуудлуудаа нэг бүрчлэн.../минут дуусав/

Г.Ганболд: Би хэдхэн асуулт асууя даа. Гишүүд ихэвчлэн асуучихлаа. Зам, тээврийн яамны хүмүүс байгаа гэж ойлгож байгаа. Тийм ээ. Зам, тээврийн яамны нөгөө нэгдлийн захирал байгаа юу? Тийм үү? Ер нь хувьчлалын жагсаалт оруулж ирэхдээ эхэлж Төрийн өмчийн хорооноос оруулахаасаа өмнө Засгийн газраа судалж байж оруулахгүй бол маш олон компани оруулж ирчхээд.

Одоо ерөөсөө тэр 2022 оны 4 сарын тогтоолоос чинь хэрэгжсэн нь хөрөнгийн бирж дээр л нэг жоохон юм яваад бусад нь ерөөсөө нэг ч хөдлөөгүй юм байна.

Тэгээд Монголын цахилгаан холбоо компани л гэнэ. “Мэдээлэл холбооны сүлжээ”. Тэгээд хэлбэрийг нь ч олоогүй. 34-ийг болохоор авахгүй гээд яриад яваад байдаг. Би учрыг нь ойлгохгүй байна. 34-ийг авах хүн байна уу гээд зарлахаасаа өмнө ярьж явахаар нөгөөдүүл нь ийм жоохон байвал авахгүй. Нэгмөсөн том болговол л авна гээд байдаг юм уу? Би бүр учрыг нь ойлгохоо байлаа л даа. Тэгээд энэ АЗЗА-гийн хувьчлал гээд. Би эхнээс нь л ярьж байсан юм. Яагаад ийм шийдвэр гаргасныг. Энэ чинь өмнө нь том АЗЗА болгоод дампуураад, жижиг АЗЗА болгоод дахиад дампуураад тэгээд больчихсон бүтцийг буцаагаад яагаад сонгосныг Зам, тээврийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хоёр хэлээд өгөөч. Одоо энэ компани юугаар санхүүжих юм? Одоо энэ том нэгдэл нь. Арчлалтын мөнгөнөөс нь л хэдэн төгрөг авч үлдэж л санхүүжнэ шүү дээ. Одоо хэдэн хүнтэй, ямар бүтэцтэй, ямар байгууллага байгаа юм. Тэгэхээр энэ чинь жижгээр нь хувьчлах юм бол илүү 34 хувийг нь. Энэ чинь ашгийн бус компани байхгүй юу. Ашиг гаргая гэвэл яадаг гэхээр зэрэг эвдэрхий замаа нөхөхгүй бол ашигтай ажиллана. Эвдэрхий замаа нөхөх юм бол. Хэзээ ч. Ашгийн төлөө биш компани байхгүй юу. Эсвэл бүр төрийн өмчит компаниуас нь болиулъя гэдэг юм яваад байхад ийм бүтэц оруулж ирчхээд баталчхаад байх юм. Одоо энэ яадаг юм гэхээр жижиг хорин хэдэн АЗЗА, тэр хувийн АЗЗА-нууд чинь бүгдээрээ энэ нэгдэл дээр ирж, нэг хонины мах чирч ирж байж л жоохон арчлалтын мөнгө салгаж авдаг компани шүү дээ.

Байнгын хорооноос энэ дээр дахиж эргэж хар, энэ хувьчлалын процессуудаа явуул гэдэг чиглэлээр тодорхой тогтоолын төсөл Засгийн газар луу чиглэл өгье гэж бодож байгаа

юм. Өмнө нь хоёр удаа яваад дампуурсан бүтэц рүү ингэж оруулаад байгаа нь яг ямар учиртай юм бэ? Энэ Зам, тээврийн яамны бодлого юм уу, эсвэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын бодлого юм уу гэдгийг би асуух гээд байгаа юм. Нэгд нь.

Хоёрт нь, Уул уурхайн яамны тэр биржийн бусаар явж байгаа гэдэг нь урт хугацааны гэрээтэй. Хамгийн урт хугацааны гэрээтэй хэдэн компани байна аа? Энэ компаниудын гэрээ хамгийн сүүлийнх нь хэзээ дуусахаар байгаа вэ. Одоо яг арилжиж байгаа үнэ. Би С.Наранцогт даргаас асууя. Биржийн үнэтэй харьцуулах юм бол тэр урт хугацаатай явж байгаа гэрээний үнэ хоёрын зөрүү нь яг хэд байна. Энэ гэрээг хүчингүй болгочихъё гэхээр ямар гэрээгээр заасан үүрэг манайх хүлээх болчихоод байна. Энэ дээр хэлэх гээд байгаа юм. Одоо ил болгож чадахгүй байгаа Норенкогийн ч юм уу, Чалкогийн гэрээнүүд байна. Төрийн өмчит компаниуд гаднын компанитай гэрээ хийхдээ дур мэдэж маш ноцтой заалтууд оруулдаг. Одоо Норенкогийн гэрээ яагаад ил болохгүй байна гэхээр аль нэг компанийнхаа зөвшөөрөлгүйгээр гэрээг ил болгох юм бол 100 сая долларын торгууль төлнө гэх мэтчилэн ийм том том заалтууд оруулаад ингээд нийгмээс нуудаг. Энэ зүйлүүдийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар энэ төрийн өмчийн компаниуддаа яаж чиглүүлж явах юм бэ? Ийм гэрээний заалтуудыг төрийн өмчит компаниуд хийж явж яг болох юм уу? Үүнийг асуумаар байгаа юм. Зэсийг биржээр арилжихтай холбоотойгоор зэс харьцангуй нүүрсийг бодох юм бол биржээр явах хамгийн оновчтой бүтээгдэхүүн. Яагаад гэхээр үнэ нь их тогтвортой л доо. Нүүрс маш их хэлбэлзэлтэй. Тэгээд улирлын шинжтэй огцом огцом өөрчлөлт ордог учраас нүүрс яг биржээр явахад хэр оновчтой бүтээгдэхүүн байна вэ? Уул уурхайн биржээр явахад.

Харин зэсээ нэлээн өндөр хувиар явуулах боломж байгаа юу? Зэсийнхээ арилжааг өндөр хувиар. Зөвхөн 10 хувь биш. Тэгээд бүр 50 хувийг нь. Энэ бол тогтвортой учраас ер нь цаашидаа арилжиж үзээд одоогийн урт хугацааны гэрээтэй үнийн хувьд зөрүүтэй байх юм бол богино хугацаанд эд нарыг нэлээн үнийн өөрчлөлтүүд оруулах ийм зүйлүүд байгаа юм. Энэ зүйлүүдийг асуучихъя даа.

Г.Ганболд: Зам, тээврийн яам. Ажлын хэсгийн 3. Ажлын хэсгийн 1 номер.

Ц.Эрдэнэ-Очир: Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын Замын ашиглалт, засварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэ-Очир. Ер нь АЗЗА-гийн хувьчлалаас болоод, Их Хурлын тогтоолоос үүдээд л ингээд 34 хувийг хувьчлах гэдэг асуудлаас нь нэгтгэл болоод л явчихлээ л даа. Манай яамны байр суурийн хувьд бид өмнө нь ярьж байсан шиг нэгтгэж үзсэн, багасгаж үзсэн. Ер нь аль ч асуудалд давуу болон сул тал байдаг. Нэгтгэж үзэж байсан. Энэ дээр бүтэц, зохион байгуулалт шуурхай ажиллах асуудал дээр жоохон доголдолтой асуудлууд гараад байдаг. Зохион байгуулалтаасаа хамаараад. АЗЗА гэдэг компани маань тухайн гартаа онцгой байдал үүсэхэд шуурхай арга хэмжээ авч, захирал нь өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд тодорхой хэмжээнд зээл аваад шийдвэр гаргаад явах боломж уг нь байдаг байсан. Тэгэхээр нэгтгэл болохоор үндсэн толгой удирдлагаасаа чиглэл хүлээгээд ямар зохион байгуулалтаар явах юм. Одоогоор бид нэгтгэлтэйгээ зохион байгуулалт нь ямар байх юм, ямар арга хэмжээ авах юм, сул талуудыг яаж арилгах талаар төлөвлөгөөгөө танилцуул, ямар зохион байгуулалтаар ажиллах гэж байгаа вэ гэдэг дээр яригдаад ярилцаад байгаа. Өнөөдөр 16.00 цагаас уулзахаар ярьж байна. Тэр дээр бид ярилцана. Ер нь

яамны хувьд нэгтгэл болгох асуудлыг дэмжээгүй.

Г.Ганболд: 2 номер. Б.Цэнгэл.

Б.Цэнгэл: Би түрүүн компаниудыг цаашидаа яах вэ гэдэг дээр компаниудыг бид ангилж үзсэн гэж хэлж байгаа. Бид ангилж үзэхдээ ерөнхийдөө заавал ашиг гэж харах ёсгүй. Төрийн өмнөөс заавал энэ үйлчилгээг үзүүлэх шаардлагатай ийм ажил, үйлчилгээний төрөлд АЗЗА-г бид оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл АЗЗА-г бид заавал ашигтай ажиллах гэж шаардах албагүй. Энэ бол өөрөө төрийн өмнөөс энэ зам арчилгааны асуудлыг нийтийн нийтийн архишгийн өмнөөс хийж байгаа ийм л үйлчилгээ байгаа юм. Тийм учраас ангилал нь тэр ангилалд хамаарч байгаа юм.

Нэг дэх асуудал дээр. Их Хурлын үндсэн чиглэл энэ 34 гэдэг дээр нэлээн л маргаан болсон шүү дээ. Тэгж байгаад л 34 дээр алх цохичихсон. Тийм учраас нэгэнт Их Хурлын шийдвэр гарчихсан учраас Засгийн газар шийдвэрээ гаргаад л явж байгаа гэж бид ойлгож байгаа. Тийм. Тэгээд Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг. Олонхоороо Засгийн газар шийдчихсэн бол үүнийг хэрэгжүүлдэг ийм л журамтай. Ер нь Зам, тээврийн яамыг бид ойлгож байгаа. Энэ дээр мэдээж янз янзын байр сууриуд гарна шүү дээ. Гэхдээ ер нь яагаад 34 гэдэг юм гарсан бэ гэдэг. Их Хурлын үндсэн чиглэлийг л хэрэгжүүлэх бид ийм үүрэгтэй. Тийм учраас үүнийг л хэрэгжүүлэхэд яаж эвтэйхэн үүнийг 34 хувиа цааш нь гаргах вэ гэдэг асуудал ярьсан. Нөгөөтээгүүр бид энэ нэгдэл байгуулагдсанаараа ямар ач холбогдолтой талаар би бүр нэг, хоёр, гурав, дөрөв гэж байгаад сая тайлбарласан шүү дээ. Тэгэхээр энэ байр суурь дээрээ байгаа. Ер нь үе үеийн олон бүтцүүд байсан нь үнэн. Бид судалсан. Гэхдээ ер нь энэ дээрээ тухайн яам удирдаж байгаа улсууд, компани удирдаж байгаа улсууд орон нутагтайгаа хэр таарамжтай

ажиллаж байгаа эсэхээсээ л хамаардаг шүү дээ. Та мэднэ. Тийм учраас тухайлбал 2022 оны үзүүлэлтээр.../минут дуусав/

Г.Ганболд: Нутаг мутаг хамаагүй. 3 номерын микрофон өгье. Ингээд асуудалдаа хариулахгүй шал өөр юм яриад яваад байх юм. 3 номерыг өгье.

М.Мэндбаяр: Баярлалаа. Өнөөдрийн танилцуулгад гарсан урт хугацааны. Эрдэнэс Тавантолгой дээр нүүрсний 4 гэрээ байгаа. Хүчин төгөлдөр гэрээ. Хамгийн сүүлийн гэрээ нь бидэнд байгаа мэдээллээр 2027 онд дуусахаар ийм гэрээ байгаа. Зарим гэрээнүүд нь Эрдэнэс Тавантолгойн өөрийн олборлолтын хэмжээнээс хамаарсан хувиар тогтоосон гэрээнүүд байгаа болохоор тэд нар нь хамгийн сүүлийн хугацаа нь 2027 он гэж харагдаж байгаа. Энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” болон “Эрдэнэс Монгол”-оос нэмээд тайлбар байвал С.Наранцогт захирал нэмээд хариулчихна биз. Тийм ээ. Цуцлах тал дээр эрсдэлийнх нь талаар өнөөдөртөө тодорхой мэдээлэл байхгүй байна. Зэсийн арилжаатай холбоотой товчхон хариулахад өнөөдрийн байдлаар мөн адилхан зэс дээр арилжаа явуулах хамгийн боломжтой нь Эрдэнэт үйлдвэр хамгийн түрүүнд байгаа.

Эрдэнэт үйлдвэр мөн адилхан урт хугацааны гэрээнүүд байгаа. Эхний ээлжид бид 10 хувь гэж байгаа. Зэсийн олборлолт 2024 оноос эхлээд Эрдэнэт үйлдвэрийн хүчин чадал өргөтгөгдөж байгаатай холбоотойгоор 100 мянгаас дээш хэмжээний баяжмал экспортлох боломжууд нэмэгдээд эхэлнэ. Тэгэхээр энэ арилжааг урт хугацааны гэрээ дуусгах хэмжээгээр нь нэмэгдүүлээд байх боломж үүсэх байх гэж бид урьдчилж харж байгаа.

Г.Ганболд: Тэр нэгтгэлийн захирал 3 номерын микрофон дээр суугаад бүтэц нь ямар бүтэцтэй юм, санхүүжилт нь яаж явах юм, хаанаас

санхүүжих юм. 3 номерын микрофон өгье.

Б.Наранбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. АЗЗА нэгтгэлийн захирал Б.Наранбат байна. Миний хувьд томилогдсоноос хойш ер нь АЗЗА-нуудын нөхцөл байдлыг судлаад явж байгаа. Бүтцийн хувьд нийтдээ 850 хүнтэй байхаар шийдсэн. Одоо байгаа нийт АЗЗА-нуудын батлагдсан байгаа бүтэц нь өөрөө 850 хүний бүтэцтэй юм билээ. Тэгээд тэр орон тоог тэр хэвээр нь баталсан. Санхүүжилт нь өөрөө засвар арчлалтын гэрээгээрээ явна. Ингэхдээ энэ бол өөрөө нэг л компани. Бусад тэнд байгаа үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд салбар нэгж болж ингэж явахаар бүтцээ батлуулсан.

Г.Ганболд: Энэ маш буруу тогтолцоо шүү дээ. Б.Цэнгэл ээ. Ашгийн төлөө бус компанийг томруулж байж 34 хувийг нь хүн авна гэж та нар тийм байдлаар оруулж ирдэг чинь маш буруу шүү дээ. Үүнийг Байнгын хорооноос эсэргүүцэх ёстой. Би энэ дээр тогтоолын төсөл гаргана гэсэн бодолтой байгаа. Юун 850 хүний бүтцээр батлах, юун аймгуудынхаа компанийг оруулж батлах. Тийм балай юм байж болохгүй шүү дээ. Наадах чинь. Одоо бүр сүүлдээ цалингийн индекс тавих юм байна шүү дээ. Тэр орон нутгийн АЗЗА-гуудын цалинг. 2 номерын микрофон өгье.

Б.Цэнгэл: Сая Б.Наранбат захирал арай өөр өнцгөөс нь ярьчих ишг болно лээ. Ер нь толгой компанийн бүтцийг 22 хүнтэй баталсан. Юугаар санхүүжих юм бэ гэхээр бид яах вэ менежментийн төлбөрийг нэг хүртэл хувь гэж ярьж байгаа. Гэхдээ үүнийг харилцан адилгүй байдлаар ингээд зохицуулна гэж үзэж байгаа. Дүрэмд ингэж орсон. Одоо байгаа төрийн өмчит 20 АЗЗА салбар хэлбэрээрээ үйл ажиллагаа явуулж байгаа юм. Тийм. Ийм байна.

Г.Ганболд: Зам, тээврийн яамны арчлалтын дарга ярь даа. Одоо энэ жил арчлалт дээр 60 орчим тэрбум байгаа юу? Хэд байгаа юм. Тэрийг танай яам шууд хуваах уу? Шууд бүх хөрөнгийг нь өгч байгаад толгой компани дээрээ хувааж явах юм уу?

Ц.Эрдэнэ-Очир: Зам, тээврийн яам улсын төсөв дээр буюу авто замын санд тавигдсан хөрөнгийг замын урсгал засвар болон ээлжит засвар, бусад тоног төхөөрөмж гээд ингээд хуваарилдаг. Энэ жил өнгөрсөн жилтэй адилхан улсын төсөв дээр 56.0 тэрбум төгрөг хуваарилагдсан байгаа. Үүнээс яг засвар арчлалтын чиглэлээр буюу замын ашиглалтын бэлэн байдлыг хангах чиглэлд өнгөрсөн жил 36.0 тэрбум төгрөгийг бид нийт АЗЗА нартаа хуваарилсан. Замынх нь уртаас хамаараад. Тэгээд энэ АЗЗА компани болгонтой гэрээ байгуулж байсан бол энэ жил хуваарилалтынхаа дагуу хэрэв нэгдсэн нэгтгэл болох юм бол нэгдэлтэйгээ гэрээ байгуулаад нэгдлээс салбар нэгжүүд рүүгээ 36 тэрбумынхаа хуваарилалтыг хийх байх л гэж харж байна.

Г.Ганболд: 1 номерын микрофоныг өгье.

С.Наранцогт: Г.Ганболд даргын асуултад хариулъя. Энэ 4 том гэрээ гээд байгаа нь Чалкогийн гэрээ нь 2028, Иком гэж компанитай байгуулсан гэрээ 2025, Жайюу гээд 2026, Глори гээд 2027 онд дуусах ийм 4 гэрээ байгаа юм билээ. Түрүүн Ж.Ганбаатар сайд хэлсэн. Яг ний нуугүй хэлэхэд одоогоор “Эрдэнэс Тавантолгой” компани дээр Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч томилогдож ажиллаж байгаа. Тийм учраас яам болоод толгой компанийн зүгээс яг энэ гэрээтэй холбоотой энэ дотоод үйл ажиллагаанд аль болох оролцохгүйгээр ажиллаж байгаа. Үнийн хувьд урт хугацааны гэрээнүүд дээр ер нь нэлээдгүй тийм хатуу нөхцөлтэй гэрээнүүд хийсэн гэсэн ийм ойлголттой

байгаа. Гэрээнүүд нууцлалын түвшинд байдаг учраас яг доторх нөхцөлүүдтэй нь танилцаагүй. Үнийн хувьд нэг жишээ авахад эдгээр 5 Хятад улсын бирж нүүрсний индексээр улирал бүр үнээ шинэчилж явдаг юм байна лээ. Тэгэхээр дундаж тооцоогоор 83 орчим доллар гарч ирж байх шиг байгаа юм. Биржийн зарагдаж байгаа үнэ 120 доллар. Тэгэхээр 40 орчим долларын зөрүү энэ гэрээнүүд дээр байгаа. Тэгээд гэрээний нөхцөлийн хувьд нууцлалтай. Тэгээд тэр гэрээ цуцалсан тохиолдолд нэлээн хатуу нөхцөлүүдтэй юм байна гэж ойлгогдоод энэ 4 гэрээг цуцалж чадахгүй яваад байгаа юм байна лээ. Дээр нь нэмээд төмөр замын бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэр, газрын тос дамжуулах хоолойтой холбоотой офтейк гэрээнүүдийн хэрэгжилт мөн ялгаагүй нэлээн хатуу бөгөөд үнийн хувьд бас өмнөх гэрээнүүдтэй адил зохицуулалттай явж байгаа гэсэн үг.

Г.Ганболд: Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн байвал нэрсээ өгье. Б.Пүрэвдорж гишүүнийг оруулаад Б.Пүрэвдорж гишүүнээр тасалъя. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр Уул уурхайн биржийн хуулийнхаа хэрэгжилтийг нэлээн сайн эрчимжүүлж, арилжаа нь ингээд Хөрөнгийн биржээрээ явж болдог юм байж. Тэгвэл уул уурхайн биржийн өөрийнх нь тэр ложистик юуных нь асуудлыг бид бие даалгаж шийдэх ёстой. Үүнийгээ нэг бодмоор тухай асуудал байна гэж. Нэг.

Хоёрдугаарт, биржээр борлогдож байгаа бүтээгдэхүүний чанар, ангиллын тухай асуудал байгаа юм. Энэ нь өөрөө хаа хаанаа эргэлзээгүй байж энэ биржийн бүтээгдэхүүний борлуулалт, итгэл үнэмшил цаашид илүү нэмэгдэж явах ёстой.

Тийм учраас энэ дээр нэг онцгой анхаарал хандуулах ёстой гэж.

Гуравдугаарт, ерөөсөө тэр урт хугацааны гэрээнүүдийг яаж энэ улс орны эрх ашигт нийцүүлж өөрчилж шинэчилж болох юм. Тэрийгээ судалмаар байна. Түүгээр гарах бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнүүдийг бүгдийг нь энэ уул уурхайн биржээр борлуулах арга хэмжээг авах ёстой. Тэгж байж бид уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах бололцоо боломж бүрдэнэ гэж хэлмээр байна. Корпорац хэлбэр лүү зохион байгуулагдаад доороо баахан компаниуд нэгтгэгчээд байгаа. Тэгэхээр тэр толгой компани энэ салбаруудынхаа үр ашгийг дээшлүүлэх чиглэл дээр тавьдаг хяналт, менежментийн асуудал их чухал үүрэг л гүйцэтгэх гээд байгаа юм даа. Би тэгж л хараад байгаа. Тэгэхээр энэ төрийн өмч, төрийн өмчит компаниуд гэдэг юм уу, ер нь энэ компанид энэ талынх нь харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын шинэ зохицуулалтаа маш яаралтай хийхгүй бол бидний өнөөдөр мөрдөж байгаа хууль тогтоомжоор яг ингээж зохицуулагдсан харилцаа байхгүй шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид ер нь маш яаралтай тодорхой болгох ёстой болов уу гэж ингэж би бодоод байх юм. Энэ төрийн өмчийн бодлого зохицуулалтынхан энэ дээр ер нь нэлээн онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой байх. Тэгж байж энэ зүйл чинь өөрөө их бодитой, үр дүнтэй юм болох ёстой гэж би хараад байна шүү дээ. Амны үнэ, хил нөхцөл хоёрыг тооцоод үнийн өсөлт жоохон гарсан. Үнэн. Тэр дотор амнаас хил хүртэлх зардлын асуудал байгаа юм. Тэгээд цэвэр өсөлтийн үнэ цэн ер нь ямар юм байгаа юм бэ? Үүнийг л бид улам нэмэгдүүлэх ёстой. Тэгэхээр уул уурхайн салбар дээр тээвэрлэлт, хөрс хуулалт, өөр ямар туслан гүйцэтгэх үйл ажиллагаанууд байгаа юм. Үүний нэгжийн үнэ тариф, тэгээд нээлттэй сонгон шалгаруулалт. Энэ замаар л бид өөрийн өртөг гэдэг

юмыг хямдруулах ийм бололцоо боломжууд бүрдэнэ. Тэр өртгийн сүлжээ гэдэг юм чинь ер нь ямархуу байдлаараа явах юм бэ гэдэг юмыг ихээхэн онцгой анхаарч хянахгүй бол энэ бидэнд тийм ч амар зүйл биш л байгаад байгаа. Тоо харахаар тоо харагдаад байдаг. Гэтэл яг дотор нь ороод задлаад хөөгөөд явахаар зэрэг яг үр өгөөж талаасаа ямар тоо илэрхийлэгдээд байгаа юм гэдэг юм чинь бидний ихээхэн гол чухал зүйл байгаад байгаа шүү. Үүнийгээ нэлээн онцгой анхаарч ажиллах ёстой байх гэсэн ийм л зүйл байна.

Г.Ганболд: Ж.Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн өмчийн бодлого зохицуулалтынхан өөрсдийнхөө арга барилаас жоохон салмаар байна. Төр л сайн менежер. Та хэд л их мундаг. Та хэдийн л зохицуулалт байх ёстой. Бусад нь орон нутаг юу гэдэг юм, хувийн хэвшил нэг мөнгө хөөсөн хэдэн хүмүүс байдаг. Та хэд л ухаантай, төрийн зохицуулалтыг авч явдаг, гардаж явдаг гэсэн нэг ийм бодлогоос болимоор байна, салмаар байна.

Тэр АЗЗА дээр яг бодит жишиг гарч ирж байна шүү дээ. Хуучин наадхыг чинь тэр яамны дэргэдэх төв базаад ерөнхий юм, зохицуулалтыг нь хийгээд явдаг. Тийшээгээ бүх аж ахуйн нэгжүүд. Сая Г.Ганболд гишүүний хэлдэг үнэн шүү дээ. Хонины мах барьж очоод бараг найз нөхөр болж байж л асуудлуудаа шийдүүлж байдаг нэг ийм л зарчимтай. Наадах чинь буцаад бий болно шүү дээ. Ер нь бол бүгдээрээ л нэг захиргаатай болчихсон. 21 аймгийн бүх АЗЗА-нууд нэг гар очоод төвлөрчихсөн. Төвлөрсөн том удирдлагатай. Ер нь тэгээд хувийн хэвчлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх энэ зарчим руу бид орох ёстой шүү дээ. Цаашидаа яваандаа. Айл гэрээр бодоход хүүхдүүдээр юм хийлгэхгүй аав нь урдуур нь ороод л өө чи болохоо байчихна, чи чадахгүй, чи болохгүй, чиний ухаан хүрэхгүй, чиний чадал хүрэхгүй

гээд л урдуур нь орж гүйгээд л хамаг ажлыг нь хийгээд байдагтай адилхан төр өөрсдөө бүгдийг нь аваад л хувийн хэвшил цаашаа байж бай. Та нар л болохоо байчихна, та нар хийхээр л юм дампуурчихна, та нар хийхээр л наад зам чинь засвар олигтой юм болохгүй. Төр л сайхан бодож байж энэ бодлогыг нь сайхан барихгүй болохгүй гээд л өөрсдөө хийгээд байгаатай л адилхан байна шүү дээ. Ийм л зарчим яваад байна шүү дээ.

Ер нь төр бодлого ерөнхийдөө зохицуулалт байлгүй л яах вэ. Төрийн зохицуулалт байлгүй л яах вэ. Төрийн зохицуулалт чинь гол нь шударга өрсөлдөөнийг бий болгох зарчим дээр л уг нь барих ёстой шүү дээ. Гол юм. Түүнээс биш урдуур нь орж хийгээд байдаг асуудал биш шүү дээ. Тийм болохоор наад том нэгтгэл гэдэг юманд би Г.Ганболд гишүүнтэй санал нэг байна. Наадах чинь улам дахиад нэг хүний гараас нөгөө хүний гар луу ороод л төвлөрөл үүсээд л тэгээд л орон нутаг нэг царай алдсан дээрээсээ харсан цалингаа дээрээс авсан. Тэгээд бараг томилох томилгоо бүх юмнууд чинь дээрээс явах юм байгаа биз дээ бодвол. Орон нутагт нэг хүн авахад л. Цэвэрлэгч авахад л дээрээсээ юу нь гарч байдаг. Тушаал нь тэр дээр очиж Улаанбаатарт гарч байдаг. Тэнд нэг цэвэрлэгч авч байдаг ийм л юм болж байгаа шүү дээ. Тэгээд наадхыг чинь би олон дахин ярьсан даа. Уг нь буруу юм хийчихлээ гээд. Анх Улсын Их Хурал, яах вэ Улсын Их Хурал бас буруу юм хийсэн. Энэ буруу юм хийснийхээ юмыг бид авах ёстой. Бурууг өөрсдөө хүлээх ёстой. Үүнийг чиглүүлээд л үүнийг л ажил болгох гээд та нар буруу юм хийчхээж байгаа ч юм уу билүү мэдэхгүй. Ямар ч л байсан Улсын Их Хурал дээр 34 хувь гээд ингээд алх цохиод. Тэр дээр чинь бас л хэлээд хэлээд нэмэргүй. Хаанаас ч орж ирсэн санал байсан юм. Яамнаас орж ирсэн санал юм уу, эсвэл төрийн өмчөөс орж ирсэн санал юм уу. 34 хувийг нь хувьчилна гээд л гараад ирсэн.

Миний хувьд анх бүр 100 хувь хувь хувьчилъя гэж оруулж байсан шүү дээ. МИАТ-тай хоёуланг нь. Тэгэхээр энэ мэдэхгүй яах ёстой юм. Тодорхой тогтоолын төсөл оруулж ирээд буцаад Засгийн газар луу хандаад орон нутагт нь өгөөд явах ёстой юм уу. Ер нь 34 хувь хувьчилна гэдэг бол үнэхээр буруу шийдвэр байсан. Одоо тэгээд та хэд бас шийдвэрээ буцаад нэг эргээж хараарай даа. Яг үүнтэй адилхан бусад аж ахуйн нэгжүүдээ шаардлагатай хувьчлах хэрэгтэй шүү дээ. Тэгээд бид эхнээс нь авхуулаад л одоо жишээ нь нүүрсний сонсгол гээд үзэж байна. Нүүрсний сонсгол дээр Тавантолгой компани гээд л гарч ирж байгаа. Яаж дотор нь булхай юмнууд, тэр ТУЗ-д нь ордог, удирдлагад нь ордог, удирдлагын баг дотор нь ордог. Тэгж байгаад худалдан авалт болон тендер бүх асуудал дээр нь өөрсдөө ордог, өөрсдөө нөлөөлдөг, өөрсдөө ашигтайгаар ажиллуулдаг. Энэ чинь төрийн өмчийн компанийн нэг тодорхой жишээ байна шүү дээ. Тийм болохоор үүнийг бодолц.

Г.Ганболд: Б.Пүрэвдорж гишүүн уг хэлье.

Б.Пүрэвдорж: Монголын баялаг ямар үнэд хүрдгийг би та нарт ганцхан бүтээгдэхүүн дээр хэлж өгье. Монгол Улс 30-аас 50 хувийн агууламжтай “жоншны хүдэр”-ийг 600 мянган тонныг экспортолдог. Тэндээс 20 сая доллар олдог юм. Гэтэл энэ 600 мянган тонн жоншны хүдрийг Эрээний 2 үйлдвэр. Цаад талын нөгөө юу билээ. Тал дээр байдаг чинь. Нэг ийм 3 үйлдвэр 90 хувийн баяжмал хийгээд дахиад тэндээсээ “кальцийн фтор” хийгээд ойролцоогоор 120 сая доллар олж байгаа юм. 120 сая доллар олж байгаа юм.

Тэгээд тэр 120 сая долларынхоо кальцийн фтор гээд цаашаа Фужаны криолитын үйлдвэрт аваачаад криолит хийгээд 1.2 тэрбум доллар олж байгаа. Тэр криолитоо цаашаа Жужаны фторт ус төрөгчийн үйлдвэрт аваачаад

“элементийн ус төрөгч” үйлдвэрлээд 2.7 тэрбум доллар олж байгаа байхгүй юу. Яг 600 мянган тонн хүдрээр. Гэтэл энэ юунаас болоод, одоо энэ яагаад ингээд энэ дээр ажиллаад байна гэхээр, манайд яагаад хөгжихгүй байна вэ гэхээр АМНАТ-ыг давхардуулж олгож байгаагаас болж байгаа юм. Манай Т.Энхтүвшин дарга үүнийг маш сайн мэдэж байгаа. Өөрөөр хэлбэл өөрийн уурхайгүй аж ахуйн нэгжүүд Хятадууд нь аваад шууд хилээр гаргахад нэгхэн удаа АМНАТ төлдөг.

Гэтэл хүдэр авсан компани энд баяжуулахад АМНАТ эндээсээ төлчхөөд дахиад хил рүү гарахад дахиж төлдөг байхгүй юу. Тэгэнгүүт ямар ч өрсөлдөх чадваргүй болдог. Яг түүнтэй адилхан төмрийн хүдэр, баяжмал, хорголжин, ширэм бүгдээрээ давхардуулаад үе шат болгон дээрээ АМНАТ-тай. Дахиад нүүрс, угаасан нүүрс, хагас кокс бүгдээрээ давхардуулсан АМНАТ-тай. Тэгээд Монголд ерөөсөө давхардуулсан АМНАТ үйлдвэрлэлийг боомилсон гол зүйл болоод байгаа юм. Тэгээд үүнийг ерөөсөө шийдэхгүй. Тэгээд л роялти авдаг. Хятадууд болохоор нэгхэн удаа АМНАТ төлөөд гаргаж болдог. Гэтэл монголчууд болохоор дотооддоо үйлдвэрлэл хийгээд хэд хэд дахин. “Роялти” гэдэг чинь “хаандаа төлбөр төлөх”-ийг л хэлж байгаа юм л даа. Тэгээд тэр хэд хэдэн удаа төлдөг тийм юм гэж ерөөсөө байх ёсгүй байхгүй юу даа. Дэлхийд ерөөсөө ганц ч байхгүй ийм зүйл. Ийм давхардуулж авдаг ийм АМНАТ-ын төлбөр. Энэ бол Монголыг үнэхээр цаашидаа үргэлж л нэг тийм түүхий эдийн хараат улс болгох ийм л зорилготой зүйл болсон гэдэгт би эргэлзэхгүй байгаа. Тэгээд энэ нэг 30-аад компани байдаг юм. Өөрөө ширэм үйлдвэрлэх гэж зорьж байгаа. Тэр баяжмал хийж байгаа. Цаашидаа кальцийн фтор хийх гэж байгаа. Жонни дээр гэхэд 3, 4-хөн компани энэ тэр гээд. 30-аад компани түүхий эд дээр анхан шатын боловсруулалт энэ тэр хийгээд явж байгаа. Тэндээс 40-өөд тэрбум

төгрөг болох юм билээ. Гэтэл энэ АМНАТ-ыг давхардуулж олгосноос болоод одоо тэр 30-аад үйлдвэрийн 1500 хүн Улаанбаатарт ирчихсэн байгаа. Тэгээд тэд нар чинь ойролцоогоор 150 тэрбум төгрөг одоо янз янзын ашиглалтын төлбөр, хураамж энэ тэр гээд тэр сум, орон нутагтаа өгөх ёстой байсан байхгүй юу. Тэр 1500 хүн ажилтай байсан байхгүй юу даа. Гэтэл энэ АМНАТ-ыг давхардуулж олгосноос болоод өнөөдөр тэр компаниуд бүгдээрээ хаалгаа барьчихсан. 30-хан тэрбум төгрөг олохын төлөө, 40 тэрбум төгрөг олохын төлөө. Энэ дээр манай шинэ дарга энэ дээр сайн анхаараарай. Хуучин дарга бол энэ дээр бас нэлээн ажиллаж байсан. Бид хоёр энэ тогтоолын төслөө хамт өргөнө.../минут дуусав/

Г.Ганболд: Т.Энхтүвшин гишүүн үг хэлье.

Т.Энхтүвшин: Түрүүн Зам, тээврийн яамнаас бас нэг асуудал ярьчих шиг боллоо л доо. Зам арчлалтын компанийн 34 хувийг Улсын Их Хурал тогтоол гаргаад ингээд олон нийтийн болгох ийм чиглэл өгч байсан. Тэгээд хэрэгжихгүй байна гээд. Яс юман дээр Улсын Их Хуралд оруулж ирсэн нь Засгийн газар оруулж ирсэн шүү дээ. Энэ зам арчлалтын компанийн 34 хувийг олон нийтийн болгоё гэдэг Засгийн газар Улсын Их Хуралд оруулж ирээд Улсын Их Хурал энэ боломжит хувилбар байж магадгүй гэдэг дээр л дэмжиж явсан. Тэгээд Улсын Их Хурлын тогтоол хэрэгжихгүй байна, Улсын Их Хурал энэ дээр ажиллахгүй байна гэхээсээ илүүтэй Засгийн газар энэ дээрээ бас нэг эргэж хараад явах нь зөв байх.

Хоёр дахь асуудал. Тавантолгой, Дарханы төмөрлөг, Хөтөлийн цемент шохой, Монголросцветмет нэгдэл, МИАТ, Эрдэнэт. Энэ асуудлаа олон нийтийн болгох энэ судалгааныхаа ажлуудыг яаралтай хийгээд 2024 ондоо багтаагаад зарим энэ төрийн өмчит компаниудаа олон нийтийн болгох,

хувьцааг нь гаргах энэ асуудал дээр онцгой анхаараач ээ. Тэгээд энэ дээр ч гэсэн Г.Ганболд дарга тогтоолоороо тийм ээ. Ялангуяа эрдэс баялаг үйлдвэрлэж байгаа уул уурхайтай холбоотой төрийн өмчтэй компаниудаа заримыг нь 2024 онд л олон нийтийн болгох, ард иргэдээ өгөх, хувьцааг нь гаргах энэ ажлыг яаравчлан эхлүүлж гэдэг дээр.

Гурав дахь асуудал. Биржийн үйл ажиллагааг улам идэвхжүүлж гэж бодож байгаа бол. Түрүүн Б.Пүрэвдорж гишүүн хэллээ шүү дээ. Энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг аваад, баяжуулаад, боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн хийж байгаа ийм хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын бүтээгдэхүүнүүдийг биржээр зарах нь илүү их оновчтой шүү. Илүү их оновчтой. Илүү дотоодын үйлдвэрлэлүүдээ дэмжсэн, илүү түүхийгээр нь биш, боловсруулсан бүтээгдэхүүнээ зарах ийм сонирхлыг бий болгож өгнө. АМНАТ-аа ч гэсэн энэ биржийн үнээр төлөх ийм эрх зүйн орчин бас нээгдчихээд байгаа шүү дээ. Тэгээд бидний эдийн засаг байнга ингээд түүхийгээрээ төмрийн хүдэр, нүүрсээ хөөгөөд байхгүй шүү дээ. Тийм учраас аль болохоор бид 100 тонн нүүрс гаргаснаас 30 тонн кокс гаргах юм бол орж байгаа орлого нь адилхан байхгүй юу. Тийм учраас манай бирж өөрөө цаашидаа энэ уул уурхайн дагнасан биржийг байгуулах, хөдөө аж ахуйн ийм дагнасан биржийг байгуулах. Хууль нь ч гэсэн ерөнхийдөө тийм байгаа шүү дээ. Дагнасан уурхайн биржийг байгуулах гээд. Энэ уурхайн биржийн гол зорилго бол түүхийгээр нь зарахаас гадна баяжуулж байгаа, боловсруулж байгаа үйлдвэрүүдийг дэмжсэн, тэдний бүтээгдэхүүнийг зардаг ийм сонирхлыг л бий болгож өгөх юм бол олон хүн ажилтай, орлоготой, олон эцсийн бүтээгдэхүүн хийдэг үйлдвэрүүд бий болох болов уу л гэсэн ийм бодолтой байж байна. Үүн дээр нэлээн сайн анхаараач.

Яах вэ биржийн асуудал сайн явж байгаа. Б.Цэнгэл дарга ч сайн явж байгаа, “Эрдэнэс Монгол” ч сайн явж байгаа, манай уурхайн яам ч гэсэн их сайн ажиллаж байгаа. Үнэхээр нэг үеэ бодвол бид томоохон амжилт гаргаад, ингээд юмаа хийгээд, туршаад юмаа зараад бас амжилтад хүрч байна шүү дээ. Тэгээд үүнийгээ л цаашаа яаж хөгжүүлэх вэ, цаашид яаж олон бүтээгдэхүүнийг их хэмжээгээр зарах вэ гэдэг дээр л бид анхаараад явчих юм бол бид нэг үеэ бодвол эхлээд тавьчихсан тодорхой хэмжээний амжилтад хүрээд явж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Ганболд: Б.Баттөмөр гишүүний микрофоныг өгье. Г.Дамдинням гишүүн байхгүй байна. Б.Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Өнөөдөр маш чухал сэдвээр ярилцаж байна. Монгол Улсын хөгжлийн гарц энэ баялгийнхаа менежментийг л зөв хийх ёстой. Уул уурхайн биржийн хуулийг санаачилж батлуулж гаргасан гишүүний хувьд манай уул уурхайн бирж сайн ажиллаж эхэлж байгаа. Ажлын маш сайн эхлэлүүд байгаа. Өнөөдөр Монгол Улсын төсөв 1.7 их наяд төгрөгөөр даваад явж байгаа. Төлбөрийн тэнцэл сүүлийн бараг арван хэдэн жилийн хугацаанд анх удаагаа бараг 700-аад сая доллароор давж байгаа. Урсгал данс бараг 20, 30 жил алдагдалтай явсан. Урсгал данс ашигтай явж байгаа. Санхүүгийн данс ашигтай.

Ингээд ирэхээр энэ төлбөрийн тэнцэл гэдэг юм чинь сайн болж гарч ирж байна шүү дээ. Энэ юу вэ гэхээр зэрэг энэ уурхайн биржээр нүүрсийг үнэ хүргэж худалдсан нь голлох роль гүйцэтгэж байгаа. Тийм учраас энэ уурхайн биржээ цаашаагаа их сайн болгох шаардлагатай. Бид ингээд бүгдийг нь хувьчилна гэж байгаа юм. Яах вэ хувьчлах нь зөв. Банкны хувьчлал. Банкны хувьчлалыг одоо ингээд л аваад

үзэхээр 447.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татчихсан байгаа юм. 70 мянга орчим хөрөнгө оруулагч энд оролцсон байгаа юм. Тэгтэл энэ хөрөнгө оруулагч нарыг ингээд аваад үзэхээр зэрэг бүгд нөгөө ашиг олохын тулд л хувьцаа авсан л улсууд байгаа юм. Яг жинхэнэ стратегийн хөрөнгө оруулагч байхгүй. Энэ юунаас болж байна гэхээр бодлогын хүүтэй холбоотой. Бодлогын хүү нь өндөр учраас хувьцаа авснаас банканд хадгалуулах нь илүү ашигтай. Тэгэхээр энэ хүмүүст мөнгө алга байна. Тэгээд мөнгөтэй болгох ажил энэ хувьчлалын ажил энэ тэр чинь зэрэг ингэж уялдаж явах ёстой байгаа юм. Мөнгө байхгүй.

Өнөөдөр Монголын банкны систем 22 орчим их наяд төгрөгийн хадгаламж байна. Тэд нар жилийн 12-оос 13 хувийн хүүгээ аваад л сууж байна. Үүнээс илүү үр ашиг, өгөөж хаана ч байхгүй. Ийм л байдалтай байгаа юм л даа. Тэгээд үзэх ёстой. Тэгээд төрийн бүх өмчийг бүгдийг нь муухай гэж болохгүй. Монголын хөгжлийн гарц бол төрийн өмч байх ёстой. Дээр нь хувийн өмч байх ёстой. Төрийн өмчтэй бол тэр хувьцаат компаниудаа бий болгох ёстой. “Эрдэнэс Тавантолгой” дээр тэр ард түмний өгчихсөн байгаа 14 хувиа нээлттэй болгоод нээлттэй компани болгох ёстой шүү дээ. Тухайлбал, тэгээд цаашаагаа дандаа хувьцаат компаниуд болгож үүнийг үйл ажиллагааг нь шилэн болгох ёстой гэж. Ер нь тэр АЗЗА, тэгээд юу байдаг юм тэр авъя гэсэн юмыг тэр хувьд нь бүгдийг нь өгөх хэрэгтэй. Авъя гэж байгаа юм бол. Зөвхөн баялаг дээрээ л менежмент хийх ёстой. Нүүрс дээр хийсэн менежментийн үр дүн ингэж сая гарч ирж байна шүү дээ. Үүнийг нөхдүүд та нар их сайн бодож тооцоолох ёстой. Одоо ингээд цаашаагаа стратегийн ордууд гэж байгаа шүү дээ. Энэ ордуудаар ямар менежмент хийх вэ.

Уул уурхайн биржээр зэс худалдах ёстой шүү. 20, 30 жил зэс тойрсон

шимэгч нар байгаа шүү. Гадна талдаа ч байна, Монголдоо ч байна. Гэрээ байгуулдаг. Түүнээс тодорхой хэмжээний хувь хүртдэг. Манай Лондонгийн бирж дээр худалдсан зэс чинь Хятадын зах зээл дээр ирж борлогдож байгаа шүү дээ. Дэлхийн зэсийн 60 хувийг Хятад хэрэглэж байгаа. Дэлхийн төмрийн хүдрийн 50-аас илүүг Хятад хэрэглэж байгаа. Тийм учраас энэ биржээрээ дамжуулж зэсээ худалдах ёстой, төмрийн хүдрээ худалдах ёстой. Тэгээд цаашаагаа юу байдаг юм Монголын бүх л зүйлийг худалдах ёстой. Энэ баялаг ард түмний өмч учраас тэр хувийн ч бай, хувьсгалын ч бай бүх баялаг биржээр худалдагдах ёстой. Биржийн үнэ шударга болно. Үүнээс тооцсон нь АМНАТ. Нөгөө их хэл амтай АМНАТ-аа биржийн үнээсээ авчих юм бол ямар ч маргаан байхгүй шүү дээ. Төгсгөлд нь хэлэхэд энэ боловсон хүчний асуудал. Сая Б.Пүрэвдоржийн хэлж байгаа үнэн шүү дээ. Дандаа цүнх баригч нар очиж байгаа шүү дээ. Манай Тавантолгойн сүүлийн захирлууд ер нь бүгд л нөгөө хуулийн байгууллагаар шалгагдаад л ийш тийш нь зугтаад л бариад л явж байгаа шүү дээ.

Тийм учраас төрийн албаны хуульдаа өөрчлөлт хийж тэр жинхэнэ манлайлагч нар нь энэ төрийн өмчтэй том компаниудыг удирдах ёстой шүү дээ. Цүнх баригч нар биш. Ийм өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай.

Г.Ганболд: Гишүүд үг хэлж дууслаа. Тэгээд гишүүдийн үгийг Та бүхэн сонсож байгаа байх. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Их Хурлын тогтоолуудыг хэрэгжүүлэх ёстой. Бид чинь Дамдины Цогтбаатар гишүүн санаачлаад шинээр төрийн өмчит компани байгуулахыг ер нь хориглочихсон байгаа гэж ойлгоод байгаа. Тэгээд үүнтэй холбоотой энэ АЗЗА-нуудын нэгтгэлтэй холбоотой асуудлыг нь салбарын яам, салбарын бүх байгууллагууд нь, үйлдвэрчний эвлэл нь хүртэл эсэргүүцээд бид нартай уулад яваад байгаа юм.

Тэгээд яах вэ, дотор нь ажиллаж байсан хүний хувьд үүнийг ямархуу бүтэц байдгийг мэднэ. Үүнийг бид ямар ч байсан өнөөдрийн хуралдаанаар сонслоо. Тэгэхдээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай энэ асуудлаар эргэж санал солилцож байж шаардлагатай бол тогтоолын төсөл гаргах асуудлыг ярьж гэж бодож байна. Өнөөдрийн энэ 4 тогтоолтой холбоотой Уул уурхайн яам, Хөрөнгийн бирж бас энэ биржээр арилжиж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, хувийг нь нэмэгдүүлэх чиглэлээр онцгой анхаарах шаардлагууд байна.

“Эрдэнэс Монгол” компанийнхан мөн дотроо ажиллаж байгаа “Эрдэнэс Тавантолгой” компанийн энэ БЭТ-тэй холбоотой асуудлыг цэгцлэхгүй бол одоо яг тэр уулиар чинь явах юм бол яг Компанийн хуулиар явахгүй болчихоод байна шүү дээ. Компанийн хуулиар явахаар яг Эрдэнэс Монголын бүрэлдэхүүн компани биш болчихож байгаа байхгүй юу. Тэр битгий хэл ТУЗ нь хүртэл хүчин төгөлдөр биш шүү дээ. Одоо тэр БЭТ томилогдоод ТУЗ ч байхгүй. Яг хуулиар тэгж ойлгогдоно шүү дээ. Тэгээд энэ БЭТ томилсон тохиолдолд ямар бүтцээр, ямар зарчмаар явах вэ гэдгийгээ тодорхой болгомоор юм билээ. Тийм нэг тусдаа журам гаргаж энэ шинэ хуульд нийцүүлэхгүй бол одоо БЭТ томилчихоод давхар ТУЗ шийдвэр гаргаад явна гэх юм бол энэ өөрөө маш олон хуулийн зөрчил болох ийм зүйлүүд байгаа учраас энэ дээр Та бүхэн онцгой анхаарах байх гэж бодож байна.

Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцаж дууслаа.

Эхний асуудал өндөрлөж байна. Ажлын хэсэгт баярлалаа.

13.32 цаг.

Үйлдвэржилтийн бодлогын 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тайланг сонсоё.

Засгийн газарт чиглэл өгөх тухай 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх асуудлаар ажлын хэсгийг танилцуулъя. Засгийн газрын гишүүн, Боомтын сайд Б.Тулга, Ш.Мөнхсүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын зохицуулалтын газрын дарга, С.Наранцогт “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Анхбаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Л.Баярмандал Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Я.Өлзийболд “Эрдэнэс Монгол” компанийн төслийн судалгаа, үнэлгээний газрын ахлах менежер, С.Алтанцэцэг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал, Б.Чинтуяа “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга, А.Баяржаргал “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөвлөлтийн инженерийн албаны дарга, О.Энхбаяр “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм ажлын хэсгийг танилцуулж байна.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээллийг Монгол Улсын сайд Б.Тулга, Боомтын асуудлаарх Үндэсний хорооны дарга танилцуулна.

Б.Тулга: Эрхэм Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Өнөөдөр Та бүхэнд Үйлдвэржилтийн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр

тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд хийгдсэн ажлууд болон Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулж байна. Өнөөдрийн байдлаар уг төслийн ЕРС-1 буюу технологийн бус байгууламжийн ажлууд 98.4 хувийн гүйцэтгэлтэй. 2024 оны эхний улирал дуусахаар. ЕРС-2 буюу төслийн анхдагч процессын болон дагалдах байгууламжуудын ажлууд эхэлсэн. Ажлын гүйцэтгэл 10.4 хувьтай. 2026 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орох төлөвлөгөөтэй явагдаж байна. Харин ЕРС-3 буюу үйлдвэрийн цахилгаан станцын ажлын хувьд төслийн инженерчлэлийн зураг төслийг хянан баталгаажуулах ажил, дэд станц, хяналтын өрөө, шугам хоолойн стакадны барилга угсралтын ажил төвөгшил өндөр, удаан үйлдвэрлэгдэх тоног төхөөрөмжийн захиалга зэрэг ажлууд хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 10.9 хувьтай. 2026 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орох төлөвлөгөөтэй ажиллаж байна. ЕРС-4 буюу лицензтэй технологийн байгууламжийн хувьд төслийн зээлийн шугамд хараахан оруулаагүй боловч ажил эхлүүлэх уултууд хийгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын хүлээх хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, төслийн ажлын хувьд төмөр зам, авто замын ажил бүрэн дуусаж ашиглалтад орсон. Газрын тосны үйлдвэрийн хотхоны барилгын нэгдүгээр ээлжийн 5 орон сууцын барилга болон оффис үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын явц 81 хувьтай. Харин хоёрдугаар ээлжийн 6 орон сууцын барилгын ажлын явц 28 хувьтай байна.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан 2023 оны 07 дугаар сарын 04-ний төслийн бүтээн байгуулалтын ажлын явцтай газар дээр нь танилцаж, тулгамдсан асуудлуудтай танилцаж, тодорхой байгаа гарц

шийдлүүд гарах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр дараах ажлын үр дүнгүүд гарсан болно. Үүнд:

1.Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээс гэрээлэгчдэд төлбөр төлөх болон бүтээн байгуулалт шаардлагатай бараа материал, техник, тоног төхөөрөмжийг зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу татвараас чөлөөлөхтэй холбоотой асуудлууд тодорхой шалтгаануудаар удааширсан. Улмаар бүтээн байгуулалтад нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсэж буйд дүгнэлт хийж зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр бүтээн байгуулалтын ажил хэвийн явагдаж байна.

2.Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд зориулан буцаж гарах нөхцөлтэйгөөр импорт ороолах техник, тоног төхөөрөмжийн гаалийн нутаг дэвсгэрт түр горимд байх хугацааг тухайн үйлдвэр барьж дуусах хугацаагаар зохицуулах асуудлыг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСИМ банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт оруулах замаар шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.Цар тахлын болон бусад шалтгаанаар төслийн эхний шатын ажлуудын төсөвт өртөг нэмэгдэж, хугацаа удааширсантай холбоотойгоор төслийн санхүүжилт, эргэн төлөлттэй холбоотой үүссэн асуудлыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэж эхлээд байна. Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас олгож буй 1 тэрбум ам.долларын зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах, ЕРС-2 болон ЕРС-3 багц ажлын гэрээний үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацааг дахин 7 жилээр сунгах зээлийн дэд гэрээг 2023 оны 08 сарын 17-ны Сангийн яам, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСИМ баг хооронд байгуулсан байна.

4.2022 оны 10 сарын 28-нд байгуулагдсан ЕРС-2 ба ЕРС-3 багц ажлын гэрээг 2023 оны 09 сарын 20-нд зээлийн шугамд албан ёсоор оруулснаар ЕРС-2 ажлын урьдчилгаа төлбөр гүйцэтгэгч компанитай олгогдож, төслийн ажлууд эхэлсэн байна.

5.Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, ирэх оноос ЕРС-2, 3 ба 4 багц ажлуудыг зэрэг явуулах боломжийг Засгийн газрын 2023 оны 09 сарын 13-ны өдрийн 336 дугаар тогтоолоор олгосноор 04 багц ажлын эхний хэсгийг гүйцэтгэх гэрээ, МГТБҮ ТӨХХК болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Мега инженеринг энд Инфра Стракчер Лимитед” компанийн хооронд байгуулагдсан байна.

6.Үйлдвэрийн ТЭЗҮ-г батлуулснаас хойш 5 жил тутам тодотгох, шинэчлэх шаардлагын дагуу ТЭЗҮ-г боловсруулсан “Инженерс Индиа Лимитед” компани нь үйлдвэрийн технологийн зураг төсөлд техник, технологийн нэмэлт, өөрчлөлтүүд, цар тахалтай холбоотойгоор үүссэн төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлын өөрчлөлтийг дахин тооцож техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг 2023 оны 09 сарын 27-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан байна.

7.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс баталгаажуулсан ТЭЗҮ-д туссан дүнгээр зээлийн дүнг нэмэгдүүлэх хүсэлтийг 2023 оны 10 сарын 16-ны өдөр Сангийн яамнаас Энэтхэгийн Гадаад хэргийн яаманд, 2023 оны 11 сарын 3-ны өдөр Сангийн яамнаас Энэтхэгийн Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт олгосон зээлийн дүнг нэмэгдүүлэх эсэх асуудлаар Энэтхэгийн талаас албан ёсны хариу ирмэгц зээлийн дүнг нэмэгдүүлэх

асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх юм.

8.Олборлолтын хэмжээг орд ашиг төлөвлөгөөнд тусгагдсан жилд 1.5 сая тоннд хүрэх талаар “Петро Чайна Дачин Тамсаг” хязгаарлагдмал хувьцаат компанитай яриа хэлэлцээ хийх, Монгол Улсаас олборлож буй газрын тосны үйлдвэрт нийлүүлэх асуудлаар холбогдох яриа хэлэлцээрийг эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Тогтоолоор өгөгдсөн цаг хугацаа шаардлагатай зарим асуудлын биелэлтийг хангахаар холбогдох төр, захиргааны байгууллагууд ажиллаж байгаа бөгөөд Байнгын хорооны 04 дүгээр тогтоолын биелэлтийг 80 орчим хувьтай байна гэж дүгнэж байна. Цаашид Монгол Улсын Засгийн газраас түүхий тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх, Засгийн газраар зээлийн дүнг нэмэгдүүлэх асуудлыг Энэтхэгийн Засгийн газраас хариу ирсэн даруй Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх, компанийн цаашидын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэрийг шийдвэрлэх зэрэгт анхаарч ажиллах болно. Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

Г.Ганболд: Б.Тулга сайдад баярлалаа. Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023 оны 06 сарын 07-ны өдөр 04 тоот тогтоол гаргасан. 04 тоот тогтоолоор хэд хэдэн заалттай ийм үүрэг, чиглэлүүдийг Засгийн газарт өгсөн байгаа.

“Эрдэнэс Монгол”-ын захирал хаачив. Мэдээлэл, танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Ж.Батжаргал гишүүнээр тасалъя. Т.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. 2023 оны 06 сарын 07-ны өдөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гарсан. Тэгээд тогтоолын төсөл үндсэндээ 7

заалттай. Тэгээд энэ 7 заалтыг хараад байхад хэрэгжилт ер нь хангалтгүй байна уу гэсэн ийм бодолтой байна.

Нэгдүгээр асуудал. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшлийн эрхийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах төрийн захиргааны төв байгууллагыг тодорхой болгооч гэдэг ийм асуудал тавьсан. Тэгээд яг энэ газрын тосны төрийн өмчит компанийг яг хэн нь хариуцаж байгаа юм? Уул уурхайн яам нь хариуцаад байгаа юм уу? Аль яам нь хариуцаад байгаа юм. Тэгээд энэ чинь одоо хүртэл тодорхойгүй яваад байна шүү дээ. Төрийн захиргааны байгууллагыг тодорхой болгооч ээ л гэдэг асуудал тавьсан. Тэгээд “Эрдэнэс Монгол” дээр оччихсон.

Хоёр дахь асуудал. Дорноговь аймагт баригдаж байгаа 2019, 2020 онд эрчимтэй баригдаж байсан энэ газрын тосны үйлдвэрт ажиллах ажилчдын орон сууц, контор, энэ барилга байгууламж маш эрчтэй баригдаж байсан. Одоо ингээд зогсонги байдалд орсон. 2024 оны төсөвт энэ барилга байгууламжийг дуусгах, энэ конторын барилга байгууламжийг дуусгах тал дээр 2024 оны төсөвт тусгаач ээ гэдэг ийм асуудал тавьсан. Тэгээд энэ ер нь юу болж байгаа юм. 2024 ондоо багтаагаад энэ томоохон хэмжээний барилга байгууламжууд дуусах юм уу? Энэ чинь балгас болоод дууслаа.

Гурав дахь асуудал. Одоо энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн чинь үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байна. Бүх гэрээнүүд нь хийгдчихлээ. ЕРС 1, 2, 3, 4 гээд. Тэгээд хоолойгоо тавиад эхэлсэн. 2026 онд ашиглалтад орно. Одоо газрын тосоор хангах ямар тос байна? Нөгөө Тамсаг дээр үйл ажиллагаа явуулж байгаа “Петро Дачин Тамсаг”, нөгөө

Дорноговь аймгийн Цагаан элс дээр үйл ажиллагаа явуулж байгаа “Доншин Монгол” компаниудтай гэрээ байгуулсан уу? Нөгөө гэрээг нь баталгаажуулсан уу. Газрын тосны үйлдвэр лүү түүхий эдээ нийлүүлэх гэрээ контрактынхаа ажлыг яагаад хийхгүй байгаа юм бэ? Энэ асуудал чинь одоо хүртэл тодорхойгүй яваад байна шүү дээ. Тэгэхээр яаж хангах юм.

Дөрөв дэх асуудал. Энэ газрын тосны хайгуулаа эрчимжүүлээч ээ. Газрын тосны хайгуулыг хийх компаниудыг яаралтай сонгон шалгаруулаад, аль аймагт газрын тосны хайгуул хийх бололцоо боломжтой байна, энэ компаниудаа яаралтай олж тогтоогоод хайгуулаа эрчимжүүлээч ээ гэдэг ийм асуудал тавьсан. Тэгээд 2023 онд олигтой хайгуул явсангүй шүү дээ. 2022 онд ч явсангүй. Тэгээд энэ яагаад явахгүй байна гэдэг асуудал.

Тав дахь асуудал. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль дээр 20 гаруй оюутан яг энэ газрын тосны мэргэжлээр сурч байгаа. Сургалтын төлбөрийн асуудлыг яагаад шийдэхгүй байгаа юм? Одоо хүүхдүүд маань хоёрдугаар курст орчихсон байна. Нэгдүгээр курст сурч байгаа хүүхдүүдийн сургалтын төлбөрийг төлөөгүй байна. Сая хоёрдугаар курст дэвшээд орсон хүүхдүүдийн сургалтын төлбөрийн асуудлыг төлөөгүй байна. Эцэг эхчүүд нь байнга ярьж байна. Бид газрын тосны мэргэжилтнүүдээ одоогоос бэлдээд 2026 онд үйлдвэр ашиглалтад ороход сургууль төгссөн хүүхдүүд шууд очоод ажиллах ийм бололцоо боломжтой болно гээд энэ хүүхдүүдийг бүгдийг нь сургаж эхэлсэн. Одоо сургалтын төлбөрийг нь төлөөгүй. Хүүхдүүд эргэж буцаж байна гээд. Тэгээд энэ асуудал дээрээ та хэд тодорхой ажлыг зохион байгуулаач ээ. Энэ шатахуун ямар үнэтэй байна. Үнэхээр бид цаашидаа Монгол Улс бие даасан, бусад улсаас хараат бус байа гэвэл ямар ч үнээр ч хамаагүй бид энэ

нефтийн үйлдвэрээ л яаралтай барих ёстой.

Т.Ганболд: Т.Энхтүвшин гишүүний цагийг сунгая. 1 минут нэмж өгье.

Т.Энхтүвшин: Өнөөдөр бид дотооддоо үйлдвэртэй болохгүй бол Оросын Холбооны Улс хилээ хаах, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хилээ хаах тохиолдолд бидний газар тариалан, хөдөө аж ахуй, уур уурхай гээд бүх юм зогсонги байдалд орох нь. Зогсонги байдалд орох нь. Үнэхээр шатахуун гэдэг бол бүх юмны суурь үнэ байдаг юм байна. Суурь тогтолцоо нь байдаг юм байна. Тийм учраас энэ дээр Засгийн газар ямар ч үнээр хамаагүй хайгуулаа яаралтай хийх, үйлдвэрээ яаралтай ашиглалтад оруулахад нь сайн дэмжлэг үзүүлж ажиллаач ээ л гэж хэлж байгаа юм. Тэгээд энэ 5 асуултдаа хариултаа авъя.

Т.Ганболд: Хэн хариулах вэ. 2 номерын микрофон өгье. Ажлын хэсгийн 2. Өөрийгөө танилцуулаад хариулт өгье.

Б.Анхбаяр: Сайн байцаана уу? Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Уурхай хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр. Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Анх 2017 онд газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл анх хэрэгжиж эхэлж байх үеэс эхлээд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам энэ төсөл дээр маш их ач холбогдол өгч анхаарал хандуулж ажилласан. Тэр хүрээндээ бас нэлээдгүй ажлуудыг хийсэн байгаа. 2018 онд газрын тос боловсруулах үйлдвэрийн яг барилгын ажлуудыг эхлэх явцын үед Засгийн газраас чиглэл гарч дотооддоо байгуулах дэд бүтцийн ажлуудаа өөрсдөө хийе гэдэг шийдвэр гарсан. Энэ шийдвэрийн хүрээнд Сайншанд сум руу хүрэх авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах агаарын шугам, кемп зэрэг иймэрхүү ажлуудыг өөрсдөө хийе гэдэг ийм чиглэлийн дагуу Хөгжлийн банкнаас 100 орчим сая долларын зээлийг авч энэ

ажлуудыг эхлүүлсэн. Явцын дунд Хөгжлийн банк нь өөрөө 2023 онд энэ төсөл нь цаашидаа 67 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хэмжээтэй болсон байна. Цаашидаа энэ компани нь зээлд шаардлагатай барьцаанд тавих хөрөнгөгүй болсон гэдэг үндэслэлээр зээлийг зогсох шийдвэр гарсан. Тухайн үед Засгийн газар дээр ярилцаад энэ шийдвэрийн дагуу Хөгжлийн банкны тухайн үед хэлэлцүүлэг гээд асуудлууд явж байсан учраас энэ төслийг цааш нь хэрэгжүүлэхийн тулд санхүүжилтийн эх үүсвэртэй байх ёстой. Санхүүжилтийн эх үүсвэрийг төсөв дээр суулгаж болохгүй юм байна.

Тэгэхээр “Эрдэнэс Монгол” руу ер нь үйл ажиллагааг нь тогтвортой явуулахын тулд шилжүүлэе гэдэг тийм шийдвэр гарсан. Энэ шийдвэрийн хүрээнд л ерөөсөө энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл маань өдийг хүртэл ингээд хэрэгжээд явж байгаа. Төсөв дээр бид ямарваа нэгэн байдлаар компанийн үйл ажиллагааг хангах хэмжээний төсөв мөнгийг суулгах боломжгүй байсан. Энэ үед. Тэгээд “Эрдэнэс Монгол” дээр шилжсэн хүрээнд бүх компанийн үйл ажиллагаа нь тогтвортой явж байгаа гэж үзэж байгаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зүгээс өнөөдрийн байдлаар бүх талаар нь мэргэжил, арга зүйн хэмжээнд чиглэлүүдийг өгөөд туслаад, дэмжээд явж байгаа. Жишээлбэл, түрүүн бидний ярьж байсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль байна. Дээрээс нь компанийн гаднаас ирж байгаа хүн хүч, нөөцийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, техник, эдийн засгийн үндэслэлийг нь батлуулах гээд бүх л төрлийн арга хэмжээнүүдээр мэргэжил, арга зүйн дэмжлэг өгөөд ингээд хамтраад ажиллаад явж байгаа. Тэгэхээр ер нь яах вэ манай яам өөрөө ямарваа нэгэн компанид өгөх юу гэдэг юм санхүүжилтийн эх үүсвэр байхгүй учраас тэрэн дээр л зохицуулагдаж, компани

буюу аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг “Эрдэнэс Монгол” руу шилжүүлсэн. Бусад мэргэжил арга зүйн талаар байнгын харилцаатай. Дээрээс нь Сангийн яамны баталгаажуулалтын ажлуудыг ч гэсэн бид давхар хийгээд өдөр тутмын үйл ажиллагаанд нь туслалцаа дэмжлэг үзүүлээд ажиллаж байгаа гэдгийг хэлье.

“Петро Чайна” компанийн гэрээний баталгаажуулалтын хувьд Т.Энхтүвшин гишүүн асуулаа. Та бүхэн бүгдээрээ сайн мэдэж байгаа. “Петро Чайна” компани 2005 оноос хойш Монгол Улсад үйл ажиллагаа явуулсан. Нийт Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт нь 4 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалт оруулсан. Энэ 4 орчим тэрбум доллар.../минут дуусав/

Г.Ганболд: Гүйцээж хариулъя. 2 номер.

Б.Анхбаяр: 4 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтаас одоогийн байдлаар 3 орчим тэрбумыг нөхсөн. Цаад талд нь 1 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтыг нөхөх шаардлагатай байгаа. Гол үүсээд байгаа асуудал нь юу вэ гэхээр ерөөсөө бүтээгдэхүүн хуваах гэрээ болон хуулийн зөрчил хоёрын хооронд компанийн төлөө өөрсдийнхөө байр суурийг баримталсан. Монгол Улсын талаас татвар авна гэдэг ийм асуудлууд үүссэн учраас нэгдүгээр асуудал нь “Петро Чайна” компани цаашдаа үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад сөрөг нөлөө үзүүлж байгаа асуудлуудыг ярьж байгаа шүү. Тэгэхээр иймэрхүү асуудлуудаас болоод “Петро Чайна” компани тогтвортой үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, орон нутгийн эсэргүүцэл гэдэг асуудал байна. Орон нутгийн эсэргүүцэл гэдэгт ерөөсөө байнгын үйл ажиллагааг нь зогсоодог, дарамталдаг тийм бүлэг хүмүүс бүр бий болсон. Энэ асуудлуудаас шалтгаалаад

“Петро Чайна” компанийн өөрийнх нь жилийн төлөвлөсөн олборлолтын хэмжээ хүртэл буурах ийм түвшинд оччихсон. 2023 оны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр 6.5 сая баррелийг төвлөрүүлэх ёстой байсан боловч одоогийн байдлаар дөнгөж 4.5-ыг оруулсан ийм хэмжээтэй явж байна. Гэрээ баталгаажуулалтын хувьд гэж ярих юм бол бид Монгол Улсын Газрын тосны тухай хуульдаа ч гэсэн тусгачихсан байгаа. Газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулсан тохиолдолд нэн тэргүүн ээлжид тосоо нийлүүлнэ гэдэг хуультай. Үүнийг ч гэсэн “Петро Чайна” компанийн зүгээс мөрдөж дагаж ажиллана гэдгээ илэрхийлсэн. Засгийн газрын зүгээс энэ баталгаажуулах ажлыг хэзээ хийх вэ гэдэг асуудлыг ярьж байгаа. Үүнийг бүтээгдэхүүн хаах гэрээг шинэчлэх явцад энэ нэг заалтыг бүтээгдэхүүн хуваах гэрээн дээрээ тусгаж өгье гэдэг тал дээр зарчмын байр суурь дээр хоёр талаасаа нэгдчихсэн явж байгаа. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга сайд Д.Амарбаясгалангаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад явж байна.

Сая өнгөрсөн сард Бүгд Найрамдах Хятад Ард Улсад “Петро Чайна” компанийн толгой компани болох “Си Эн Пи Си” компанитай очиж уулт хийсэн. Энэ уулзалтын хүрээнд хоёр талаасаа ажлын хэсгээ байгуулаад хамтраад бүтээгдэхүүн хуваах гэрээгээ шинэчилье гэдэг ийм байр суурь дээр тохиролцсон байгаа. Тэгэхээр энэ ажлын хүрээнд баталгаажуулах гэдэг асуудлууд яригдаад явахаар байна гэдгийг танд хэлье. Хайгуулыг эрчимжүүлэх асуудал дээр Т.Энхтүвшин гишүүнтэй санал нэг байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газраас нийт Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлэн болсон 3 бүтээгдэхүүн авах гэрээний төсөл явж байна. Энэ төслүүд үндсэндээ Засгийн газраар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Бид юуг хүлээж байна гэхээр

Д.Амарбаясгалан даргаар ахлуулсан энэ бүтээгдэхүүн хаах гэрээг шинэчлэх ажлын хэсгийн тодорхой хэмжээний үр дүнг харж байгаа. Цаашидаа ер нь эрчимжүүлэх талаар өөр бусад компаниуд ажиллаж байна. Жишээлбэл, “Петро Матад” гэдэг компани 20 дугаар талбай дээр газрын тосыг нээж илрүүлсэн. Ойролцоогоор сая орчим тонны нөөцтэй. Цаашиа хайгуулын хүрээнд нөөц ихсэхээр төлөвтэй ийм ажлууд хийгдээд явж байгаа гэдгийг танд хэлье. Сургалтын төлбөрийн талаар Л.Баярмандал дарга хариулах уу?

Г.Ганболд: Л.Баярмандал даргын хэдэн номер байна? Дээшээ ажлын хэсгийн 3 руу суучих. Ажлын хэсгийн 3 номер луу суучих.

Л.Баярмандал: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ашигт малтмал, газрын тосны газарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй компаниудаас авдаг сургалтын сангийн хөрөнгө байдаг. Энэ бол Боловсрол, шинжлэх ухааны яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хамтарсан журмаар зохицуулагддаг. Өнгөрсөн жил манайд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 20 хүүхдийн нэртэй тушаал ирсэн. Тэгээд тэр тушаалын дагуу 20 хүүхдийн сургалтын төлбөрийг үүнээс төлсөн байгаа.

Тэгээд Ашигт малтмал, газрын тосны газар нь хэрэгжүүлэгч агентлаг учраас яамныхаа чиглэлээр яамныхаа энэ Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ийм зохицуулалт хийгддэг. Манайх өөрсдөө бие дааж захиран зарцуулах тийм эрх байхгүй байгаа.

Г.Ганболд: Т.Энхтүвшин гишүүн тодруулъя. Саяынх дээр дахиад.

Т.Энхтүвшин: Тэгээд манай Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, манай энэ Монгол газрын тос боловсруулах төрийн өмчит

үйлдвэрийн газрууд цаашид анхаарах хэрэгтэй л дээ. Өнөөдөр ард иргэдийн эсэргүүцэлтэй тулгараад бид хайгуулаа хийж чадахгүй байна гэдэг ийм юм цаашидаа яримааргүй байгаа юм. Бид энэ нефтийн хайгуул ямар үр дүнтэй юм, нефтийн хайгуул хийснээрээ бид ямар гацаанаас гарах юм, нефтьтэй болсноороо бид ямар үр дүнд хүрэх юм гэдэг асуудлаа л ард иргэддээ зөв ойлгуулаад явах юм бол хайгуул хийх бүрэн бололцоо боломж байж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ хайгуулынхаа ажлыг л яаралтай эрчимжүүлэх ажил дээр онцгой анхаараач ээ. Ерөөсөө сум, орон нутаг багийн иргэдтэй ерөөсөө энэ хайгуулын ажлын талаар ерөөсөө очиж уулздаггүй юм байна лээ шүү дээ. Очоод уулад явахад иргэд дэмжинэ шүү дээ. Одоо ингээд өвөлжилт хүндэрч байна. Цаг ер нь жилээс жилд л хатуу.../минут дуусав/

Г.Ганболд: Нэмэлт 1 минут өгье.

Т.Энхтүвшин: Нефть шатах тослох материал ямар ач холбогдолтой гэдгийг ард иргэд мэдэж байгаа. Нефтийн үйлдвэрийг бүгд л дэмжиж байгаа шүү дээ. Тийм учраас наад сонгон шалгаруулалтаа яаралтай хийгээд, тэр гадна, дотнын компаниуд байна уу, яаралтай л хайгуулаа хийлгэж, үр дүнг л үзэх ёстой. Монгол Улсын Үндсэн хууль дээр байж байгаа шүү дээ. Монгол Улс газар доорх баялгаа мэдэх хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлээр ажиллаач.

Хоёрдугаар асуудал. Л.Баярмандал дарга тодорхой хариулахгүй бол. Ингээд 20 гаруй хүүхдийг сургаж байгаа. Тэгээд 2 хоногийн өмнө Техникийн их сургуулийн захирлуудтай ярьсан. Энэ сургалтын төлбөр нь орж ирэхгүй байна. Хүүхдүүдээс нь аваад явж байгаа шүү гээд. Нөгөө хоёрдугаар курст байж байгаа хүүхдүүдийн хоёрдугаар курсийнх нь мөнгө нь төлөгдөөгүй. Нэгдүгээр

курст сая элсэж орсон хүүхдүүд маань бас төлбөр нь төлөгдөөгүй. Тэгээд энэ асуудлаа тодорхой болгоод энэ боловсон хүчнээ дэмжвэл дэмжсэн шиг дэмжээд, төлбөл төлсөн шиг төлөөд ингээж явахгүй бол тэгээд баахан.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номерт дахиад тодорхой хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

Л.Баярмандал: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хайгуулын хувьд манайх энэ жил нийт 14 талбай дээр олон улсын нээлттэй тендер зарласан байгаа. Нийт 5 аж ахуйн нэгж гадаадын компаниуд сонирхож саналаа ирүүлсэн. Үүнээс 3 нь хэлэлцээ хийгээд Засгийн газартай, одоо Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам руу бүтээгдэхүүн хуваах гэрээ хийхээр хүргүүлсэн байгаа. Нөгөө 2 компани нь түр түдгэлзсэн байгаа. Энэ бол “Доншин” компани буюу “Петро Чайна” компаниуд нөгөө дансыг нь хаасан асуудал байгаа учраас энэ асуудлыг ишидэгдтэл бид дахиж шинэ талбай дээр хайгуулын ажил хийхээ түр түдгэлзүүлэе гэсэн ийм юм ярьсан. Тэр сургалтын сангийн хувьд Т.Энхтүвшин гишүүн сайн мэдэж байгаа байх. Өмнө энэ сургалтын сан зөвхөн гадаадад хүүхэд сургана гэсэн тийм журамтай байгаа. Одоо энэ асуудал нь Авлигатай тэмцэх газар шалгагдаж байгаа. Энэ сургалтын сан. Тэгээд энэ журмаа өөрчлөхгүй бол манайх агентлаг дангаараа мөнгө гаргах боломжгүй байгаа. Тэгээд ноднин Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар бас шилжүүлсэн. Энэ жил журмаа л өөрчилчихвөл бид нарт ямар ч асуудал байхгүй. Сургалтын санд мөнгө байгаа.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр энэ газрын тос боловсруулах үйлдвэр үнэхээрийн л аминд их тулчихсан л бүтээн байгуулалт л даа. Бид хэдэд.

Тэгэхээр наад үйлдвэрийн чинь бүтээн байгуулалтын ажил графикт хугацаанаасаа өмнө явна уу, хойно явна уу? Энэ дээр нэг тов тодорхой мэдээлэл өгчих. Нэг.

Хоёрдугаарт, уг үйлдвэрт газрын тос үндсэн түүхий эд нь байх. Тэгэхээр одоо батлагдчихаад байгаа баталгаат нөөц чинь энэ үйлдвэрээ хангах хэдэн жилийн нөөц юм бэ? Тэр улсуудтай гэрээ хэлцэл хийж, тэргүүн ээлжид өгье гээд ярьсан юм байж. Үнэ хани элдэв бусын юман дээр урьдчилж тохирсон барьсан юм байдаг юм уу? Тухайн үеийн дэлхийн зах зээлийн гэдэг юм уу, юуны үнийг баримжаалж хамгийн түрүүн нийлүүлнэ барина гэсэн юм байдаг юм уу. Бид хоолойгоо татчихаад байгаа шүү дээ. Хүний юм руу. Яг нарийндаа. Тэгээд одоо хоолой оччихсон болохоор зэрэг үнийн тулгалтад ороод хэдүүлээ өндөр үнэтэй газрын тос татах болох вий дээ энэ чинь.

Би уг нь энэ ажлыг хоёр, гурван жилийн өмнө үүнийгээ баталгаатай болгоорой нөхдүүд ээ. Санамж бичиг байдаг юм уу. Гэрээ хийж болдоггүй юм бол санамж бичиг байдаг юм уу, юм байгуулах ёстой шүү. Өнөө маргаашигүй. Тэгж байж тэр хоолой таталтын ажил явах ёстой шүү гэдэг ийм л юм ярьж байсан санагдаад байна. Энэ ямар юм байгаа юм. Үйлдвэрт газрын тосноос гадна нэмэлт орцууд гэж юу байх юм бэ? Ер нь. Юм байх юм уу, байхгүй юм уу? Байвал хаанаас яаж нийлүүлнэ гэж ингэж тооцож урьдчилсан хэлцэл, санамжууд байгуулсан юм байна уу гэж. Нэг ийм зүйл.

Дөрөв дэх зүйл. Баталгаат нөөц нэмэгдүүлэх тухай л асуудал байгаа бидэнд. Тийм учраас хайгуулын ажил. Үүнд бид мөнгө гаргах ёстой. Өөрсдийнхөө мэдэлд байх ордуудаа юуны өмнө тогтоож авах ёстой. Тэр бүтээгдэхүүн хуваах гэрээгээр улсуудтай тохирчихсон ордоос гадна өөрсдөө мэдээд шууд ашиглаж болдог тэр

ордуудаа л тогтоож авах ёстой. Үүнийгээ л маш яаралтай хиймээр байгаа юм. Ядаж энэ хоёр нөөц чинь баланс нь ойролцоо байх юм бол энд асуудал нь зөв зохицогдоод явах юм болов уу л гэж би хараад байх юм. Үүнийг ер нь юу гэж ойлгоцгоогоод, яаж хандаад байгаа юм бэ гэж. Үйлдвэр байгуулагдчихлаа. Шатахуун гардаг юм байжээ. Дагаж гарч ирж байгаа бүтээгдэхүүнүүдийг нь үйлдвэрлэлийн аргаар боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох зүйлүүд бий юу. Энэ чинь дан ганц бензин, дизель түлш хоёр гарахаас гадна тэрний дайвраас гарах юмнууд байх ёстой. Үүнийг боловсруулах үйлдвэрүүдийнх нь асуудал ер нь яаж төлөвлөгдөж яаж явж байна аа? Энэ дээр нэг тов тодорхой хариу авмаар байх юм. Нэг ийм зүйлүүд дээр эхлээд хариу аваадахъя.

Г.Ганболд: Хэн хариулах юм? Ажлын хэсгийн 2 номер.

Б.Анхбаяр: Гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээр асуулт. График хугацаанаас хоцорч байна уу гэж. Анх төсөл эхлэх үед 2023 онд үйлдвэр ашиглалтад орохоор төлөвлөгөөтэй байсан. Уучлаарай. 2025 онд. Гэсэн хэдий ч цаг хугацааны хувьд бидний үед нэлээн амаргүй үеүд тохиосон. Энэ мэдээж КОВИД-ын цар тахлын хугацаа байсан. КОВИД-ын цар тахлын хугацаанд үндсэндээ төслийн ажил бараг 20 орчим хувь руу хүртэл буурч ажиллагаанууд ерөнхийдөө зогссон ийм цаг үеүд өнгөрсөн.

Одоогийн байдлаар Засгийн газрын зүгээс үйлдвэрийн төслийг 2026 он гэхэд ер нь дуусгана гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Үнэ ханишийн хувьд асууж байна. Үнэ хани гэдэг дээр ерөнхийдөө Ж.Батжаргал гишүүн ээ, ийм байгаа. Газрын тосны үнэ нь өөрөө дэлхийн зах зээл дээрх биржүүдээр зохицуулагддаг. Бид ч гэсэн мөн ялгаагүй. Монгол улсаас олборлож байгаа газрын тосыг биржийн үнээр л наймаалцаж байгаа. Тэгэхээр цаашидаа ч

гэсэн бид биржийн үнийг баримтална. Үүнийг бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр ч гэсэн ерөнхийдөө суулгачихсан бүх зохицуулалт нь энэ дээр орчихсон явж байгаа. Таны хэлсэн саналыг бид цаашидаа бүтээгдэхүүн хаах гэрээг шинэчлэх асуудал дээр тодорхой тусгаад явна. Одоо байгаа нөөц Монгол Улсын хэмжээнд 332 сая тонн газрын тосны нөөцтэй. Үүнээс баталгаат 42 сая тонн нөөцтэй гэсэн тоотой байдаг. Бид нар. 42 сая тонноос одоогийн байдлаар бид 10 орчим сая тонныг олборлоод экспортод гаргасан байна. Тэгэхээр баталгаат нөөц ойролцоогоор 32 орчим сая тонн нөөцтэй байна гэж бид харж байгаа. Энэ нөөцийг газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор бид 15-аас 20 жилийн хугацаанд ер нь ашиглах болов уу гэсэн тооцоо ерөнхийдөө байгаа. Цаашидаа нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр “Петро Матад” компани. Би түрүүн дурдсан. “Петро Матад” компани үйл ажиллагаа явуулж байгаа.

Ганц энэ дээр харамсалтай гэх юм уу түрүүн Т.Энхтүвшин гишүүн ч гэсэн хэллээ. Нөөцийг ихэсгэх талаар арга хэмжээ аваач гэдэг асуудал дээр. Яг үнэнийг хэлэхэд Дорнод аймаг маань бас нэлээн их эс үйлдэхүй үлдэж байгаа гэдгийг Та бүхэнд хэлмээр байна. Аймгийн юу гэдэг юм Засаг дарга болон Засаг даргын Тамгын газар ямарваа нэгэн гэрээнүүдийг тэнд удаадаг, гацаадаг ийм үйлдлүүд ерөнхийдөө маш их ажиглагдаж байгаа. Тэгэхээр мэдээж бид орон нутгаас санал авдаг, тэд нартайгаа хамтарч ажиллах гэдэг ийм асуудлууд байдаг учраас энэ тал дээр жоохон цаг хугацаа алддаг асуудлууд байгаа гэдгийг танд хэлье.

Цаашидаа нэмэлт орцууд байгаа юу гэдэг дээр миний дараа Д.Алтанцэцэг захирал, яг энэ үйлдвэрийн захирал Та бүхэнд мэргэжлийн зүгээс нь хариулт өгөх байх. Мөн дагаж гарах бүтээгдэхүүнүүдийг яах вэ гэдэг асуудлууд дээр яг үйлдвэрийн технологийн асуудлыг илүү сайн мэдэж

байгаа Д.Алтанцэцэг захирал хариулт өгсөн нь зөв байх.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номер. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

Д.Алтанцэцэг: Үйлдвэрчний байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Үйлдвэрийн нэмэлт орцуудын тухай асуулаа. Ер нь газрын тос боловсруулах үйлдвэрийн үндсэн түүхий эд түүхий тосыг Та бүхэн мэдэж байгаа. Гол шаардлагатай нь устөрөгч байдаг. Устөрөгчийг бид гаднаас авахаас зайлсхийхийн тулд нэгдүгээрт тээвэрлэхэд хүндрэлтэй.

Хоёрдугаарт, өндөр үнэтэй учраас Монголын газрын тосны үйлдвэр бусад үйлдвэрээс юугаараа онцлогтой гэхээр устөрөгч үйлдвэрлэнэ. Манай Монголд анхны устөрөгчийн үйлдвэр бий болох гэж байна.

Хоёр дахь катализаторууд байж байна. Химийн урвалжууд. Үүнийг тухайн 7 лицензтэй молекулын түвшинд урвал явагдах тэр гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчид нь өөрсдөө катализаторуудаа нийлүүлнэ. Ийм гэрээтэй. Бид нар. Бас бус азот гэх мэтчилэн бага хэмжээний химийн бодисуудыг импортоор оруулж ирж ашиглана. Үйлдвэрийн дараа дараагийн шатын үйлдвэрүүд ярьж байх шиг байна. Манай газрын тосны үйлдвэр нэн түрүүнд өндөр чанарын орчин үеийн шаардлага хангасан түли шатахуун үйлдвэрлэх зориулалттай. Бид 1.5 сая тонныгоо ямар ч байсан боловсруулаад шатахуунаа үйлдвэрлэхэд дагалдаж гарах бүтээгдэхүүн зөвхөн зуухны түли байгаа. Тэгэхээр газрын тосны үйлдвэр гэдэг өөрөө *couple production* буюу ийм юмыг үйлдвэрлэхэд заавал тийм юм дагаж гардаг гэх. Тэгэхээр дагаж гарч байгаа бүтээгдэхүүн ганцхан зуухны түли. Энэ зуухны түлиээр бид үйлдвэрийнхээ цахилгаан станцыг тэжээнэ.

Тэгээд яльгүй бага хэмжээний зуухны түли илүү гарна. Тэр нь мазут 100 стандартаас арай жсоохон дээгүүр олон улсын стандарттай ийм түли байгаа. Үүнийг өөр Хятадын юм уу, гадаадын зах зээл дээр борлуулна гэж үзэж байгаа. Манай газрын тосны өөрийнх нь химийн шинж чанарын хувьд хүхрийн агуулга маш бага учраас бид жилийн 3 мянган тонн элементийн хүхэр гаргаж авна гэж ярьж байгаа. Үүнийг Монгол дотооддоо хэрэглэх энэ ураны төсөл хэрэгжвэл бас хэрэглэх тийм боломжууд байгаа. Ер нь манай Монголын газрын тос хүхрийн хэмжээгээр дэлхийн бусад тоснуудаас хамгийн багад ордог. Дараа дараагийн бүтээгдэхүүн гэхээр бид ер нь эхлээд түли шатахууныхаа үйлдвэрийг гаргаж авчхаад. Хаягдалгүй үйлдвэрлэл гаргана гэж байгаа юм.

Тэгээд хүчин чадлаа нэмж байгаад энгийн нэрлэгийн байгууламжаас гарч байгаа түүхий нафтагийн хэсгийг *steamcracker* буюу ханаагүй нүүрс ус төрөгч олифины үйлдвэрт оруулж задлаад нэ нефть химийн үйлдвэрийн түүхий эдийг бэлдэх боломжтой.

Тэгэхээр манайх газрын тосны үйлдвэрээс химийн үйлдвэр хүртэлх гурав дахь шатын үйлдвэрлэлийн эхнийхийг хийж байгаа. Ямар ч байсан үйлдвэрээ бариад авчихсан цагт дараа дараагийн үйлдвэр бид нэн түрүүнд нэмүү өртөг шингэсэн маш өндөр шингэдэг тос, тосолгооны материалаа үйлдвэрлэе гэж бодож байгаа.

Манай Монголын тос изопропанолын агуулга асар өндөртэй. Шатах, тослох материал хийхэд маш их тохиромжтой тос байгаа. Дээрээс нь парафинлаг тос учраас цагаан тунгалаг парафиныг гаргаж авъя гэсэн бодолтой байгаа. Инженерүүд юу ч гэсэн энэ үйлдвэрээ л бариад авъя. Тэрний дараа аяндаа тийм сеператорууд энэ тэр

тавьж шинээр тийм байгууламжууд барих хэрэгтэй л дээ. Баярлалаа.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Түүхий тос дэлхийн зах зээл дээрх биржийн үнээрээ явдаг юм гэж. Дэлхий дээр энэ төрлийн бүтээгдэхүүний үнэ өсчихлөө. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Монголд нэмэгдэж орж ирсэн орлого гэж ер нь ямар юм байгаа юм. Экспортоос чинь. Энэ дээр нэг тодорхой хариулт авчихмаар, тоотой юм авчихмаар байна. Тэгээд баахан нууцын зэрэглэлтэй юм шиг юм ярьцаагаад. Энэ тоонууд нь хаалттай.

Гаднаас импортоор орж ирж байгаа шатахууных нь үнэ хэлбэлзээд байдаг. Үүнийгээ тогтворжуулахын тулд түүхий бүтээгдэхүүнийхээ экспортын үнийн зөрүүгээр тогтворжуулах үйл явцыг явуулж байж энэ эдийн засаг нийгмийн бусад салбаруудыг өөрийг нь тогтворжуулах ёстой гэдэг ийм байр суурь яриад дийлэхгүй яваад байгаа байхгүй юу. Үүнийгээ нэг тодорхой болгоод өгчхөөч гэж.

Дараагийн нэг зүйл. Тэр эцсийн бүтээгдэхүүнээс гарч байгаа бусад төрлийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх үйлдвэрүүд.../минут дуусав/

Г.Ганболд: Нэмж авах юм уу? Та. Ж.Батжаргал гишүүнд нэмж 1 минут өгье.

Ж.Батжаргал: Тийм төрлийн бүтээгдэхүүнүүд хийдэг тэр нефть химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүтээгдэхүүнийх нь түүхий эд хэдий хэмжээний юм гарах юм. Жилийнх нь хэмжээ. Тэрийг барих үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсвийг бэлэн болгож, тэр үйлдвэрүүдийг бид эхлүүлэх тухай асуудлыг ярих ёстой. Тэгж байж бид энэ нэг үйлдвэрүүдийг дагасан кластеруудыг нь бий болгож, бүтэн үр өгөөжийн

тухай л ярих ёстой шүү дээ. Түүнээс ганцхан бүтээгдэхүүн дээр суурилсан үйлдвэрлэл яваад, тэгээд энд тэндээс авсан хөрөнгөө буцааж төлдөг цаг хугацаа, цаглавар чинь сунаад ингээд байж таарамгүй. Нэгэнт бий болж байгаа юмнаасаа гарч ч болдог бүхий л юмаа ашиглаад аль болохоор тэр авсан хөрөнгөө буцаан төлөх асуудлаа шуурхайлах тухай л асуудал байхгүй юу бидний. Тэгэхээр энэ талаас нь л нэг цогц хандаж л асуудалдаа явмаар санагдаад байгаа юм. Дараа нь тэр мэргэжлийн боловсон хүчний тухай ярихаар зэрэг тэгэх болов уу, ингэх болов уу гэж.../минут дуусав/

Г.Ганболд: Ажлын хэсгийн 2 номер.

Б.Анхбаяр: Монгол Улсын хэмжээнд 2023 онд 6.5 сая баррель буюу 883 мянган тонн газрын тос олборлож экспортлохоор төлөвлөсөн. 2023 оны 12 сарын 31-ний өдрийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 404 сая 887 мянган баррель буюу 663 мянган тонн газрын тосыг олборлосон. 4 сая 727 мянган баррель буюу 642 мянган тонн газрын тосыг экспортод гаргажээ гэсэн ийм тоо. 2023 оны төсвийг бид төсөвт төвлөрүүлэхдээ газрын тосны үнийг дунджаар 60 доллароор төлөвлөсөн байгаа. Өнөөдрийн байдлаар таны хэлдэг үнэн. Газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр өсөж байгаа. Сүүлийн саруудад нэг ойролцоогоор 90 доллар хүрч байсан бол өнөөдрийн байдлаар 76, 75 орчим доллар дээр хэлбэлзэж байгаа буюу бидний төлөвлөснөөс илүү өндөр үнэтэй зарагдаж байгаа. Тэгэхээр манай гарч байгаа газрын тосны үнэ Сингапурын бирж дээрх Дачин-31 тосноос нэг долларын татуугаар зарагддаг. Энэ тос одоогийн байдлаар 72, 73 долларын ийм үнэтэй зарагдаж байгаа. Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр бид яг газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр өндөр болоод ирэх үед нь бид дагаад л өндөр үнээр зарж байгаа. Буух үед нь дагаад л буусан үнээр нь зараад явж

байгаа. Энэ бол төсвийн асуудал хариуцсан Сангийн яаман дээрээс бид илүү нарийвчилсан тоонуудыг аваад танд эргээд албан бичгээр хүргүүлье гэж хэлмээр байна.

Г.Ганболд: 3 номер. Ажлын хэсгийн 3 номерыг өгье.

Д.Алтаницэцэг: Үйлдвэр 1.5 сая тонн хүчин чадалтай.

Дээрээс нь бензиний октаныг дээшлүүлэгч нэг химийн бодис байна. МТВЕ гээд. Үүнийг нийлүүлэхээр 1.5-аас жаахан илүү тийм түүхий эд ороод 1.33 сая тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь. Тэгээд үүнийгээ бид өөрсдийнхөө үйлдвэрлэх гэж байгаа бензин, дизель, онгоцны түли, ингээд зуухны түли, шингэнүүлсэн шатдаг хий ерөнхийдөө төлөвлөлт нь Монгол Улсын зах зээлийн бүтцэд нийцүүлж үйлдвэрлэнэ. Тэгэхээр нэн түрүүнд бид өөрийнхөө эдийн засгийг түли, шатахуунаар хангах гэсэн зорилготой. Мэдээж манай үйлдвэрээс гарах бүтээгдэхүүнүүд чанарын хувьд одоо зах зээл дээр борлогдож байгаа түли, шатахуунаас өндөр учраас зарцуулалт арай бага байна гэж тооцох юм бол 2027 онд гэхэд зах зээлийн 70-аас 75 хувь орчмыг хангах болов уу гэж бодож байна. Тэгэхээр 1.5 сая тонноосоо бид дараагийн дагалдах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэвэл тэр бензин гаргах гэж байгаа нафтанаасаа хэрэглэнэ гэсэн үг. Тэгэхээр энэ улс оронд нэн түрүүнд эхнээс нь нефть, химийн бүтээгдэхүүний түүхий эд үйлдвэрлэхээсээ илүүтэйгээр түли, шатахуун хэрэгтэй байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, дэлхий дээр энэ нефть химийн үйлдвэрүүд аварга том болсон байна. Саяхан тэр Улаан тэнгис дээр баригдсан “Saudi Aramco” гэхэд 60 сая тонны хүчин чадалтай, Nigeria гээд 25 сая тонны хүчин чадалтай. Тэгэхээр энэ том том үйлдвэрүүд хажуудаа дагалдаж нефть химийн үйлдвэрүүд барьдаг. Манайхан тэрийг манай газрын

тосны олборлолт нэмэгдээд, үйлдвэрийн хүчин чадлаа нэмж байгаад л тэр төлөвлөлтөө хийхгүй бол одоо хийхэд боломж тун хязгаарлагдмал.

Г.Ганболд: Тэгэхээр газрын тосны үйлдвэр ямар ач холбогдолтойг сүүлийн өдрүүдэд Монголчууд илүү ихээр мэдэрч байна л даа. Гаднаас 100 хувь хамааралтай байгаагийн горьг амсаж байна. Шатахуун түгээх станцууд дээрээ очерлож байна. Тэгээд манай Байнгын хорооноос гаргасан тогтоол үйлдвэрийг бүх талаар дэмжих ёстой.

Төрийн уялдаа холбоо жаахан муу байна. Тэгээд үүнийг цэгцлэх зорилгоор л нэлээн хэдэн заалттай уг нь их чухал тогтоол гарсан юм. Тэгээд өнөөдрийн энэ тогтоолын хэрэгжилтийг сонсоход энд хэрэгжсэн юм бараг алга.

Нэгдүгээрт нь, Уул уурхайн сайд манайд бараг ямар ч хамаагүй шүү гэж зугтаагаад байгаа юм. Гэтэл одоо энэ Засгийн газрын 2023 оны 03 сарын 01-ний 82 дугаар тогтоолоор Уул уурхайн яам бодлогын хувьд удирдана. Удирдлага, зохион байгуулалтын хувьд удирдана гэдэг шийдвэр нь хэвээрээ байна гэх юм. Тэгээд яагаад энэ Уул уурхайн сайд эндээс манайд ерөөсөө ямар ч оролцоо байхгүй гээд яваад байна. Ямар зорилгоор эндээс зугтаагаад яваад байгаа юм бэ. Бид чинь бүх талаасаа дэмжиж байж энэ хүмүүсийн чинь үйл ажиллагааг нь таслахгүй байж үйлдвэрийн хугацаанд нь ашиглалтад оруулах шаардлага байна шүү дээ. 2 дугаар заалтаар өгсөн одоо энэ орон сууцын барилгуудын үлдэгдэл санхүүжилтийг тэгээд хэн хаанаас гаргаж үүнийг гүйцээх юм бэ. 2024 оны төсөв дээр суулга гэсэн чиглэл өгсөн. 2024 оны төсөв дээр юу ч байхгүй.

Үүнтэй холбоотой газрын тосны компанийнхан чинь өмнө нь ашиглалтад орчихсон энэ хэдэн объектуудаа бүр болохгүй бол бид ингээд хүмүүс түрээсэлчхээд тэрүүгээрээ ч болтугай

нэг жсоохон үйл ажиллагааны зардлаа хагас хугасыг нь нөхмөөр байна гээд хүсэлт тавиад байдаг. Хэн шийдвэр гаргах юм. Д.Алтанцэцэг захирал тэр шийдвэрийг нь хэн гаргаж өгөх юм? “Эрдэнэс Монгол” компани өгөх юм уу? Уурхай яамны зөвшөөрлийг нь гэх юм уу. Тэрийг даруйхан өгөөд хий хоосон байж байхаар тэгээд тэндээс 5 төгрөг олох боломж байгаа бол тэрийг нь шийдэж өгмөөр байна шүү дээ. Эзэнгүй байгаад байна гэдэг чинь үүнийг хэлээд байгаа байхгүй юу.

Гуравт нь, “Эрдэнэс Монгол” компаниас эдний компанийн үйл ажиллагааны санхүүждэг, цалингаа авдаг юм байна. Хүүтэй авдаг гэж ойлгоод байгаа. С.Наранцогт захирал аа. Энэ мөнгийг нь байна шүү дээ хэдүүлээ жилээр нь баталчихдаг юм бол урьдчилж сар сарынх нь санхүүжилтийг нь хийчхээд л дараа нь тайланг нь аваад явчхаж болдоггүй юм уу? Эдний компани чинь үйл ажиллагаагаа явуулмаар. Эсвэл танайх руу нэг баахан бичиг цаас, гарын үсэг хөөцөлдөж цалингаа олж авахгүй маш хүндрэлтэй яваад байдаг юм байна шүү дээ. Тэгээд энэ дээр бид чинь төсвөөс ч гэсэн урьдчилж орчхоод л тэгээд л дараа нь бид чинь гүйцэтгэлээрээ ингээд л явчхаж болдог. Тэрийг ийм хэлбэр лүү оруулж болохгүй юм уу? Тэрийг би танаас асуух гээд байна. Санхүүгийн урьдчилгаа гэсэн үг. Тэгээд Ашигт малтмалын газрын дарга тэр хүүхдүүдийнх нь сургалтын төлбөрийг ноднин Төрийн нарийн бичгийн дарга тушаал гаргаад л өгчихсөн юм бол одоо яагаад болохгүй байгаа юм. Ноднин яагаад өгч болж байсан юм. Энэ жил яагаад болохгүй байгаа юм. Тэгээд журмаа өөрчлөх ёстой юм бол тэр саналуудаа тавиад тэр журмаа өөрчлөөд яв л даа. Одоо үүнийг чинь хурдан явуулах нь бид чухал байна шүү дээ. Энэ гацанууд чинь юу юугүй хугацаа чинь богинохон шүү. Цаг хугацаа нэг мэдэхэд ямар ч ажиллах хүн байхгүй. Дахиад үйлдвэр ашиглалтад ордог. Боловсон хүчин байхгүй гээд хойшоо

сунах асуудал үүсэх вий. Энэ дээр бүгдээрээ сэтгэл гаргамаар байна шүү дээ. Тойрч зугтаагаад л хэн хэн нь мөнгө байхгүй гээд яваад байх юм бол бүтэхгүй шүү дээ.

Тэгээд цаашидаа тэр хайгуулын ажлууд их чухал байна. Тэр “Давст-3” гээд л эртээд эдний компанийнхан хэлж байна лээ шүү дээ. Энэ дээр тэр хайгуулын ажлыг жсоохон зардал мөнгө тавьж, энэ үйлдвэр цаашидаа явна гэж байгаа бол түүхий эдээ хангах тал дээр урьдчилж ер нь жсаахан бодлогын яам энэ дээр нэг анхаарч явахгүй бол энэ гол заалтууд дээр чинь ерөөсөө одоо ингээд хэрэгжилт нь би ерөөсөө хэрэгжиж байгаа юм бараг байхгүй байна шүү дээ. Нэг ч заалт нь ерөөсөө хэрэгжсэн юм байхгүй.

Тийм учраас би энэ хэрэгжилтийг 01 сарын 17 чуулган завсарлахаас өмнө би дахиж сонсоно гэж бодож байна. Одоо эндээс энэ хэрэгжилт дээр энэ холбогдох байгууллагуудад Байнгын хорооноос хугацаатай үүрэг өгөөд энэ Байнгын хорооноос гарсан тогтоол дээр хэрэгжсэн заалт нэг ч алга.

Тэгэхээр зэрэг үүнийг дахин Байнгын хороон дээр сонсох. Энэ хүрээнд энэ холбогдох байгууллагууд сая тэр заалт болгон дээр хэрэгжүүлэх тал дээр анхаарах ийм шаардлага байна гэж ингэж үзэж байна. Тэгэхээр саяын энэ асуултууд дээр би С.Наранцогт захирлаас, тэгээд Уул уурхайн яамнаас, Ашигт малтмалын газраас нэг тодорхой хариултууд аваадахъя. Ажлын хэсгийн 1 номер.

С.Наранцогт: Г.Ганболд даргын асуултад хариулъя. Эдний төслийн дундаас нь энэ оны хавар гэсэн үг шүү дээ. Үйл ажиллагааны санхүүжилтгүй боллоо. Яг энэ асуудлын хүрээнд нь шийдье гэдгээр манай нэгдлийн харьяанд Засгийн газрын тогтоол гарсан. Энэ дагуу үйл ажиллагааны санхүүжилтийг нь өгөөд явж байна. 3.8 тэрбум төгрөг

олгосон байна. Ер нь зүгээр манай компани дээр ийм төслийн шинж чанартай хэд хэдэн төслийн нэгж компаниуд ийм байдлаар санхүүжилт өгөөд явж байгаа. Санхүүжилтийн хэлбэр зээлээр явдаг. Ялангуяа цаашаа нөгөө үйл ажиллагаа явуулаад өөрөө мөнгө олоод зээлээ төлнө гэдэг ийм схемээр компаниуд явж байгаа. Энэ “Монатом” болон бусад энэ төслийн компаниуд ялгаа байхгүй.

Төслийн санхүүжилтийн хувьд бид нэгдлийн хэмжээнд ТУЗ-аараа санхүүжилтийн журам гэж батлуулаад нэлээн цэгцэлж журамлаж явж байгаа. Ийм учраас тэр журмынхаа дагуу яваад үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн саад байхгүй байгаа. Энэ явдаг яг тэр санхүүжилтийнхээ ТУЗ-аас баталсан журмаар явж байгаа. Хүүгийн хувьд ч гэсэн ер нь энэ бодлогын хүү одоо 13 хувь, 12 хувьтай явж байгаа. Бид 10.9 хувийн хүүтэй зээл олгож байгаа. Ийм учраас ямар ч байсан зүгээр байгаа боломжийн хувьд санхүүжилтийн хувьд боломжийн явж байгаа гэж яг өнөөдрийн энэ шийдлийнхээ хүрээнд. Зүгээр яах вэ эднийх тэр ашиглалтын өмнөх захиргаа гээд төсвөөс санхүүжүүлэх юм нь анхнаасаа яагаад хийгдээгүй явсан юм. Ер нь зээлээр л явж байсан юм байна лээ. Тэгэхээр тэр тусдаа энэ компанийн асуудал биш болж хувирч байгаа юм.

Яг өнөөдөр Засгийн газрын тогтоол гараад манайд харьяалагдаж байгаагийнхаа хувьд харин ч үйл ажиллагаа явуулах боломжийг нь бид олгосон гэж ингэж үзэж байна. Дээр нь нэмээд тэр орон сууцтай холбоотой. Нэгдүгээр ээлжийн орон сууц дээр дутагдаж байгаа санхүүжилт энэ тэр нь харьцангуй бололцоотой байсан учраас бид Хөгжлийн банканд 8 тэрбум төгрөгийн зээлийн баталгаа гаргаж өгч байгаа шүү дээ. Тэр үлдэгдэл санхүүжилтийг нь санхүүжүүлнэ гээд.

Тэр хоёрдугаар ээлжийн орон сууц нь нэгдүгээрт одоо тэр үнийн маргаан,

хоёр талууд тохиролцоогүй ч асуудлууд ингээд хяналт шалгалт, үнэлгээ юмнууд хийгдээд явж байна. Тэгээд үнэ мөнгөний хувьд ч гэсэн нэлээдгүй дүн юм гарах байх. Тэрийг бас бид арай шийдлийг нь өөр өөр ярьж байж шийдэх ёстой болов уу л гэсэн ийм бодолтой байна.

Г.Ганболд: Түрээстэй холбоотой шийдвэрийг хэн гаргаж өгөх юм? Эднийх чинь өөрсдөө одоо нэг жоохон ашиглалтад орсон объектуудаа түрээсэлмээр байна гээд байгаа шүү дээ. Хүмүүст. Тэр шийдвэрийг нь хэн гаргаж өгөх юм? Ажлын хэсгийн 1 номер.

С.Наранцогт: Энэ байр түрээслэх асуудал чинь Г.Ганболд дарга аа, энэ нөгөө Төрийн өмчийн хорооны нэг журамтай юм байна лээ. Төрийн өмчийн хороо тодорхой орлогыг нь бас авдаг. Тэгэхээр тэр журмаараа л зохицуулагдах байх гэж бодож байгаа.

Г.Ганболд: 2 номер.

Б.Анхбаяр: Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас газрын тос боловсруулах үйлдвэр дээр бүх талаар мэргэжлийн арга зүйн чиглэл өгөөд, ингээд дэмжээд, хамтраад, асуудал бүх юмнуудыг нь ингээд сонсоод явж байгаа, гишүүн ээ. Ер нь яах вэ, бидний хувьд түрүүн Б.Тулга гишүүний уншсан танилцуулга дээр ч гэсэн дурдагдаж байсан. Техник, эдийн засгийн үндэслэлийг нь дахиж шинэчилж, батлуулах ажлуудыг хийсэн. Өдөр тутмын Сангийн яамнаас Энэтхэгийн зээлийн санхүүжилтээр олгодог тэр баталгаажуулалтынхаа асуудлыг нь бид өдөр тутам ингээд хамтраад хийгээд явж байна. Дээрээс нь Энэтхэгээс орж ирж байгаа ажилчид дээр бид бүх ажилчдынх нь 2023, 2024 оныхоо баталгаажуулалтыг нь бид Хөдөлмөрийн яамтай хамтраад Засгийн газрын хуралдаанаар оруулаад явж байна.

“Давст-31” талбайг бид Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль дээр хүртэл оруулж өгөөд явсан.

Бид яагаад үүнийг “Эрдэнэс Монгол” компани руу энэ төслийг шилжүүлсэн бэ гэхээр цаашидаа энэ компанийн санхүүжилтийн буюу өдөр тутмын үйл ажиллагааг явуулах зардал үнэхээр бид нарт яаман дээр байхгүй учраас аргагүйн эрхэнд авсан арга хэмжээ гэдгийг Та бүхэн ойлгоорой. Буцаад яаман дээр ирсэн ч гэсэн бид энэ санхүүжилтийн асуудлыг бид шийдэж чадахгүй. Тэгэхээр Та бүхэн маань бас яг энэ талаас нь нэг хараад Үйлдвэржилтийн байнгын хорооныхоо гаргасан тогтоол дээр бас нэг жоохон өөрчлөлт оруулах боломжтой болов уу л гэж хүсмээр байна. Бид хамгийн гол асуудал нь ерөөсөө л бид энэ төслийг цааши нь үйл ажиллагаагаа явуулаад өөрөө өөрсдөө зардлаа олж чаддаг болтол нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам төслийг юу гэдэг юм өдөр тутмын үйл ажиллагааг нь зардлыг нь гаргаж чадахгүй гэдэг ийм л асуудал.

Түүнээс биш яг өдөр тутмынх нь үйл ажиллагаанаас гаднах бүх асуудал дээр бид дэмжээд хамтраад, ажиллаад явж байгаа гэдгийг хэлье хэлье. “Давст-31” талбайн асуудал дээр бид Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль дээр бүр оруулаад бүтээгдэхүүн хуваах гэрээнээс гадна байдлаар энэ талбайг ганцхан газрын тос боловсруулах үйлдвэрт өөрт нь олгосон. Энэ хуулийн заалтын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэр өөрөө олон улсын тендер зарлаад өөрсдөө гаднын хөрөнгө оруулагч компаниудтай хамтраад ажиллах бүрэн боломж нь нээгдсэн байгаа. Тэр ч утгаараа газрын тос боловсруулах үйлдвэр олон улсын тендер зарласан.

Харамсалтай нь яах вэ энэ тендерт оролцох компаниуд хараахан, 56 компани оролцсон боловч яг хамтарч ажиллах компани санал ирүүлээгүй ийм асуудал болсон. Газрын тосны хайгуулын зардал маань өөрөө маш өндөр хэмжээтэй байдаг. Эрсдэлд нэлээн үүрдэг асуудал байдаг учраас үүнийг

Газрын тос боловсруулах үйлдвэр өөрсдийнхөө ажлын хүрээнд үүнийг зохион байгуулаад явах нь хамгийн зүйтэй болов уу. Энэ их хэмжээний зардлыг төсөвт суулгах нь жоохон эрсдэлтэй асуудал байдаг юм гэдгийг Та бүхэн ойлгоосой гэж хүсэж байна. Хариулж дууслаа.

Г.Ганболд: Сангийн яамны хүмүүс байна уу? Тэр 6-тай холбоотой. Бүтээн байгуулалттай холбоотой импорт оор оруулж ирэх тоног төхөөрөмжийг гаалийн нутаг дэвсгэрт түр горим байх хугацааг үйлдвэр барьж дуусах хугацаагаар зохицуулах асуудлыг шийдвэрлэх гээд. Үүнийг одоо яг хэн шийдэх ёстой юм бэ? Сангийн яам журмаар юм уу? Ажлын хэсэг 3 номер. Дараа нь Л.Баярмандал дарга тийшээ сууж байгаарай. 3 руу. Тэр сургалтын төлбөр. 3 номер.

Д.Алтанцэцэг: Гаалийн тэр түр горимын хувьд манай Гаалийн тухай хуулиараа техник, тоног төхөөрөмжийг түр горимд нэг л жил байришуулна гэж байгаа юм. Тэгэхээр төслийн бүтээн байгуулалт жишээ нь 3 жил компани нэг техникээ ашиглахад жил болгон авчирсан гар луу нь буцааж явуулаад эргүүлж оруулж ирэх ийм хуультай. Тэгээд энэ нь томоохон төсөл хэрэгжүүлж байгаа, цаг хугацаа шаардсан ажилд тохиромжгүй байгаа учраас гаалийн горимыг өөрчлөх талаар бид бараг сүүлийн 2 жил хагас, 3 жилийн хугацаанд Сангийн яамтай асууж лавлаж Гаалийн ерөнхий газартай ажиллаж байгаа.Тэгэхдээ яах вэ сүүлд Сангийн яамнаас ийм санал гаргасан. Энэтхэгийн ЭКСИМ банк, манай Сангийн яам хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээр нь Монгол Улсын олон улсын хууль юм байна.

Тэгэхээр олон улсын хуульдаа өөрчлөлт оруулах замаар одоо энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн түр горимыг

төсөл хэрэгжих хугацаагаар тооцох гэж юм оруулаад. Одоо угаасаа зээлийн ерөнхий хэлэлцээр дээр өөрчлөлт хийхээр Сангийн яам ажиллаж байгаа. Энэ юугаар л зохицуулчихъя гэсэн санал гаргаад явж байгаа.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 1 номер.

Л.Баярмандал: Би түрүүлээд Ж.Батжаргал гишүүний асуусан асуултад нэмээд жоохон тайлбар хэлчихье. Тэгэхээр өнөөдөр бүтээгдэхүүн хуваах гэрээгээр Монгол Улсаас нэг ч төгрөг гардаггүй. Зардалд. Одоо өдөрт тэрбум орчим төгрөг Монгол Улсын төсөвт орж байгаа. Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээний нөгөө Монголын талын ногдох хувь нь. Энэ жил Сангийн яамнаас манайд 414.0 тэрбум төгрөгийн орлого олох ийм үүрэгтэй ажиллаж байгаа. Дээрээс нь 700-аад монгол ажилчид тэнд ажиллаж байгаа. Мөн хангамжийн нэлээн том. Зөвхөн нэг жишээ хэлэхэд Дорнодын цахилгаан станцаас жилд 8 сая орчим долларын цахилгаан авч хэрэглэдэг. Хамгийн гол хэрэглэгч гэх мэтээр. Сургалтын асуудал дээр хэлэхэд энэ жил яагаад болохгүй юм бэ гэж байна. Хавраас эхлээд энэ сургалтын сангуудыг шалгаж эхэлсэн. Тэгээд Авлигатай тэмцэх газраас одоо шалгалт үргэлжилж байгаа учраас одоогоор тийм шинэ хүүхдүүдэд мөнгө гаргаагүй байж байгаа. Тийм.Тэгээд энэ асуудал шийдэгдчихвэл бэлэн байгаа.

Г.Ганболд: Тэр тэгээд Засгийн газрын журам юм уу, танай яамны журам юм уу?

Л.Баярмандал: Энэ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд хоёрын хамтарсан журам байгаа. Тэгээд үүнийг л манайх хэрэгжүүлж явдаг. Түүнээс манайх өөрсдөө тийм журам гаргадаггүй л дээ. Хоёр сайдын хамтарсан журам.

Г.Ганболд: Гишүүд асуулт асууж, уг хэлж дууслаа. Уг нь энэ их чухал тогтоол юм билээ. Бүх заалтуудыг нь үзэхэд. Одоо энэ дээр ерөөсөө аль нэгэн яам, төрийн өмчийн газар нэгэн рүүгээ чихэхгүй бүх талаасаа дэмжиж үүнийг явуулах чиглэлээр их чухал заалт байгаа юм. Тэгэхээр энэ дээр уг нь одоо яг өнөөдрийн байдлаар энэ хэрэгжсэн заалт ер нь бараг алга даа. 7 заалтаас сая тэр б дээр нь олон улсын гэрээн дээрээ нэг оруулъя гэж Сангийн яам ярьсан юм болов уу даа бодвол. Түүнээс бусад нь хэрэгжүүгүй байна. Тийм учраас бид хугацаатай дахиад л 01 сарын 17-нд чуулган завсарлахаас өмнө дахиж хэлэлцэнэ. Тэр хүрээнд Л.Баярмандал дарга та наад журмаа сайд руугаа оруулчих л даа. Чухал асуудал шүү дээ. Хэдэн хүүхдийн. Тийм. Ойрын үед болж өгвөл Та сарын бид нарт дахиж хэлэлцэхээс өмнө наад нэг журмаа оруулаад тэр хэдэн хүүхдүүдийн сургалтын төлбөрийг нь төлөөд. Энэ чинь боловсон хүчнээ бэлдэх нь. Энэ чинь саалиа бэлдэхээр саваа бэлд гээд энэ чинь чухал шүү дээ. Үүнийг нэгдүгээр шийдэх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь, тэр түрээслэх, өмнөх байр түрээслэх асуудал тэр Төрийн өмчийн хорооны журам байгаа юм бол тэрийг хэн нэгэн хүнээс заавал асуух, зөвшөөрөл авах шаардлагагүй л юм байна шүү дээ. Тэр журмынх нь дагуу. Бодвол журамд нь нэг тариф байдаг санагдаж байна. 1 метр квадратын. Тийм ээ. Тэр тарифаас нь доош оруулчихгүй явчих юм бол дээшээ хэд ч байсан байж болох байлгүй дээ. Тэгэхээр тэр шийдвэрийг нь ойрын үед тэгээд тэр журмыг нь харж байгаад өөрсдөө шийдвэр гаргаад явчхаж болох юм байна даа. Өөрсдөө гаргаад яв. С.Наранцогт захиралд л би бас одоо ингээд. Та өөрөө бас ажил дээрээ байхыг үгүйсгэхгүй. Доод талын гарын үсэг дээр л хүндрэл гардаг гэдгийг бүх төслийн хүмүүс яриад байгаа юм. Тэгэхээр нэгэнт жилийнх нь төсвөөр. Нэгэнт л зээл юм бол. Банкнаас зээл авахаар чинь тэр цалингаа бүгдийг

нь бичээд ир. Тэгэхээр нь өгье гэдэггүй биз дээ. Тэгэхээр чинь графикийг нь гаргаад л сар сараар нь. Нэгэнт зээл юм чинь өгөөд л. Тэднийх тэрийгээ юундаа зарцуулна уу, тэр надад зүгээр сонин биш юм шиг байх юм. Түүнээс зээл шүү дээ, энэ чинь. Нэгэнт зээл юм бол сарын хуваарь график гаргаад ингээд өгөөд явчих тал дээр та нэг анхаараач ээ. С.Наранцогт захирал аа. Тэгээд энэ чинь бас л цаанаа нэг ажил хийх гэж байгаа аж ахуйн нэгж дээр бас л хүндрэлтэй л байгаа юм билээ. Тэгэхээр энэ дээр одоо нэгэнт үйлдвэр ашиглалтад ороод явахаар зэрэг энэ түүхий эдийн асуудал чухал.

Түүхий эдийн баахан цооног хийж байна. Тэр цооногоор татаж авах түүхий эдийг чинь хүрэлцээ хангамж. Одоо саяхан бидний авсан мэдээллээр энэ “Петро Чайна”-гийн чинь олборлолт нь жил ирэх тусам буурсаар байгаад одоо бараг 500 мянга руу орж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Бид чинь 1.2 сая. Цаашилаад нэмэгдэх ийм хэмжээний түүхий эд боловсруулах үйлдвэр барьж байдаг. Гэтэл бүтээгдэхүүнээ хуваалаа хуваалаа гэхэд одоогийн олборлолтоор нь ярих юм бол 200 гаруйхан мянган тонн магадгүй. Тэгээд ийм хэмжээнд байгаа үед байна шүү дээ танайх өөрөө мөнгө гаргаж чадахгүйг чинь ойлгож байна. 2024 оны улсын төсөв дээр жишээлэх юм бол танайхаас ямар ч санал орж ирээгүй. Одоо энэ нөхцөлд хэрэв улсын төсөв дээр танай яам хайгуул дээр 5 төгрөг тавиад орж ирэх юм бол энэ удаагийн парламентад байгаа гишүүд бүгд хоёр гараа өргөөд дэмжихэд бэлэн байгаа шүү дээ. Бас ч гэж улсын төсөв чинь гайгүй тэлчихсэн. Тав, гурван төгрөгийн санал орж ирээд хайгуулын ажил хиймээр байна. Тэр битгий хэл энэ газрын тосны дөнгөж хөл дээрээ тогтож байгаа компанийг үйл ажиллагааны санхүүжилт төсөв дээр орж ирэхэд ер нь төсөв дээр Их Хурал дэмжихэд бэлэн байгаа шүү дээ. Ганц л нэг цэцэрлэг барих хэмжээний л мөнгө шүү дээ.

Тэгэхээр зэрэг үүнийг заавал ингээд эхнээс нь үйл ажиллагаа явуулаагүй байхад нь хүүтэй зээлээр. Тийм төрийн бодлого байж болохгүй байхгүй юу. Тийм ээ. Хүүтэй зээлээр. Одоо хэзээ ойрхон ашиглалтад орох нь тодорхойгүй. Тэгээд хүү бодогдоод явж байх. Энэ чинь ашиглалтын өмнөх хиргааг нь төр өөрөө төсвөөс санхүүжүүлээд явахад ерөөсөө болохгүй юм байхгүй шүү дээ. Тэгээд энэ дээр нэгэнт бодлого барих гэж байгаа юм бол яагаад тэр 01 дүгээр тогтоолоор эзэнтэй болго гээд байгаа юм гэхээр зэрэг үнэхээр харьяаллын яам байх юм бол тэр яам нь өөрийнхөө төсөв дээр, 2024 оны төсөв, 2025 оны төсөвтөө тусгаж орж ирээд суулгачих ёстой байхгүй юу. Тэгээд эзэнгүй байгаад байгаагийн чинь нэг утга учир нь тэр.

Одоо С.Наранцогт захиралд буруу байхгүй. Аргаа бараад л танайх л чирээд яв л гэж л өгсөн юм байна лээ. Яагаад гэхээр энэ чинь салбарын яамгүйдээ л ингээд яваад байгаа байхгүй юу. Салбарын яам байсан бол энэ битгий хэл өчнөөн төсөл, арга хэмжээнүүдийг. Улаанбаатар хот чинь өмнө нь дүүжин мүүжин, есөн жорын төслүүдийн өмнөх захиргааны зардлууд гэж замбараагүй олон мөнгө гараад явсан тохиолдлууд зөндөө байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр танай яам нэгэнт Засгийн газрын тэр гаргасан 82 дугаар тогтоолоор бодлого, үйл ажиллагааг нь авч явах нь танай дээр үүрэг чиглэл нь байгаа юм бол төсөв дээр ч гэсэн анхаарах ёстой. Ингэж тал талаасаа явж байж үүнийг нэг жоохон оруулахгүй бол бүгд зугтаагаад, тэгээд бодлогоо нгидаж чадахгүй яваад байх юм бол энэ мөд орохгүй шүү. Ордог юм гэхэд түүхий эдгүй болно шүү. Үүнийг л гишүүд анхааруулаад байгаа шүү дээ. Тэгээд энэ асуудал дээр бодлогын яам, Уул уурхайн яам энэ бензин түлш оруулж ирье гэж өдөр шөнөгүй нийгэмтэй хэрэлдэхийн чинь эхлэлийг үүнээс эхэлж эхэлж бид таслан зогсооно шүү дээ.

Тэгээд том бодлого ярих гэж байгаа бол эхлээд том юмаа ярих ёстой байхгүй юу. Тэгээд бид хойноос нэг оруулж ирэх тухай юм ярих биш. Үүнийгээ хаанаас яаж нөөцөө бүрдүүлэх вэ гэдэг дээр тал талдаа анхаарч энэ нэг газрын тосны компанийг жоохон дэмжиж ингэж явах ёстой юм байна лээ. Би өмнө нь Т.Энхтүвшин даргаас мэдээлэл авч байсан. Сүүлд зүгээр яах вэ өгсөн материал дээрээс нь танилцаж үзэхэд бид зайлиггүй үүнийг хийх ёстой юм байна. Тэгэхээр энэ чиглэлээр бид дахиад нэг сонсьё. Тэр хүрээнд С.Наранцогт захирал тэр санхүүжилтийнх нь журмыг Та нэг эргэж харахыг бодоорой. Уул уурхайн яамныхан тэр нэг журмаа оруулаад тэр хэдэн хүүхдийн сургалтын төлбөрийг нь өгөөдхөөрэй. Бас Уул уурхайн яам мэргэжлийн төсөв дээр оруулах тал дээр бодлогоо нэг зангидаад. Ер нь одоо ингээд л энэ чинь дөнгөж он гараад л 4 сар гээд л төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл гээд л явна шүү дээ. Тийм ээ. Тэндээс эхлээд Уул уурхайн яам ямар ч гэсэн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд энэ компанийн санхүүжилтийн талаар тодорхой юмнууд тусгаж орж ирэх дээр анхаараарай гэдгийг хэлж байна.

Ингээд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 03, 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонслоо. Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

14.39 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ